

Гарчиг

ii.	Хураангуй	2
iii.	Тогтвортой хөгжлийн төлөвлөгөө ба/буюу бодлогын хүрээнд боловсруулсан стратеги, ач холбогдлын зэрэглэл	11
	3.1. Нийгэм-эдийн засгийн бусад хүрээнд боловсруулсан үндэсний төлөвлөгөө, стратеги.....	11
	3.2. НҮБ-ын ЦТК-ийн ҮҮАХ-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн цөлжилттэй тэмцэх хүрээнд боловсруулагдсан үндэсний төлөвлөгөө буюу стратеги	12
iv.	Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор авсан бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ	14
	4.1. ҮҮАХ-үүд нь Үндэсний Нийгэм-Эдийн засгийн Хөгжил ба Байгаль Хамгааллын Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох нь	14
	4.2. Бүсийн, Дэд Бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй бий болсон харилцаа холбоо	19
	4.3. Үндэсний зохицуулах байгууллага, түүний үйл ажиллагаа.....	20
	4.4. Цөлжилтийн хяналтын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохион байгуулалтын цар хүрээ.....	26
	4.5. Хууль эрхзүй, зохицуулалтын уялдаа холбоо, үйл ажиллагааны цар хүрээ	28
v.	Үндэсний Үйл Ажиллагааны Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо, ялангуяа иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, иргэдэд түшиглэсэн байгууллагуудын оролцооны явц	32
	5.1. Үндэсний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын идэвхитэй оролцоо	32
vi.	ҮҮАХ-ыг боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөлдөөний үйл явц ба хөгжингүй орон-талууд, сонирхлын бүлэг бусад байгууллагатай байгуулсан түншлэлийн гэрээ, ялангуяа орон нутгийн болон олон улсын нөөцийг татах, зохицуулахад.....	40
	6.1. Хамтран ажиллагч олон улсын байгууллагуудын үр ашигтай дэмжлэг туслалцаа	40
vii.	Ган цөлжилтийн мониторинг хийх, үнэлгээ өгөх зорилгоор цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-ийн хүрээнд түүний дотор эдийн засгийн орчныг сайжруулах, байгалийн баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, цөлжилт, түүнд хяналт тавих мэдлэгийг дээшлүүлэх талаар төлөвлөсөн болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	47
	7.1. Өмнөх туршлагад хийсэн дүн шинжилгээ	47
	7.2. Цөлжилттэй тэмцэх чиглэлд боловсруулсан техник хөтөлбөр ба үйл ажиллагааны цогц төслүүд	48
	7.3. Конвенцид тусгагдсан тэргүүлэх чиглэлд нийцсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	51
	7.4. Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн	52
viii.	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжин үндэсний төсвөөс хуваарилсан санхүүжилтын хэмжээ, хэрэгцээ шаардлага хийгээд эдийн засаг, техник хамтын ажиллагаа, чиглэл, ач холбогдлын зэрэглэл.....	53
	8.1. Бүрдүүлсэн санхүүгийн механизм.....	53
	8.2. ҮҮАХ-ийн санхүүжилт	57
	8.3. Техник хамтын аажиллагааны хөгжил	59
ix.	Хэрэгжилтийн явцыг тодорхойлох, үнэлэхэд хэрэглэгдэх шалгуур үзүүлэлтүүдийн талаарх тойм	60
	9.1. Үнэлгээ өгөх болон хянах үйл ажиллагааны механизм	60
x.	ТБХ.5/10-ын шийдвэрийн дагуу шинээр танилцуулах үзүүлэлтүүд	65
	10.1. Цөлжилтийг хянах шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа	65
	10.2. Шинжлэх ухаан, технологийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	68

ii. Хураангуй

1. Цөлжилттэй тэмцэх конвенцийн үндэсний зохицуулагч

Зохицуулагч
Dr.Цэсэдийн Банзрагч Хүрээлэн байгаа орчин Байгалийн нөөцийн газрын дарга
Хаяг, и-мэйл:
Засгийн Газрын 3-р байр Бага тойруу – 44 Улаанбаатар – 210620А Монгол Улс e-mail: mne@mongol.net
Цөлжилттэй холбоотой тухайн орны вэб-сайт байгаа эсэх
www.mne.mn

2. Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай

ЦТҮХөтөлбөр баталсан хугацаа
<p>Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 7 сарын 169 дүгээр тогтоолоор ЦТҮндэсний Хөтөлбөрийг анхлан баталсан. Үүнээс хойш 2003 оны 141 дүгээр тогтоолоор Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталсан.</p> <p>Энэхүү шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулахад БОЯ, Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо, түүнд харъяалагдах холбогдох яамд, эрдэм шинжилгээний байгууллага, ТББ-ын төлөөлөл оролцсон болно.</p> <p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааг 3 үе шаттайгаар тодорхойлсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- 1-р үе шат (2003-2007): Цөлжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч цөлжилтийг бууруулах эрхзүйн зохион байгуулалтын үндсийг сайжруулж цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх, түүнд дасан зохицох бэлтгэлийг хангахад чиглэгдсэн цогц асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх- 2-р үе шат (2008-2011): Цөлжилтийн үйл явцад мониторинг хийх дасан зохицох чадавхийг бэхжүүлэх, цөлжилтөнд хүчтэй өртөж буй эмзэг бүс нутгийн доройтсон орчинг нөхөн сэргээх замаар цөлжилтийн эрч хүчийг сааруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх- 3-р үе шат (2012 оноос хойш): Цөлжилтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга механизмыг бүрэн ашиглаж, цөлжилтөнд дасан зохицох бодлогын үр шимийг хүртэх.

Шинэчилсэн хугацаа
2003 оны 141 дүгээр тогтоол
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр Ядуурлыг бууруулах үндэсний стратеги баримт бичигт тусгалаа олсон уу?
<p>Үгүй</p> <p>Үндэсний хөтөлбөрийн зорилтод зааснаар цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон холбогдох талуудын оролцоог нэмэгдүүлнэ хэмээн заасан байна. Энэ үндсэн дээр Үндэсний хөтөлбөрт цөлжилттэй тэмцэх төв, орон нутгийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, сургалт сурталчилгаа хийх, цөлжилтөнд нэрвэгдсэн бүс нутаг, орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон нийтийг татан оролцуулах урамшууллын тогтолцоог бүрдүүлэх гэсэн үйл ажиллагааг тусгаж өгсөн билээ. Энэ үндсэн дээр цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны нэг бүлэг хэсэг нь цөлжилтөнд нэрвэгдсэн нутгуудын ард иргэдэд мод, сөөг тарималжуулах замаар орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох ажлыг хөхүүлэн дэмжиж ирлээ.</p>
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр Үндэсний хөгжлийн стратеги баримт бичигт тусгагдсан уу?
<p>2002 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, ТХГН-ийн үндэсний хөтөлбөр, Ойн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн 17 зорилт, арга хэмжээг, 2003 оны үндсэн чиглэлд Тогтвортой хөгжлийн асуудлаархи дэлхийн дээд хэмжээний уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ болон Усны үндэсний хөтөлбөр, ТХГН-ийн үндэсний хөтөлбөр, Ойн үндэсний хөтөлбөр, Бүх нийтийн экологийн боловсролын үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд тусгагдсан болно.</p> <p>Цаашид хөтөлбөрийн зорилтыг хангах зорилгоор экологийн тэнцвэрт байдлыг хангах байгаль орчин ба хөгжлийн талаар баримтлах дунд хугацааны бодлогын чиглэл, Монгол Улсын 2021 он хүртэлх үндэсний хөгжлийн хөтөлбөрийн “Байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгаалал” бүлэг зэрэг бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.</p>
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр хамтын ажиллагааны гэрээний зөвшөөрлийн дагуу хэрэгжиж эхэлсэн эсэх
Тийм
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан хугацаа
<p>2003 он</p> <p>Шинэчлэн боловсруулсан Үндэсний хөтөлбөр нь богино, дунд, урт хугацааны хэмээн заагдсан бөгөөд дараахь байдлаар төлөвлөгдсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Богино (2003-2007) - Дунд (2008-2011) - Урт (2012 оноос хойш)
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн эцсийн хувилбар байгаа эсэх

Байгаа
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг одоогоор хийж байгаа эсэх
Үгүй
Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах зааварчилгаа байгаа эсэх
Байгаа
Үйл ажиллагаа дөнгөж санаачлагдсан байгаа
Үгүй Үндэсний хөтөлбөрт заагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөнд заагдсан үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байгаа.
Үйл ажиллагааг эхлүүлээгүй байгаа
Үгүй

3. Бүсийн болон дэд бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрийн гишүүн эсэх

Бүсийн болон дэд бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрийн гишүүн эсэх
Монгол Улс нь бүсийн болон дэд бүсийн хамтын ажиллагааны дараахь байгууллага хөтөлбөрүүдэд оролцож ирсэн. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Азийн бүсийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Гангийн нөлөөг бууруулах, цөлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх” сэдэвчилсэн хөтөлбөрийг Монгол Улс хариуцан гүйцэтгэж байна. 2. Зүүн хойд Азийн байгаль орчны хамтын ажиллагааны хүрээнд “Зүүн Хойд Азийн газар ашиглалт, бүрхэвчийн өөрчлөлт” төсөлд оролцож байна. 3. Зүүн Хойт Азийн Цөлжилттэй тэмцэх нийгэмлэгийн (ТББ-ын) хүрээнд Монгол оронд цөлжилтийг сааруулах Улаанбаатар хотын агаарын бохирдлыг арилгах жижиг төсөл хэрэгжиж буй

4. Үндэсний зохицуулах хорооны бүтэц (Засгийн газрын болон иргэний нийгэмлэгийн байгууллага эсэх, төлөөлж буй байгууллагын хүний хүйсийг заах)

Байгууллагын нэр	Засгийн газар	Төрийн бус байгууллага	Эмэгтэй/эрэгтэй
БОЯ	√		эрэгтэй
Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам	√		
Нийгэм, Хөдөлмөр Хамгааллын Яам	√		
Санхүү, эдийн засгийн Яам	√		
Газрын Харилцаа, Геодези, Зурагзүйн Газар	√		
Боловсрол Соёл Шинжлэх	√		

Ухааны Яам			
Шинжлэх Ухааны Академи		√	эрэгтэй

5. Үйл ажиллагаанд оролцогч төрийн бус байгууллагуудын тоо

Цөлжилтийн үндэсний зохицуулах хороо ТББ байгуулагдсан эсэх. Хэрэв тийм бол хичнээн ТББ болон иргэний нийгэмлэг оролцсон бэ?
Байгуулагдсан. 5

6. Цөлжилттэй тэмцэх үндэсний конвенцийн тухай нийт хичнээн хууль тогтоол байдаг вэ?

Хуулиудын нэрс	Батлагдсан он, сар, өдөр	Мөрдөж эхэлсэн он, сар, өдөр
Газрын тухай (1994 оны хууль шинэчлэн найруулсан)	2002.06.07	2003.01.01
Байгаль орчныг хамгаалах тухай	1995.03.30	2003.01.02
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай	1994.11.15	2003.01.02
Усны тухай	1995.04.13	2003.01.02
Ойн тухай	1995.03.31	2003.01.02
Ургамал хамгааллын тухай	1996.03.22	2002.11.28
Ашигт малтмалын тухай	1997.06.05	2003.01.02

7. Зөвлөлдөх үйл ажиллагаа

Number of partnership agreements that have been concluded and/or are being initiated within the framework of the UNCCD (please provide information where appropriate):

- НҮБ-ын ЦТК-ийн хүрээнд байгуулсан ба/буюу санаачилсан хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн тоо (шаардлагатай хэсгүүдэд мэдээллийг өгнө үү)

Ямар улс	Агуулга	Эрх зүйн баримт бичгийн төрөл	Байгуулсан огноо	Хүчинтэй хугацаа
Солонгос	Монгол улсын Байгаль орчны яам, Бүгд Найрамдах Солонгос улсын Байгаль орчны яам хоорондын байгаль орчны хамтын ажиллагааны тохиролцоо	тохиролцоо	2000-09-04	5 жилээр сунгагдана
Герман	Герман улсын Крефельд хотын амьтны хүрээлэн, МУ-ын Говийн их дархан газар хоорондын хамтран ажиллах гэрээ	гэрээ	-	-
АНУ	АНУ-ын NASA болон МУ-ын БОЯ-ны Зайнаас тандан судлах төвд тоног төхөөрөмж шилжүүлэх гэрээ	гэрээ		-
Франц	МУ-ын БО сайд, БНФранц улсын хүрээлэн байгаа орчны сайд нарын хооронд байгаль орчны салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй	тохиролцоо	1997-03-24	-

	холбогдуулан байгуулсан тохиролцоо			
Иран	Байгаль орчны сайд Ц.Адъяасүрэн, Исламийн Бүгд Найрамдах Иран улсын Зам, тээврийн нэгдүгээр орлогч сайд А.М.Ноориан нарын хооронд Азийн цаг уурын бүсийн нийгэмлэгийн 11 дүгээр хуралдааны үеэр ярьж тохирсон асуудлуудын талаархи харилцан ойлголцсон тухай санамж бичиг	санамж бичиг	1996-10-03	-
ОХУ	МУ-ын БОЯ, ОХУ-ын Ойн аж ахуйн алба хоорондын ойн аж ахуйн чиглэлээр хамтарч ажиллах хэлэлцээр	хэлэлцээр	1995-04-05	5 жилээр сунгагдана
Хятад	Монгол улсын БОЯ-ны Ойн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Х.Ыханбай, БНХАУ-ын Хей Лун Жан мужийн Мингкун компанийн ТУЗ-ийн дарга Вү Шен Ли нарын хооронд Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ургамалын бэхжүүлэгч Дразил бодисыг турших талаар хамтран ажиллах тохиролцоо	тохиролцоо	2005-04-29	-

- ЦТК-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхтэй холбогдож хийгдсэн зөвлөлдөх уулзалтын тоо (шаардлагатай хэсгүүдэд мэдээллийг өгнө үү)

Д/д	Үйл ажиллганы нэр	Зохион байгуулсан хугацаа	Оролцсон хүний тоо	үргэлжил-сэн хугацаа	Санхүүжүүлсэн байгууллага
А.СУРГАЛТ СЕМИНАР					
1.	Ойн талаар болон зах зээлийн мэдээллийг солилцох чадамжийг сайжруулах	2005.10.24.10.28	1	5 өдөр	НҮБ
2.	Хил дамнасан байгаль орчны нөлөөллийг үнэлэх нь	2005.10.17-10.21	6	5 өдөр	
3.	Байгаль хамгаалагчдын чадавхийг дээшлүүлэх нь	8 дугаар сарын 1-6 өдрүүдэд Булган аймгийн Тэшиг, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумд	38 хүн	6 өдөр	БХМТС
4.	“ Байгалийн баялгийг даацын хэмжээнд зохистой ашиглах нь” сэдэв семинар	11 сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо	50 хүн	2 өдөр	БХМТС
5.	Бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн сургалт	4 сарын 15-17, 9 сарын 4-6	125	5	НЭБНТМ төсөл

	\ 5 хамтлагт \, Хотонт сум				
6.	Бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн сургалт \ 4 хамтлагт \, Лүн сум	9 сарын 15-19	80	4	НЭБНТМ төсөл
7.	Бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн сургалт \ 7 хамтлагт \, Дэлүүн сум	9 сарын 22-29	245	7	НЭБНТМ Төсөл
8.	Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежментийн сургалт <i>/төслийн судлаачдын дунд/</i>	1 сарын 22	30	1	НЭБНТМ төсөл
9.	GPS (ЖиПиЭс)-ийн сургалт Сумын хамтын менежментийн багийн Мэдээлэлийн сангийн ажилтанд зориулсан сургалт	3 сарын 11-13	10	3	НЭБНТМ төсөл
10.	БНМ-ийн тоон болон чанарын сургалт	5 сарын 30-31	25	2	НЭБНТМ төсөл
11.	Боловсролын салбарт экологийн сургалтын чиглэлээр баримталж буй бодлого	2005.06.05- 2005.06.08	15	3 өдөр	ГТХАН
12.	"Хамтын эзэмшлийн хамтлагуудад зориулсан ойд явуулах арчилгааны огтлолт" үзүүлэх сургалт	2005.07.25- 2005.07.30	71	6 өдөр	ГТХАН
13.	үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдэд зориулсан үзүүлэх сургалт	2005.08.18- 2005.08.21	88	4 өдөр	ГТХАН
14.	Байгаль Орчны хяналтын менежментийн чадавхийг сайжруулах төслийн семинар	2005.11.30- 2005.12.01			ГТХАН
15.	"Нутгийн өөрөө удирдах ёс ба байгалийн нөөцийн менежмент" семинар - Дарханд	2005.04.12- 13	36	2 өдөр	ГТХАН
16.	"Ойн мэргэжлийн ажилтан бэлтгэх хөтөлбөр боловсруулах" семинар / 2 удаа/	2005-06-23-27	16	5өдөр	ГТХАН
17.	Говийн мод, модлог ургамлыг тарьж ургуулах сургалт	2005 оны 6, 10 сард	30	2 өдөр	Их говь төсөл
18.	ГМС (GIS) анхан шатны сургалт	2005 оны 12 сард	15	2 өдөр	Их говь төсөл

В.ХУРАЛ ЗӨВЛӨЛГӨӨН					
1.	Европ болон Хойд Азийн орнуудын ойн засаглал болон хуулийн хэрэгжилт	2005.6.6-6.8	1	3 өдөр	НҮБ БОХ
2.	“Ази номхон далайн бүсийн 13 дахь конгресс, Эко Ази 2005	2005.6.4-6.5	1	1 өдөр	НҮБ БОХ
3.	Дэлхийн Байгаль орчны сайд нарын дээд хэмжээний уулзалт	2005.2.21-2.26	2	6 өдөр	НҮБ БОХ
4.	“Хүрээлэн буй орчин ба худалдаа Ази номхон далайн бүсийн орнуудын эдийн засагт”	2005.6.14-6.16	2	3 өдөр	НҮБ
5.	Тогтвортой хөгжлийг хангахад орон нутгийн өөрөө удирдах засаглалын үүрэг хариуцлага	2005.11.14-11.18	1	5 өдөр	НҮБ
6.	НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн талуудын бага хурлын 7 дугаар уулзалт	2005.10.17-10.28	1	11 өдөр	НҮБ БОХ
7.	Зүүн хойд Азийн бүсийн орнуудын Байгаль орчны мэргэжилтнүүдийн 11 дүгээр уулзалт	2005.10.26-10.27	1	2 өдөр	НҮБ БОХ
8.	Монгол-Хятад Улс хооронд Хилийн усны хамтарсан комиссын 2 дугаар хуралдаан	2005.12.14-12.19	6	6 өдөр	Засгийн газар

Chef de file үүргийг гүйцэтгэсэн орны нэр (шаардлагатай хэсгүүдэд мэдээллийг өгнө үү)

Япон Улс, БНСУ

8. Цөлжилттэй тэмцэх конвенцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд шууд болон шууд бусаар холбогдох 10 хүртэлх төслийн нэрийг бичнэ үү.

Д / д	Төслийн нэр	Төсөл нь Үндэсний/Дэд бүсийн/Бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн эсэх?	Төслийн хамрах хүрээ	Хугацаа	Оролцсон талууд	Нийт төсөв, мян.ам.дол
1	Зүүн Хойд Азид шороон шуургуанаас сэргийлэх, хянах бүс нутгийн мастер төлөвлөгөө **	Бүсийн	Шороон шуурганы мониторинг	2003-2005	Азийн хөгжлийн банк, Японы ЗГ, Даян Дэлхийн Байгаль	1000.0

					Хамгаалах Сан	
2	Дорнод Монголын Биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой амьжиргааны арга замыг боловсруулах *	Үндэсний	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой амьжиргааг дэмжих	1998-2005	ДДБОС НҮБХХ	6174.0
3	Их Говийн Экосистем, түүний шүхэр зүйлийг хамгаалах *	Үндэсний	Биологийн төрөл зүйлийг хамгаалах	2000/2003-2007	ДДБОС НҮБХХ	25.0 / 979.0
4	Бэлчээрийн менежментийг сайжруулах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээ *	Үндэсний	Цөлжилттэй тэмцэх	2000-2003	GTZ	580.0
5	Азид Цөлжилттэй тэмцэх *	Бүсийн	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2000-	АХБ ЦТК-ийн НБДНГ	450.0
6	Хөдөөгийн Ядуурлыг бууруулах төсөл *	Үндэсний	Цөлжилттэй тэмцэх, ядуурлыг бууруулах	2003-2010	IFAD МУЗГ	19700.0
7	Бэлчээрийн тогтвортой менежмент *	Үндэсний	Цөлжилтийн сааруулах	2002-2007	НҮБ-ын ХХ Нидерландын ЗГ	3300.0
8	Монголыг Ногооруулья **	Үндэсний	Бэлчээрийн доройтол, цөлжилтөнд өртсөн бүс нутгуудыг нөхөн сэргээх	2004-2009	Олон Улсын Ротари байгууллага МУ-ын Засгийн газар	100.0
9	Газрыг зүй зохистой ашиглаж цөлжилттэй тэмцэх **	Үндэсний	Цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх	2006-2009	Даян Дэлхийн Байгаль орчны сан	PDF
10	Байгалийн нөөцийн менежментийн үндэсний гео-мэдээллийн төв **	Үндэсний	Байгаль орчны нөөцийн талаархи мэдээллийн метасанг бий болгох	2006-2010	Голландын Засгийн Газар МУ-ын Засгийн газар	330.0
11	Монголын бэлчээр – ногоон алт **	Үндэсний	Цөлжилттэй тэмцэх	2004-2007	Швецарийн хөгжил хамтын ажиллагааны агентлагаа	6600.0

					с	
1 2	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хамтын оролцоотойгоор цөлжилттэй тэмцэх, доройтсон орчинг ургамалжуулах, усжуулах	Орон нутгийн	Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх	2003- 2005	НҮБ-ын ЦТК НБДНГ	50.0

“ Монгол Улсын эдийн засаг экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” тайлан

** БОЯ-ны Гадаад Хамтын Ажиллагааны хэлтэс зэрэг эх үүсвэрээс авав.

iii. Тогтвортой хөгжлийн төлөвлөгөө ба/буюу бодлогын хүрээнд боловсруулсан стратеги, ач холбогдлын зэрэглэл

National plans and strategies available in other social and economic areas	
3.1. Нийгэм-эдийн засгийн бусад хүрээнд боловсруулсан үндэсний төлөвлөгөө, стратеги	
<p>To what extent have the strategies and priorities established within the framework of sustainable development taken into consideration the efforts to formulate a NAP or aspects of already completed NAPs?</p> <p>Үндэсний Хөтөлбөрийг боловсруулах буюу боловсруулагдсан хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлоход тогтвортой хөгжлийн хүрээнд боловсруулагдсан стратеги, тэргүүлэх ач холбогдлууд хэрхэн тусгагдсан бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - МУ-ын Засгийн газар 2003 онд economic growth support poverty reduction strategy баримт бичиг боловсруулан ажилласан. Энэ нь ядуурлыг бууруулах үндсэн үйл ажиллагааг макро-эдийн засгийн секторт ойртуулан ажлын байр, хөдөөгийн хөгжлийг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Үүнээс гадна энэхүү хөтөлбөр нь хувийн секторыг илүү хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна. - Нийгмийн аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг МУ-ын ЗГ Азийн хөгжлийн банкны техник тусламжийн хүрээнд баталсан бөгөөд энэ нь ядуурлыг бууруулах, хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн. Мастер төлөвлөгөөний хүрээнд Тогтвортой амьжиргаа (ДБ), Нийгмийн Аюулгүй байдлын хөгжил (АХБ) зэрэг хэд хэдэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээд байна. - Үндэсний Хөгжил ба Үндэсний Аюулгүй Байдлын Зарчим баримт бичигт экологийн аюулгүй байдлыг хангах талаар заалт оруулан Засгийн Газраар 1994 онд баталсан бөгөөд өнөөг хүртэл энэхүү баримт бичиг тулгуурлан үйл ажиллагааг явуулж байна. - Монгол Улсын Экологийн талаар баримтлах бодлого (1997) байгаль хамгаалал ба тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нийцүүлэн үндэсний хөгжлийн стратегитай уялдуулан ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрт багтаасан байгаль хамгааллын үндсэн баримт бичиг бөгөөд энэхүү баримт бичигт цөлжилттэй тэмцэх, газрын доройтол, хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах асуудлыг экологийн нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал болгон тавьсан. - 2021 он хүртэлх Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Үндэсний тогтвортой хөгжлийн стратеги баримт бичгийг баталсан бөгөөд энд цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх талаар дурьджээ. - Мянганы хөгжлийн төлөвлөгөө баримт бичгийн Монгол улсын Засгийн Газар 2003 онд баталж энэхүү стратеги бичгийн байгаль орчны талаар авч хэрэгжүүлэх бодлого чиглэлд цөлжилт, газрын доройтолд өртсөн талбайг 25 хувь хүртэл бууруулна хэмээн заажээ. - Бүх нийтийн экологийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг МУ-ын Засгийн газар, БОЯ, БСШУЯ-тай хамтран боловсруулж 2004 онд батлан хэлэцүүлсэн

	<p>болно. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумдын хэмжээнд экологийн боловсролын төв байгуулах ажлыг эхлүүлээд байна.</p>
<p>What working relationships have been established between the NFP and/or NCB and those Ministries dealing with the implementation of such strategies?</p> <p>ҮЗ ба/буюу ҮЗХ-ноос эдгээр стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Яамдуудтай ажлын ямар холбоо тогтоогдсон бэ?</p>	<p>Дээрхи хөтөлбөр, стратеги бичиг баримтанд заагдсан цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг нэгдмэл цогц хэлбэрээр авч хэрэгжүүлэх зорилгоор СЭЗЯ, НХХЯ, ҮХЯ, БСШУЯ зэрэг засгийн газрын байгууллагуудын төлөөллийг ҮЗХ-нд оролцуулах ажлыг ҮЗ өөрийн мэдлийн хүрээнд бүрдүүлэн ажилласан. ҮҮАХ-ийн зорилтуудыг биелүүлэх шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж тухайн яам, эрдэм шинжилгээний байгууллага, ТББ-ын үүрэг хариуцлагыг хуваарилан тухай бүр үйл ажиллагааны биелэлтийн тайланг хүлээн авах, мэдээлэл солилцох ажлыг ҮЗХ-ны Нарийн бичгийн даргаар дамжуулан гүйцэтгэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.</p>
<p align="center">National plans or strategies in the field of combating desertification developed prior to the UNCCD NAP</p> <p align="center">3.2. НҮБ-ын ЦТК-ийн ҮҮАХ-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн цөлжилттэй тэмцэх хүрээнд боловсруулагдсан үндэсний төлөвлөгөө буюу стратеги</p>	
<p>In what ways are the UNCCD principles accommodated in other environmental frameworks (i.e. in terms of the participatory process, the consultative mechanism, programme approach, etc.)?</p> <p>ЦТК-ийн зарчмууд байгаль орчны бусад асуудлуудтай хэрхэн уялдсан бэ?</p>	<p>Цөлжилтийн асуудлуудыг дараахь хөтөлбөр, стратеги, бодлогын бичиг баримтанд тусгагдсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрт гангийн нөлөөг бууруулах урьдчилан мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх - Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөрт ховор, нэн ховор, устаж болзошгүй биологийн төрөл зүйлийг хамгаалах. Монгол орны гандуу бүс нутгийн хэмжээнд ховор, нэн ховор, устаж болзошгүй статус бүхий нийт 144 зүйл ургамал, 5 зүйл ан амьтан тархсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд эдгээр төрөл зүйлийг хадгалан үлдээх, тэдгээрийн амьдрах орчныг сайжруулах зорилтууд тусгагдсан. - Ногоон хэрэм Үндэсний хөтөлбөрт Монгол орны ой бүхий талбайг 1.6 увиар нэмэгдүүлэх; цөлжилт, гангийн нөлөөг бууруулах зорилгоор салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах; хөдөө аж ахуйн ойжуулалтын зарчмыг хөгжүүлэх замаар гандуу бүс нутгийн хэмжээнд ядуурлыг бууруулах, ажлын байраар хангах зорилтууд тусгагдсан. - Усны Үндэсний хөтөлбөрт усны нөөцийн хэмжээ, чанарыг тогтоох эрэл хайгуул, судалгаа, шинжилгээний ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах, ус хэрэглээний өсөн нэмэгдэх хэрэгцээг тасралтгүй бүрэн хангах; ус ашиглалтын уламжлалт арга, дэвшилтэт

	<p>технологи, шинэлэг санаачилгыг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай холбон судалж туршин нэвтрүүлэх; ус ашиглалтын болон байгалийн бусад сөрөг нөлөөллөөс усны нөөц хомсдож, бохирдохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргэгдэх чадавхийг дэмжих үйл ажиллагааг усны нөөц, чанарын мэдээллийг үндэслэн хэрэгжүүлэх замаар байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах; хүн амын ус хангамжийн хүрэлцээ, чанарыг сайжруулах, ялангуяа говь, хээрийн бүс нутагт усны эх үүсвэрийг тогтоох, усны барилга байгууламжийг барих, шинэчлэх замаар хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэх зорилтуудыг тавьсан.</p> <ul style="list-style-type: none"> - Ойн үндэсний хөтөлбөрт ойн нөөцийг зористой ашиглах, гандуу нутгийн ойжуулалтын ажлыг өргөжүүлэх зэрэг зорилтууд багтсан.
<p>What working relationships have been established between the NFP and/or NCB and those Ministries dealing with the implementation of such strategies?</p> <p>ҮЗ ба/буюу ҮЗХ-ноос эдгээр стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Яамдуудтай ажлын ямар холбоо тогтоогдсон бэ?</p>	<p>Дээрхи хөтөлбөр, стратеги бичиг баримтанд заагдсан цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй БОЯ-ны дэргэдэх агентлаг, хүрээлэн, төслийн баг, мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцох, зөвлөлдөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ҮЗХ-ны нарийн бичгийн даргыг БОЯ-ны дэргэд байгуулан ажиллуулж байна. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо нь Сангийн яам, СШУБЯам, ХХААЯ, ХНХ-н яам, Эрчим хүч, геологи уул уурхайн яам зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагуудтай цаг үеийн болон байнгын мэдээлэл солилцох, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналт тавих зэрэг хэд хэдэн талын хамтын ажиллагааны хэлбэрээр ажиллаж байна.</p>

iv. Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор авсан бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ

NAPs as part of the National Economic and Social Development and Environment Protection Plans	
4.1. ҮҮАХ-үүд нь Үндэсний Нийгэм-Эдийн засгийн Хөгжил ба Байгаль Хамгааллын Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох нь	
<p>How coherent is the NAP with other national and social development and environmental protection plans?</p> <p>ҮҮАХ нь бусад үндэсний ба нийгмийн хөгжлийн, байгаль хамгааллын төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан бэ?</p>	<p>Цөлжилтийн асуудлыг Монгол Улсын Засгийн Газраас 2006 онд баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл” баримт бичигт “...Байгаль хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, байгаль орчны доройтлыг багасгах” хэмээн тодотгон зааж энэхүү үйл ажиллагааг ҮҮАХ, түүнийг хэрэгжүүлэх, зохицуулах үүрэг хариуцлагыг холбогдох Яам, агентлагийн үйл ажиллагаанд уялдуулахыг үүрэг болгон ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2005 оны 64-р тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Бичил зээлийн асуудлыг тусгасан.</p> <p>Нийгэм-эдийн засгийн хөгжлийн хүрээнд ядуурлыг бууруулах, бүс нутгийн хөгжил, хөдөөгийн хөгжлийг дэмжих зорилгын хүрээнд хөдөөгийн иргэдийн нийгмийн харилцааг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглах, байгалийн дагалдах нөөцийг ашиглаж хэвшүүлэх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зэрэг цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-т заагдсан зарим заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд СЭЗЯ, НХХЯ, ДБЯ зэрэг байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Хэдийгээр бодлогын хүрээнд асуудлууд шийдвэрлэгдсэн гэж дүгнэхээр байгаа ч ҮҮАХ-ийн хэрэгжилтийн явцад үйл ажиллагааг үндэсний хөгжлийн ерөнхий стратегийн цогц байдалд дүйцүүлэхэд бодлого зохицуулалт, үүрэг хуваарилалтын шатанд институтуудын оролцоо сул байна.</p>
<p>To what degree is the NAP considered a strategic framework for action with regard to the policy objectives specified in those plans?</p> <p>ҮҮАХ нь эдгээр</p>	<p>Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заагдсан үйл ажиллагааны зорилтуудыг зарим стратеги баримт бичигт тусгаж бие даасан хөтөлбөрүүдийг боловсруулан ирсэн. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Цөлжилттэй тэмцэх практик үйл ажиллагааг сайжруулах, доройтсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг Ногоон Хэрэм хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэхээр тогтсон - Гандуу бүс нутгийн усны нөөцийг зохистой ашиглах, бэлчээр усжуулалтын ажлыг эрчимжүүлэх ажилбарыг Усны Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлж байна

<p>төлөвлөгөөнд заагдсан зорилтыг хэрэгжүүлэх стратеги үйл ажиллагааны хүрээнд хэрхэн дүйцэж байна вэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Ойн хомсдол, ойн экосистемийг хамгаалах ажлыг Ойн үндэсний хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэхээр тогтсон байна. - Говийн бүсийн бэлчээрийн даац, багтаамжинд үндэслэн эрчимжсэн МАА-г эрхлүүлэх зорилгоор “Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих” хөтөлбөр боловсруулан 2004 онд Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байна. - МАА-н салбарыг уур амьсгалд зохицуулан эрхэлж ашиг шим, үүлдрийг сайжруулах зорилгоор “Малын чанарыг сайжруулах” хөтөлбөрийг боловсруулан 2006 онд Засгийн Газраар батлуулан хэрэгжүүлж байна.
<p>What are the major institutional and/or programmatic obstacles in integrating the objectives of the NAP into such strategies?</p> <p>ҮҮАХ-ийн зорилтуудыг дээрхи стратегиудад уялдуулахад ямар зохион байгуулалт, удирдлагын бэрхшээл тулгарч байна?</p>	<p>Үндэсний хөтөлбөрт тавигдсан зорилтуудыг бусад стратегиудтай холбоход дараахь бэрхшээлүүд тулгарч байна хэмээн дүгнэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-ийг улс орны эдийн засгийн хөгжлийн стратеги зорилтод сул тусгагдсан - Цөлжилттэй тэмцэх ҮҮАХ нь бодогоос зохицуулалтын төвшинд хэрэгжиж өөрийн үндсэн биелэлээ үндэсний хэмжээнд олоход орон нутаг, удирдлага зохион байгуулалтын төв байгууллагуудын хооронд ашиг сонирхлын зөрчилдөөнийг арилгах чиглэлд зохицуулалт хийж чадахгүй байна. - Хэрэгжүүлэх, зохицуулах, хянах байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул
<p>Have policy measures and incentive schemes been adopted or initiated aiming at encouraging private sector support, notably with regard to technological and scientific cooperation, and how are these efforts reflected in the NAP?</p> <p>Хувийн секторыг татан оролцуулах, нэн ялангуяа шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагааны хүрээнд бий болгох</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах нөхцлийг бүрдүүлж, тэдний хувь нэмрийг хөхүүлэн дэмжих, хууль тогтоомжийг чанд сахин биелүүлдэг дадал заншилд сургаж хэвшүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжилтэд шинжлэх ухааны талаас хяналт тавих үүрэгтэй байгууллагаар ШУА-ийн Геоэкологийн Хүрээлэнгийн Цөлжилтийн Судалгааны Төв ажиллаж байгаагаас гадна ШУА-ийн харъяа судалгаа шинжилгээний бусад хүрээлэн, төвүүдийн хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж ирсэн. Олон нийтийн байгууллага, хувийн секторыг татан оролцуулах, нэн ялангуяа шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагааны хүрээнд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 10 гаруй төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажилладаг болно. Шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ҮҮАХ-т:</p> <ul style="list-style-type: none"> - цөлжилттэй тэмцэх төв, орон нутгийн байгууллагуудын

<p>талаар бодлого, урамшууллын тогтолцоо эсвэл санаачлагыг гарган ажилласан уу? Эдгээр оролдлогууд ҮҮАХ-т хэрхэн тусгагдсан бэ?</p>	<p>чадавхийг бэхжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - цөлжилттэй тэмцэх талаар сургалт сурталчилгааг өргөжүүлэх - цөлжилттэй тэмцэхэд төрийн бус байгууллага, хувийн сектор, иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг нэвтрүүлэх - цөлжилтөнд нэрвэгдсэн нутгийн хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх цөлжилттэй тэмцэх ажилд олон нийтийг татан оролцуулах эдийн засгийн урамшууллын оновчтой механизмыг судалж нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр дурьджээ.
<p>Are there any specific attempts in the NAP process aiming at closing the gaps between existing national sustainable policies and those that are currently drafted, i.e. through legislative adjustments or awareness-raising measures?</p> <p>Одоо хэрэгжиж буй тогтвортой хөгжлийн стратеги болон түүнтэй холбоотой шинээр боловсруулагдаж буй стратеги бодлогуудтай уялдаа холбоотой ажиллахад гарч буй бэрхшээлийг арилгах талаар ҮҮАХ-ийн хэрэгжилтэнд ажил хийгдсэн үү? Тухайлбал эрхзүйн зохицуулалт, оролцоог нэмэгдүүлэх г.м.</p>	<p>Бодлого, хууль эрхзүйн орчинд өнөөгийн хөгжлийн чиг баримжаанаас хамааралтайгаар өөрчлөлт оруулах ажилд Үндэсний хорооноос идэвхи санаачлагатай оролцсон хэмээн дүгнэж байна. Ийнхүү дараахь бичиг баримтыг дахин боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажилд хамтран ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын төлбөрийн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх эдийн засгийн хөшүүргийг тусгасан заалт оруулахаар Газрын Харилцаа, Геодези Зурагзүйн Газар болон холбогдох байгууллагуудаас санал авч байна. - Ургамал хамгаалах хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг томилон ажиллуулж эхэлсэн - Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 онд баталж хэрэгжүүлсэн бөгөөд тэжээлийн болон төрөл бүрийн таримал услах, бэлчээрийг усжуулах ажиллагааг дэмжин урамшуулах эрхзүйн үндэсийг боловсронгуй болгох чиглэлээр өөрчлөлт оруулсан. <p>Дээрхи хөтөлбөр, стратеги баримт бичигт заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв, олон улсын хандивлагч байгууллагуудын санхүүжилттээр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд институтуудын, орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын болон ард иргэдийн төвшинд чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг дэс дараатай авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Бэлчээрийн тогтвортой менежмент, Олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент (ШЗБНХ ТББ), Хөдөөгийн Ядуурлыг бууруулах зэрэг төслүүдийн хүрээнд нийт 100 орчим малчдын бүлэг байгуулан тогтвортой амьжиргааг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт, загвар аж ахуй, туршилтын талбаруудыг байгуулан ажиллаж байна.</p>

<p>What new initiatives have been undertaken since the last report on integrating the NAP into the national economic and social development and environment protection planning systems, including at the local and national levels?</p> <p>Сүүлийн тайлангаас хойш орон нутгийн болон үндэсний түвшинд ҮҮАХ-ийг эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд уялдуулах тухай ямар шинэ санаачлагууд гарган хэрэгжүүлж ирсэн бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Усны тухай хууль, Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого, Тариалангийн тухай хууль, Усны шинэтгэл-21 үйл ажиллагааны чиглэл, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль бодлогын баримт бичгүүдэд усалгаатай тариаланг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмуудыг тусган хэрэгжүүлж байна. - ХАА-н салбарт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдсан нийт 18 аймгийн малчдад бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн зураглал, газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбоотой сургалт, семинарыг зохион байгуулах ажлыг хийж байна. - Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагад нийцүүлэн таримал ургамалын тариалалтын технологийг температур, тунадасны өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн тогтоож, чийг бага шаарддаг, ганд тэсвэртэй ургамлын шинэ сортыг тариалангийн бүсүүдээр тодорхойлох ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэж байна. - Швейцарийн Хамтын Ажиллагааны Агентлагаас хэрэгжүүлж буй “Монголын бэлчээр – ногоон алт” төсөлтэй хамтран “Бэлчээрийн эрсдлийн менежментийн төлөвлөлт хийх аргачлал”-ын талаар бүх аймгийн ХХАА-ын газрын дарга нарт семинар хийж сурталчилан хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч байна. - Хүрээлэн буй байгаль орчны төлөв байдлын тухай мэдээллийг орон нутгийн статистикийн мэдээлэлд оруулж мэдээлэл солилцоог өргөжүүлэх зорилгоор “Монгол Улсын байгаль орчны 2004 оны төлөв байдлын тайлан”-г холбогдох яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагууд, их дээд сургууль, сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд даалган Үндэсний Статистикийн Газрын (ҮСГ) мэдээллийн санд оруулахаар тогтсон. - Ашигт малтмал болон бусад үйлдвэрлэлийн салбарын байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бууруулах, эрсдлийн санг бий болгох зорилгоор “Экологийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хууль” –ийн төслийн боловсруулсан.
--	--

	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгалийн баялгийн болон нөхөн сэргээлтийн холбогдох мэдээллийг орон нутгаас сар, улирлаар авч нэгтгэн дүгнэх, мэдээллийн сан үүсгэх чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болсон.
<p>How successful is such a process?</p> <p>Энэхүү үйл ажиллагаа нь амжилттай явагдаж буй эсэх?</p>	<p>Эдгээр үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд дараах бодит үр дүнд хүрээд байна.</p> <ul style="list-style-type: none"> - ганд тэсвэртэй, хурдан болцтой үр тариа, ногоо ургамлын Дархан 106, Дархан 141 сортуудыг гарган авч баталгаажуулсны зэрэгцээ усалгаатай нөхцөлд Дархан 133 сортыг шалгаруулсан. - Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд 8 аймгийн 142 сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, зураглал гаргаж орон нутагт нь хүлээлгэн өгч бэлчээр төлөвлөлт, сэргээн сайжруулах арга хэмжээнд ашиглаж байна. - Бэлчээр усжуулалт, усны нөөцийг зохистой ашиглах чиглэлээр говийн бүсийн усны нөөцийг үнэлэх ажлыг 3 үе шаттайгаар JICA олон улсын байгууллагатай хамтран судалсны зэрэгцээ, жил бүр улсын төсвөөс худаг уст цэг гаргах, сэргээн засварлах ажилд тодорхой хэмжээний хөрөнгийг тусган ажиллаж байна. - Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг” хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн бүсүүдэд тухайн орон нутгийн засаг захиргаа, арилжааны банкуудтай хамтран “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан” байгуулахаар ажиллаж байна. - Хөдөөгийн нэн ялангуяа усны хүрэлцээ муу аймгуудын худаг уст цэгийг нэмэгдүүлэх зорилгоор малчид, иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд 19.3 сая төгрөгийн шагналын сантай “Гар худаг”уралдааны болзол зарлаж 2005 оны байдлаар нийт 350 гаруй гар худаг гаргасан байна. - “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд эхний жилд урьдчилсан байдлаар 13 аймгийн 14 газарт 353.5 га талбайд хашаа хамгаалалттай, усалгаатай зурвас байгуулж, үүнд 120087 ш ашигт модлог ургамлын тарьц, суулгацыг тарималжуулаад байна.

Linkage achieved with subregional and regional action programmes (SRAPs and RAPs)	
4.2. Бүсийн, Дэд Бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй бий болсон харилцаа холбоо	
<p>What kind of activities are being pursued which have a subregional or regional dimension and/or are directly linked with activities pursued under a SRAP or RAP and its thematic programme networks (TPNs)?</p> <p>БҮАХ/ДБҮАХ болон сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээний (СХС) хүрээнд бүсийн болон дэд бүсийн түвшинд ямар үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцийн газраас Азийн бүс нутагт хэрэгжүүлэх “Цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт бүсийн сүлжээг Монгол оронд төвлөрүүлэн ажиллаж байна. - Зүүн Хойд азийн байгаль орчны хамтын ажиллагааны хүрээнд Стратегийн үйл ажиллагааны хөтөлбөрийн гишүүн орон болж “Түмэн голын бүсийн стратеги хөтөлбөр” төслийг хэрэгжүүлэхэд оролцож байна. - Зүүн Хойд Азийн бүсийн шороон шуурганы нөлөөг бууруулах чиглэлээр засгийн газар хоорондын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож ирсэн.
<p>In what way do they conform to the objectives of the NAP?</p> <p>Эдгээр нь ҮҮАХ-ийн зорилтууд хэрхэн нийцэж байна вэ?</p>	<p>Дээрхи үйл ажиллагааны хүрээнд Цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчин, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг боловсронгуй болгох, цөлжилтийн үйл явцад дасан зохицох, цөлжилтөнд нэрвэгдэж байгаа газар нутгийн бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогыг боловсронгуй болгох, судалгаа мониторингийн цар хүрээ, онол арга зүйн түвшин, практик үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг зорилтыг гүйцэлдүүлэхэд чиглэгдсэн. Үүнээс гадна дээрхи зорилтуудыг биелүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн дүгнэж байна (Хураангуйн хэсгийн төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэсгээс тодорхой үзнэ үү).</p>
<p>Are national scientific and technical institutions participating actively and effectively in subregional, regional and relevant international networks?</p> <p>Шинжлэх ухааны болон техникийн байгууллагууд бүсийн болон дэд бүсийн, холбогдох олон улсын сүлжээнд идэвхитэй, үр ашигтай оролцдог</p>	<p>Монгол Улсын Шинжлэх ухааны болон техникийн байгууллагууд нь бүсийн болон дэд бүсийн, холбогдох олон улсын сүлжээнд гишүүн болон ажиллаж ирсэн Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Экологийн урт хугацааны мониторингийн сүлжээ (LTER) - Ази Номхон Далайн Сүлжээ (APN) <p>Мөн ЦТК-ийн СХС5-ын хүрээнд Ус, цаг уурын хүрээлэн хэрэгжүүлэгч байгууллага статустайгаар ажиллаж байгаа бөгөөд ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, түүний дэргэдэх Цөлжилтийн судалгааны төв, Газарзүйн хүрээлэн, Ботаникийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллага, Эко-Ази дээд сургууль тусгайлсан сэдвүүдээр өөрийн үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрхи байгууллагууд нь СХС5-ын зорилтуудыг биелүүлэх үндсэн</p>

уу?	үүрэг хариуцлагынхаа хүрээнд Япон, БНСУ, БНХАУ, ОХУ зэрэг хөрш зэргэлдээ орнууд болон GEF, UNDP зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж өөрийн чадавхийг бэхжүүлэх, бүсийн хэмжээнд үйл ажиллагаагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор төсөлт ажлуудыг хэрэгжүүлэн ирсэн.
Has the Government officially adopted the NAP? Засгийн газар ҮҮАХ-ийг албан ёсоор баталсан уу?	Тийм (II ² –ийг үзнэ үү?)
Has a budget been officially approved to finance the implementation of the NAP? ҮҮАХ-ийг хэрэгжүүлэх төсөв албан ёсоор батлагдсан уу?	ҮЗХ цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-рийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор МУ-ын төсвөөс тусгайлсан санхүүжилтийг өнөөг хүртэл авч байгаагүй бөгөөд бусад хөтөлбөр, үндэсний болон олон улсын санхүүжилттэйгээр хэрэгжиж төслүүдээс тодорхой хэмжээний эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллаж ирсэн. Үүнээс гадна олон улсын байгууллага, донор орнуудад төслийн санал боловсруулж өгөх, тэдгээрийг хэрэгжүүлэх замаар үйл ажиллагааны санхүүжилтийг олж авдаг.
Provide a brief on the status of NAP implementation. ҮҮАХ-ийн хэрэгжилтийн тухай товч дурьдана уу?	<ul style="list-style-type: none"> - Цөлжилттэй тэмцэх, байгаль орчны конвенциудын уялдаа холбоог дээшлүүлэх нь сэдэвт Үндэсний Чуулган, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Ази-Африкийн 3 дугаар чуулга уулзалт, уг конвенцийн Азийн бүсийн талуудын 4 дүгээр хуралдаан, “Цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвчилсэн хөтөлбөрийн төлөвлөлтийн хурлыг зохион байгуулсан. - Даян Дэлхийн байгаль орчны сангийн газрын доройтолд орсон орнуудын үнэлгээний жагсаалтанд Монгол Улс албан ёсоор бүртгэгдсэн. - Цөлжилтийн төлөв байдал, үйл явцын зургийг шинэчлэх ажлыг ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн дэргэдэх Цөлжилтийн Судлагааны Төвд боловсруулагдаж байна. - Зүүн Хойд Азийн бүсийн орнуудын Шар шороон шуурганы мониторингийн сүлжээ байгуулах ажлыг эхлүүлсэн.
Established and functional national coordination body (NCB)	
4.3. Үндэсний зохицуулах байгууллага, түүний үйл ажиллагаа	
How influential is the NCB on matters of policy and legislation, and how	Үндэсний зохицуулах хороо нь Засгийн газарт тухай бүр бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэн засварлах, шинээр батлах ажилд идэвхи санаачлга гарган оролцдог

<p>well is it linked to the Government department responsible for development partners?</p> <p>ҮЗХ нь бодлого болон хууль зүйн талаас хир нөлөөтэй ажиллаж ирсэн ба/ бөгөөд Засгийн газрын холбогдох байгууллагатай хир уялдаатай ажилладаг вэ?</p>	<p>(4.5. хэсгээс тодруулан үзнэ үү). Үндэсний Зохицуулах хороо нь Засгийн газар түүний хэрэгжүүлэх байгууллага Байгаль орчны яаманд үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шатны биелэлтийн талаар улирал, жилээр тайлан гаргаж хэлэлцүүлэх үүргийг хүлээн ажиллаж ирсэн. Иймд ҮЗХ нь Засгийн газартай нягт хамтран ажиллаж байна.</p>
<p>To what extent is the NCB decentralized in terms of financial, human and material resources?</p> <p>ҮЗХ нь санхүүгийн, хүний болон материаллаг нөөцийн төвлөрлийг сааруулах чиглэлд хир ажиллаж ирсэн бэ?</p>	<p>Үндэсний хорооны бүрэлдэхүүн, түүний харъяа байгууллагуудад газар зохион байгуулалт, ойжуулалт, ой, усны менежмент, байгаль орчныг хамгаалах, улсын тусгай хамгаалалттай газрыг хамгаалах, газрын доройтолтой тэмцэх салбарын шууд төлөөлөл байхын зэрэгцээ эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, эдийн засаг зэрэг салбарын төлөөлөгчид багтдаг. Иймд хүний нөөцийн төвлөрлийг сааруулах чиглэлээр бодитой арга хэмжээ аван ирсэн. Санхүүгийн эдийн засгийн хувьд ҮЗХ нь ЗГ , түүн дундаа БОЯ-наас шууд хараат байгаа учир өнөөдрийн байдлаар төвлөрсөн нэг санхүүтэй байгаа бөгөөд биеэ даасан санхүүгийн үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Хэдий тийм ч үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлэх зорилгоор бусад хөтөлбөр, төсөлүүдэд өөрийн зорилтуудыг хэрэгжүүлж байгаа учир санхүүгийн тодорхой хэсэг нь төвлөрсөн эх үүсвэрээс (БОЯ) хараат байгаа юм. ҮЗХ нь БОЯ-ны дэргэд ажиллаж байгаа хэдий ч түүний бүтэцэд багтах байгууллагуудад гол материаллаг бааз нь суурилан ирсэн болно.</p>
<p>Has a full-time secretariat for the NCB been established since the last report?</p> <p>Сүүлчийн тайлангаас хойш ҮЗХ нарийн бичгийн даргын албыг байгуулсан эсэх?</p>	<p>2002 оноос хойш БОЯ-ны дэргэд орон тооны ЦТҮЗХ-ны нарийн бичгийг томилон ажиллуулж байгаа.</p>
<p>How autonomous is the NFP in terms of resources and decision making?</p> <p>ҮЗ нь нөөцийн болон шийдвэр</p>	<p>ҮЗХ нь төрийн бус байгууллагын статустай бөгөөд шийдвэр гаргах төвшинд бүрэн бие даан ажиллаж ирсэн.</p>

<p>гаргах түвшинд хэр бие даасан байдалтай вэ?</p>	
<p>To what extent can the NCB promote synergistic developments for sustainable land management with related programme frameworks?</p> <p>ҮЗХ нь холбогдох хөтөлбөрийн хүрээнд газрын менежментийн үйл ажиллагаанд ямар үүргийг хүлээн ажиллаж байна вэ?</p>	<p>Газрын менежментийг сайжруулах, түүний тогтвортой хөгжлийг хангах ажлын хүрээнд ҮЗХ нь ГКГЗЗГ-тай хамтран зохицуулах, зөвлөх үүргийг хүлээн ажиллаж байна. Үүнээс гадна газрын менежментийг боловсронгуй болгох, доройтсон газар нутгийг нөхөн сэргээх зэрэг богино болон урт хугацааны төсөлт ажлыг хэрэгжүүлэх, зохицуулах гол байгууллага болон ажиллаж байна.</p>
<p>Review and evaluate the status of resources within the NCB as compared to the last report.</p> <p>Сүүлчийн тайлантай харьцуулахад ҮЗХ-ийн чадавхид үнэлэлт, дүгнэлт өгнө үү.</p>	<p>Үндэсний зохицуулах хороо нь цөлжилттэй тэмцэх олон талт үйл ажиллагааг нэгдмэл цогц хэлбэрт авч хэрэгжүүлэх чадварыг хангах зорилгоор ЦТҮХороо нь төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, нийгэм, эдийн засаг, байгаль хамгаалах, газар зохион байгуулалт зэрэг салбар мэргэжлийн ур чадвар өндөртэй ахлах мэргэжилтэн, эрдэмтдийн төлөөллийг өөрт хамруулах ажлыг сүүлийн 4 жилийн хугацаанд идэвхитэй санаачлан ажиллаж ирлээ.</p> <p>Хэдий тийм ч ҮЗХ нь өөрийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хэмжээнд бүрэн гүйцэлдүүлэх нийгэм-эдийн засгийн харилцаа өнөөг хүртэл бэхжиж чадаагүй бөгөөд цаашид энэ талыг бэхжүүлэх зорилгоор бусад яамдын төлөөлөлтэй хамтран ажиллаж яам дундын гэрээ хэлэлцээрийг батлах ажлыг санаачлан ажиллаж байна.</p>
<p>Does the NCB have the capacity to catalyze preparation, implementation and evaluation of the NAP?</p> <p>ҮЗХ-д ҮҮАХ-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх, үнэлгээ чадвартай юу?</p>	<p>ҮЗХ нь ҮҮАХ-ийг хэрэгжүүлэхэд бодлогын чиглэлээр хангах байгууллага бөгөөд өнөөгийн байдлаар цөлжилт, газрын доройтолоос урьдчилан сэргийлэх чиглэлд хэрэгжиж буй бүхий л үйл ажиллагаа, төсөлт ажилд өөрийн хяналтыг тавин ажиллаж ирсэн. Иймд ҮЗХ нь зохицуулах, хяналт тавих бүрэн чадалтай бие даасан байгууллага болно.</p>
<p>What are the specific capacity needs of the NCB and the NFP, taking into consideration the cross-sectoral nature of the Convention?</p>	<p>Хэдийгээр ҮЗХ, ҮЗ нь ЦТК-ийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ҮАХ-ийн биелэлтэнд хяналт тавин ажиллаж ирсэн ч өнөөгийн нийгэм-эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлд дасан зохицох чадавхи байхгүй хэмээн дүгнэж байна. Иймд:</p> <ul style="list-style-type: none"> - дасан зохицох чадавхийг бий болгох - шийдвэр гаргах төвшинд байгаль хамгаалал, нийгэм-эдийн засгийн хүрээнээс гарч буй шинэ

<p>Конвенцийн салбар дундын шинж чанарыг харгалзан үзвэл ҮЗХ болон ҮЗ-т чадавхийг бий болгох ямар хэрэгцээ шаардлага байна вэ?</p>	<p>эрэлт хэрэгцээ мэдрэн ҮҮАХ-ынг хэрэгжүүлэхэд шинэ санаа санаачлагыг шийдвэр гаргах төвшинд хүргэх тогтолцоог бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - хөтөлбөрийн менежментийг сайжруулах зэрэг хэрэгцээ шаардлага өнөөдөр улам бүр өсч байна.
<p>Has any review been done (in terms of representation) to ensure participation from other stakeholders?</p> <p>Оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэл өөрчлөлт хийгдсэн үү?</p>	<p>Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг татан оролцуулах тухай хөтөлбөрт дараахь шинэчлэлүүдийг хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - цөлжилттэй тэмцэхэд төрийн бус байгууллага, хувийн сектор, иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг нэвтрүүлэх - хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачлага, идэвхи оролцоог хөхүүлэн дэмжиж өргөнөөр татан оролцуулна.
<p>Are there any changes to report with regard to how the NCB is linked to bodies of other United Nations conventions?</p> <p>ҮЗХ нь НҮБ-ийн бусад Конвенциудтай хэрхэн уялдсан талаар шинээр гарсан өөрчлөлт байгаа эсэх?</p>	<p>ҮЗХ нь НҮБ-ын бусад Конвенцидтай уялдан ажиллаж ирсэн үйл явцад өөрчлөлт ороогүй боловч ажил төрлийн уялдаа холбоо сайжирсан.</p>
<p>How does the composition of the NCB enhance the (synergistic) programming and implementation of UNCCD projects?</p> <p>ҮЗХ-ны бүрэлдэхүүн ЦТК-ийн төслүүдийн боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хэрхэн сайжруулсан бэ?</p>	<p>Энэ хугацаанд ҮЗХ цөлжилттэй тэмцэхэд үндсэн зорилгоо чиглүүлсэн, орон нутагт бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээний үндэсний чадавхийг олон улсын төвшинд хүргэх зорилгоор GEF-ийн Төсөл Боловсруулах Сангийн санхүүжилттэйгээр “Газрыг зүй зохистой ашиглаж цөлжилттэй тэмцэх” төслийн саналыг 2005 онд боловсруулан хүргүүлсэн. Үүнээс гадна хандивлагч орнууд, бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагаа тогтоосон орнуудтай цөлжилттэй тэмцэх талаар жижиг төслүүдийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллаж ирсэн. Энд иргэний нийгэм, ТББ-уудын оролцоо их байсныг тэмдэглэх нь зөв юм.</p>
<p>How does the NCB/NFP address the need to involve in the NAP private sector</p>	<p>ҮЗХ болон ҮЗ нь ҮҮАХ-ийн хувийн секторын санаачлага, тэдгээрийн маркетингийн стратегийг гандуу нутгийн үйлдвэрлэлд татан оролцуулах талаар удирдлагын ба шийдвэр гаргах түвшинд яригддаг боловч тэр бүр ажил хэрэг</p>

<p>initiatives and marketing strategies for drylands products?</p> <p>ҮЗХ болон ҮЗ нь ҮҮАХ-ийн хувийн секторын санаачлага, тэдгээрийн маркетингийн стратегийг гандуу нутгийн үйлдвэрлэлд татан оролцуулахад хэрхэн ажилласан бэ?</p>	<p>болж хэрэгжихгүй байна. Цаашид хувиараа үйлдвэр эрхлэгчдийн санаачлагыг өрнүүлэн тэдгээрийн маркетингийн бодлогыг гандуу нутагт хандуулах нь цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, экологид халгүй технологи нэвтрүүлэхэд цаг хугацаа, зардал хэмнэх, үр дүнг дээшлүүлэх арга болно.</p>
<p>Has the level of stakeholder participation increased since the last reporting and what are the mechanisms to ensure active participation?</p> <p>Сүүлчийн тайлангаас хойш хамтран ажиллагсдын оролцоо нэмэгдсэн үү? Тэднийг идэвхитэй оролцуулах ямар хөшүүрэг байна вэ?</p>	<p>Хамтран ажилладаг байгууллагуудын тоонд Зүүн Хойд Азийн Ойн Чуулган, Монголын Ойн Чуулган, Монголын Байгаль Орчны Консорциум зэрэг төрийн бус байгууллагууд нэмэгдэн ажиллаж байгаа. Хамтран ажиллаж буй байгууллагуудын түншлэлийг урт хугацаанд тогтвортой байлгах зорилгоор эдийн засгийн, нийгмийн урамшууллыг тогтолцоог бүрдүүлэх ажил нь өнөөгийн төвшинд боловсруулалтын шатанд хэрэгжиж байна. Энд МУ-ын Засгийн Газраас санхүүгийн тодорхой хувийг гаргах, биет болон биет бус дэмжлэг үзүүлэх ажлыг тухай бүр амжилттай шийдвэрлэж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэх нь зөв юм.</p> <p>ҮЗХ гишүүд, ТББ-ууд болон иргэний нийгмийн төлөөлийн үүрэг хариуцлага дор хурал семинар зохион байгуулах, улирал, жилийн үндэсний талбайн бэлтгэх, мэдээллээр хангах зэрэг ажлыг гүйцэтгэж ирсэн бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг тухай бүр үнэлэх дүгнэх хуралдааныг үндэсний болон бүс нутгийн хэмжээд зохион байгуулж ирсэн.</p>
<p>How effective and efficient are the ways and means of communication or networking among members of the NCB and the groups they represent, especially with regard to civil society organizations?</p> <p>ҮЗХ-ны гишүүд болон тэдгээрийн төлөөлж буй бүлэг, ялангуяа иргэний нийгэмийн хоорондын харилцаа холбоо, тэдгээрийн сүлжээг</p>	<p>ҮЗХ-ны гишүүд нь тэдгээрийн төлөөлж буй нийгмийн бүлэг, ялангуяа иргэний нийгэмийн эрэлт хэрэгцээг ҮЗХ, түүний үйл ажиллагааны хүрээнд тухай бүр хэлэлцэх, зөвлөлдөх шаардлага хэрэгцээ өндөр байгаа билээ. Хэдий тийм ч өнөөдөр ҮЗХ-ны үйл ажиллагаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хараат байхаас гадна иргэний нийгэм, гишүүдийн төлөөлж ирсэн иргэний бүлгийн ашиг сонирхол тэдгээрийн хоорондын уялдаа холбоо шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх, дүгнэх явцад ашиглагдахгүй байгаа гэж хэлэхээр төвшинд байна.</p>

хир үр ашигтай ашиглагдсан бэ?	
<p>Is the modality for nominating members to the NCB transparent?</p> <p>ҮЗХ-ны гишүүдийг сонгох журам уян хатан болж чадсан уу??</p>	<p>ҮЗХ-г 2003 онд шинэчлэн баталж, ҮЗХ байгуулах, гишүүдийн үүрэг хариуцлага, оролцооны хувийн талаар сайдын тогтоолыг гарган ажиллаж ирсэн бөгөөд энэхүү тогтоолоор цөлжилттэй тэмцэх конвенцийг Монгол Улсад биелүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заагдсан ажлуудад шууд хамааралтай оролцох яам тамгын газар, судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, ТББ-уудын төлөөллийг урьд өмнө байсан оролцооны хувийг үнэлэж замаар сонгох зарчимд тулгуурлан ажиллаж байна. ҮЗХ-г томилон ажиллуулах өмнөх туршлагад тулгуурлан оролцооны хувь, тэргүүлэх чиглэлд нийцсэн эсэхийг үнэлж сонгодог болсноор ҮЗХ-г томилон ажиллуулах одоо байгаа журам нь өмнөхөөс уян хатан болсон гэж дүгнэхээр байгаа ч иргэний нийгмийн оролцоог хэрхэн тусгах тал дээр учир дутагдалтай байна.</p>
<p>Critically review, analyse and compare the capacity of the NCB to organize and manage the information system since the last report.</p> <p>Сүүлчийн тайлангаас хойш ҮЗХ-ноос мэдээллийн тогтолцоог зохион байгуулах, зохицуулах чадавхид гарсан өөрчлөлтийг харьцуулж дүн шинжилгээ өгнө үү.</p>	<p>ҮЗХ нь сүүлийн тайлангийн хугацаанаас хойш бүтэц бүрэлдэхүүнээ өөрчлөн ажиллаж ирсэн бөгөөд мэдээллийн системийг зохион байгуулах, зохицуулах чадавхид дараах зэрэг өөрчлөлтүүд гарсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ҮҮАХ-ийг хэрэгжүүлэх яам тамгын газар, судалгаа шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр мэдээлэл солилцооны бүхий л хэрэгслэлүүдийг ашиглан хүлээн авах, бусдад түгээх бодлогоор ҮЗХ-г хангасан. - Байгаль орчны мэдээллийн санг олон нийтэд нээлттэй болгох зорилгоор Нидерландын ЗГ-ын санхүүжилтээр “Үндэсний геомэдээллийн төв” төслийг хэрэгжүүлэхээр баталж энд ЦТ ҮЗХ Монгол орны цөлжилтийн талаархи мэдээллийн эх үүсвэрүүд, тэдгээр мэдээллийн ангилал, зэрэглэл, хариуцах байгууллага зэрэг мэдээллээр хангах эрх үүргийг хүлээн ажиллаж байна. <p>Бэрхшээл:</p> <ul style="list-style-type: none"> - ҮЗХ орон нутгийн төвшинд өөрийн үйл ажиллагааны хүрээг бүрэн таниулж чадаагүй - Шинжлэх ухааны, техник, технологийн зөвлөлийг давхар ажиллуулах шаардлага, хэрэгцээ өнөөдөр нэн тэргүүнд тавигдаж байна <p>Оролцогч байгууллагуудын мэдээлэл солилцооны, харилцаа холбооны төвшинг олон улсын өнөөгийн шаардлагад нийцүүлэн ажиллах шаардлагатай.</p>
<p>What is the status of the databases being maintained by the NCB?</p> <p>Мэдээллийн санг</p>	<p>ҮЗХ-оос гаргадаг мэдээлэл нь ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт болон БОЯ-ны үйл ажиллагааны биелэлтэнд тусгагдаж ирсэн бөгөөд мэдээллийн сан нь тухай бүр ҮҮАХ хэрэгжүүлэх байгууллага,</p>

шинэчлэх ямар ажил ҮЗХ-оос хийсэн бэ?	хүрээлэнгийн мэдээллээр баяжигдаж ирсэн.
<p>Evaluate the means of internal and external communication between the NFP and the NCB?</p> <p>ҮЗ болон ҮЗХ хоорондын дотоод болон гадаад харилцааг үнэлнэ үү.</p>	<p>ҮЗ болон ҮЗХ-ны дотоод харилцаан дор хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт болон цаашдын төлөвлөгөөг боловсруулах, цөлжилттэй холбоотой олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах зэрэг үүрэг багтах бөгөөд жил бүр үндэсний тайланг бэлтгэн гаргаж ЗГ-т хэлэлцүүлж ирсэн. Үүнээс гадна ҮЗХ-нд багтахбайгууллага, ТББ, хүрээлэн албан нэгжүүдтэй мэдээлэл солилцох, түгээх үйл ажиллагааг тухай бүр нээлттэй хийж ирсэн.</p> <p>Гадаад хамтын ажиллагааны хүрээнд МУ-д үйл ажиллагаа явуулж буй байгаль орчны Олон Улсын байгууллагуудтай холбоо тогтоож нягт ажиллахын зэрэгцээ НҮБ-ын ЦТК-ийн зүгээс зохион байгуулж буй хурал, зөвлөлгөөн, сургалт семинарт холбогдох байгууллага, иргэн, төлөөллийг тухай бүр оролцуулж өөрийн орны дуу хоолойг хүргэж ирсэн.</p>
<p>Institutional framework for coherent and functional desertification control</p> <p>4.4. Цөлжилтийн хяналтын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохион байгуулалтын цар хүрээ</p>	
<p>How has the review and analysis of existing mechanisms for coordinating and harmonizing actions to combat land degradation at national and local levels contributed to strengthening coordination and implementation of UNCCD programmes?</p> <p>ЦТК-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад үндэсний болон орон нутгийн түвшинд газрын элэгдэлтэй тэмцэх үйл ажиллагааг удирдан зохицуулах өнөөгийн механизмыг шинэчлэх, дүн шинжилгээ өгөх ажил хэрхэн хийгдэж ирсэн бэ?</p>	<p>ЦТК-иос тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний хөтөлбөрт заагдсан үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн хэмжээнд шат дараатай авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр нь гол төлөв олон улсын донор байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд хийгдэж ирсэн. Газрын доройтлыг бууруулах, ойн хомсдолыг сааруулах зорилгоор улсын төсвөөс жил бүр 500-600 сая төгрөгний санхүүжилтийг орон нутагт төсөл, даалгаварт ажлын хүрээнд хийж гүйцэтгэж ирсэн. Дээрхи ажлуудын холбогдох яам, орон нутгийн захиргаа өөрийн удирдлага зохицуулалтын мэдэл дор авч хэрэгжүүлж байна.</p>

<p>Where is it necessary to build capacity at the local and national level in order to establish a well functioning information exchange between relevant stakeholders?</p> <p>Оролцогч талуудын хооронд мэдээлэл солилцоог хангах чадавхийг бэхжүүлэх ажлыг орон нутгийн болон үндэсний түвшинд хаана хийх шаардлагатай байна вэ?</p>	<p>Холбогдох сонирхлын бүлгүүдийн хооронд орон нутгийн болон үндэсний түвшинд мэдээлэл солилцох чадварыг бий болгох зорилгоор мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах шаардлага өнөөг хүртэл тавигдан ирсэн. Энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор цөлжилтийн биофизик үзүүлэлтийг үнэлж дүгнэх, мэдээллийн сан байгуулах, мэдээллийг түгээх нэгдсэн сүлжээг УЦУОШГ-ын харъяа Мэдээлэл Тооцооллын Төвд хариуцуулан ажиллуулж байна. Үүнээс гадна нийгэм-эдийн засгийн мэдээлэл, төсөл, үйл ажиллагааны хэрэгжилтийн мэдээллийг Цөлжилтийн Судалгааны Төв, Цөлжилттэй Тэмцэх Үндэсний Хороо тус тус хариуцан ажиллаж байна.</p> <p>Мэдээлэл солилцооны чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд дараахь хэд хэдэн чиглэлд чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна. Үүнд:</p> <p>Орон нутгийн түвшинд:</p> <ul style="list-style-type: none"> - орон нутгийн засаг захиргааны мэдээллийн чанарыг дээшлүүлэх чиглэлд - орон нутгийн иргэдэд мэдээллийг шуурхай хүртээх чиглэлд - орон нутгийн иргэдээс гарах санал, зөвлөмж, мэдээллийг төв захиргааны байгууллагад хүргэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чиглэлд <p>Үндэсний төвшинд:</p> <ul style="list-style-type: none"> - мэдээллийн чанарыг дээшлүүлэх, төрөл зүйлийг нэмэгдүүлэх - Цөлжилтийн асуудлыг нэгдмэл шинж чанарт тулгуурлан мэдээллийг төрөлжүүлэх, тэдгээрийн хамаарлыг тодорхойлох чиглэлд - Мэдээлэл боловсруулах, хэрэглэгчдэд хялбар ойлгогдох, хэрэглэгдэхүйц мэдээллийг бий болгох чиглэлд - Олон улс, бүс нутгийн хэмжээнд мэдээлэл солилцоог эрчимжүүлэх чиглэлд
<p>Is capacity and institution building being continuously addressed and promoted at the local and national levels?</p> <p>Чадавхи, зохион байгуулалтыг бэхжүүлэх арга хэмжээ үндэсний, орон нутгийн түвшинд хэрэгжиж, сурталчлагдаж ирсэн үү?</p>	<p>Чадавхийг бэхжүүлэх зорилгоор орон нутгийн төвшинд сургалт семинар зохион байгуулах ажлыг холбогдох байгаль орчны хөтөлбөр, төслүүдийн хүрээнд тухай бүр зохион байгуулж ирсэн.</p>

<p>What changes have taken place since the last report?</p> <p>Хамгийн сүүлчийн тайлангаас хойш ямар өөрчлөлтүүд гарсан бэ?</p>	<p>Энэхүү ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн менежментийн сайжруулах төслийн хүрээнд нийт 3 аймгийн 9 сумдын хэмжээнд бэлчээрийн зохистой ашиглах, сэлгээтэй бэлчээр ашиглалтыг нэвтрүүлэх, байгалийн дагалдах баялгийг ашиглах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулан, загвар аж ахуйнуудыг нийт 21 малчдын бүлгийн хэмжээнд нэвтрүүлээд байна. <p>Ядуурлыг бууруулах төслийн хүрээнд нийт 12 аймгийн хэмжээнд 25 малчдын бүлгийг зохион байгуулж тогтвортой амьжиргааны үзэл баримтлалд тулгуурласан бэлчээрийг зохистой ашиглах</p>
<p>What is the feedback from stakeholders and institutions?</p> <p>Оролцогч тал, байгууллагуудаас ирүүлсэн санал юу байв?</p>	<p>Олон улсын байгууллагуудын санхүүжилт, техник хамтын ажиллагааны тусламж, дэмжлэгтэйгээр хэрэгжсэн эдгээр ажлын үр дүнд дараах санал, шаардлагуудыг ҮЗХ, МУ ЗГ-т тавиад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - бий болсон дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн харилцааг удаан хугацанд тогтвортой үргэлжлүүлэх бодлого чиглэлээр хангах - хүрсэн үр дүнг улам бүр сайжруулах, илүү үр дүнд хүрэх зорилгоор орон нутагт бүрдсэн нийгэм-эдийн засаг, байгаль хамгааллын зарчмыг тухай бүр гүнзгийрүүлэн боловсруулах - үйл ажиллагааны хүрээнд тавигдаж ирсэн зорилго, зорилтонд хүрэх арга хэмжээг үндэсний болон орон нутгийн чадавхид үндэслэн үргэлжлүүлэх - орон нутагт нийгэм, эдийн засгийн хүрээнд бий болсон ажлын байр, техник, технологийн шийдлүүдийг уламжлан үлдээх зарчимд тулгуурлан хадгалан хөгжүүлэх
<p>Coherent and functional legal and regulatory framework</p>	
<p>4.5. Хууль эрхзүй, зохицуулалтын уялдаа холбоо, үйл ажиллагааны цар хүрээ</p>	
<p>How coherent and functional is the environmental legislation in your country?</p> <p>Танай оронд байгаль орчны тухай хууль хир уялдаа холбоо бүхий хэрэгждэг вэ?</p>	<p>Байгаль орчны хуулиудын хэрэгжилт, нийгэм-эдийн засгийн хөгжлийн нөхцөл, байгаль хамгааллын төвшин, тэдгээрийн өнөөгийн төлөв байдлыг үнэлэх, цаашид анхаарлд авах шаардлагатай секторуудыг тодорхойлох зорилгоор 2005 онд НҮБ-ын ХХ-өөс “Монгол орны экологи, эдийн засгийн эмзэг байдаг, хүний аюулгүй байдлын судалгаа” төслийг хэрэгжүүлэн байгаль хамгааллын хуулийн хэрэгжилтийн талаар дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - The policies set the stage for program design, implementation and enforcement, but little was implemented and regulations were not enforced - Many of the stated policies and the required regulations

	<p>are already in place but not enforced. It is better to enforce what is in place rather than invent new policies. Examples of unenforced regulations include the use and conservation of forest resources, the protection of protected areas, the management and disposal of waste, effluent treatment, the restoration of land after minerals extraction, and the implementation of environmental impact mitigation measures. Failure to implement and ensure compliance with programmes (enforcement as necessary) is also a waste of resources.</p> <p>Эх үүсвэр: “Монгол орны экологи, эдийн засгийн эмзэг байдаг, хүний аюулгүй байдлын судалгаа” НҮБ-ын ХХ. Улаанбаатар, 2005</p>
<p>What progress has been achieved in the enforcement of environmental laws relating to desertification?</p> <p>Цөлжилттэй холбоотой байгаль орчны тухай хуулийг хэрэгжүүлэхэд ямар дэвшил гаргасан бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Усны тухай хуулийн 12.21 дүгээр зүйлд заасны дагуу усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан “Усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж байна. - Ургамлын нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн оролцоотой байгуулан экологи-эдийн засгийн үнэлгээний суурь аргачлалыг боловсруулж эхлээд байна.
<p>What are the specific institutional and human resources capacity needs in order to improve proper law enforcement?</p> <p>Холбогдох хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд ямар зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхийн хэрэгцээ байна вэ?</p>	<p>Цөлжилттэй тэмцэхтэй холбогдох хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хэрэгцээтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны хууль, эрхзүйн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх чиглэлд - Байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын эрхзүйн орчинг боловсронгуй болгох чиглэлд оролцоо оролцооны хувийг нэмэгдүүлэх чиглэлд - Иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс байгаль орчны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих чадавхийг бэхжүүлэх
<p>What progress has been made on land tenure issues since the last report?</p> <p>Хамгийн сүүлчийн тайлангаас хойш газар эзэмшлийн асуудлыг шийдвэрлэхэд ямар</p>	<p>2000 оноос “Газрын тухай багц хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-иудыг УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам, Газрыг тусгай хамгаалалтанд авах, гаргах журам, Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам, Газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журмыг баталж, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд</p>

<p>өөрчлөлтүүд гарсан бэ?</p>	<p>хэмжээг тогтоосон. 2000-2003 онд гэр орон сууц, хашааны 194856, хадлангийн 19063, тариалангийн газар эзэмшигч, ашиглагч 16824 иргэдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулсан. “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль батлагдан гарсантай холбогдуулан 2003 оны жилийн эцсийн байдлаар 16379 иргэний газар өмчлөх эрхийг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр баталгаажуулаад байна.</p> <p>Эх үүсвэр: МУ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт. 2000-2004</p>
<p>Have measures been taken to strengthen the capacity of local populations and local authorities to participate in decision making which is relevant to combating land degradation?</p> <p>Газрын доройтолтой тэмцэхтэй холбоотойгоор орон нутгийн иргэд, орон нутгийн өөрөө захирах байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд ямар арга хэмжээ авсан бэ?</p>	<p>2000-2003 онд 115 сая га буюу улсын нийт бэлчээрийн 92 хувьд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулав. 2004 онд 9.6 сая га бэлчээрийн талбайд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэснээр орон нутгийн хэмжээнд бэлчээр, газрын төлөв байдлын мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлэн дүгнэх цаашид газрын доройтол, цөлжилттэй тэмцэх ажлыг төлөвлөх боломжоор орон нутгийн захиргаадыг хангасан.</p> <p>Ард иргэдийг шинэ тутам батлагдаж буй хууль, журамыг танилцуулах, тэдгээрийн мөн чанарыг мэдүүлэх зорилгоор МУ-ын Засгийн Газрын харъяа Парламентийн телевизийн сувгийг нээн ажиллуулж байна. Үүнээс гадна МУТВ-эд “Хуулийн цаг”, ТВ3 сувагт “Монгол Улсаа хөгжүүлэе”, ТВ9 сувагт “Хуулийн цаг” зэрэг нэвтрүүлгүүдийг бэлтгэн гаргаж байна.</p> <p>Эх үүсвэр: МУ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт. 2000-2004 ТВ сувгуудын хөтөлбөр</p>
<p>What are the needs for awareness raising among the local population for an improved compliance to new legislation?</p> <p>Шинэ хууль, эрхзүйн баримт бичгийг дагаж мөрдөхөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна вэ?</p>	<p>Шинэ хууль, эрхзүйн баримт бичгийг дагаж мөрдөхөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - байгаль орчны хууль, дүрэм журмын мөн чанарыг орон нутагт таниулах, сурталчилах үйл ажиллагаанд олон нийтийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх - иргэдэд хуулийн хэрэгжилтэнд хяналт мониторинг тавих эрхзүйн орчинг бүрдүүлэх - иргэдийн хууль, дүрэм журмыг мөрдүүлэх урамшууллын тогтолцоог бий болгох - байгаль орчны хууль тогтоомжуудтэдгээрийн ач холбогдлын талаар боловсролын хөтөлбөр боловсруулан хүүхэд, залуучуудыг сурган хүмүүжүүлэх
<p>Does the NAP foresee particular projects that deal with law enforcement relating to the combat</p>	<p>Үгүй</p>

<p>against desertification?</p> <p>Цөлжилттэй тэмцэх хуулиудын хэрэгжилтийг биелүүлэхтэй холбоотой төсөл хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг ҮҮАХ-т урьдчилан харсан уу?</p>	
<p>What are the procedures for identifying and implementing such measures?</p> <p>Энэ төрлийн арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх ямар үе шатууд байдаг вэ?</p>	<p>Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг дараах үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - холбогдох яам, агентлаг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах - үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн яам, агентлаг нь холбогдох хэрэгжүүлэгч байгууллага, орон нутгийн өөрөө захирах байгууллага, ТББ-ын үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх - Үндэсний түвшинд тодорхой сэдвүүдээр сар, улирал, жилийн аян зохион байгуулах

v. Үндэсний Үйл Ажиллагааны Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо, ялангуяа иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, иргэдэд түшиглэсэн байгууллагуудын оролцооны явц

Effective participation of actors in defining national priorities	
5.1. Үндэсний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын идэвхитэй оролцоо	
<p>How effective are the participatory processes in the formulation and implementation of the NAP and its related activities?</p> <p>ҮҮАХ, түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд оролцооны үйл явц хир үр өгөөжтэй байна вэ?</p>	<p>Үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, ҮҮАХ, түүнийг хэрэгжүүлэхэд авч явуулж болох үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлэх явцад Засгийн газар, Төрийн бус байгууллагууд, Их, дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллийн оролцоог нэмэгдүүлж, өөр хоорондоо мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлэх, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор ҮЗХ-нд салбар бүрийн төлөөллийг оролцуулах болсон.</p> <p>Шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх төвшинд ҮЗХ өөрийн бие даасан статусыг хадгалан ирж оролцогч талуудан сонирхлыг дэмжих, тэдгээрээс гарсан үнэлэлт дүгнэлтийг бодит хэрэгжилт болгох бодлогыг баримтлан ирсэн. Хэдий тийм ч, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд үнэн зөв мэдээллээр ард иргэдийг хангах ажил төдийлөн системтэй хийгдэж чадахгүй байна. Цөлжилттэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн оролцоог дээшлүүлэхийн тулд сурталчилгааны хүрээг өргөтгөн эмэгтэйчүүд, залуучууд, хүүхэд, малчид, тариаланчид зэрэг олон нийтийн давхаргыг хамруулхад үйл ажиллагаагаа чиглүүлж байна.</p>
<p>What is the trend now in these processes, notably with respect to areas of the Declaration mentioned under (vii) below?</p> <p>Эдгээр үйл ажиллагааны өнөөгийн хандлага, ялангуяа VII хэсэгт дурьдсан Тунхаг бичигтэй уялдаатай үйл ажиллагаануудын хувьд ямар байна вэ?</p>	<p>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар иргэдийн санаачлага үйл ажиллагааг дэмжин зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэд олон нийтийн зөвлөл ажиллулан үйл ажиллагаанд нь мэргэжлийн зөвлөлгөө өгч байгаагийн зэрэгцээ уг зөвлөлийн дарга нарыг оролцуулан байгаль орчны тулгамдсан асуудлаар ярилцлага семинар зохион байгуулав. Мөн Байгаль орчны сайдын тушаалаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх иргэдийн санаачлага үйл ажиллагааг дэмжин зохицуулах зөвлөлийг Байгаль орчны сайдын дэргэд байгуулан ажиллуулж байна. Зөвлөл нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байгаль орчныг нөхөн сэргээх сан байгуулах, байгаль орчныг хамгаалах сурталчилгааны ажлыг нийтийг хамарсан хэлбэрээр явуулах, байгаль орчны сэдэвт төрөл бүрийн уралдаан зохион байгуулах, булаг шандыг тохижуулах улмаар ойн нөөцийн хамтын эзэмшлийн арга хэлбэр хэрэгжүүлэх зэрэг олон төрлийн ажлыг дэмжих туслалцаа үзүүлэн ажиллаж ирлээ.</p>

	<p>Энэ хугацаанд ҮҮАХ-ийн үндсэн бодлого газрын доройтол, цөлжилттэй тэмцэх, бэлчээр байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд ТББ, иргэний нийгмийн байгууллага, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлж иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын зарчмыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэж ирсэн. Ийнхүү “Иргэдийн оролцоотой байгаль хамгаалал” Шинэ Зеландын байгаль орчны хүрээлэн (ШЗБОХ), “Бэлчээрийн тогтвортой менежмент” ХХААЯ, Хөдөөгийн Ядуурлыг бууруулах IFAD зэрэг төслүүдийн хүрээнд малчдын бүлэг, малчдын ТББ, жижиг үйлдвэрлэлийг нээн ажиллуулах чиглэлийг баримталж ирлээ.</p> <p>Үүнээс гадна USAID-ийн үйл ажиллагааны хүрээнд “Говийн санаачлага” төслийг хэрэгжүүлэн гандуу бүсийн ард иргэдэд жижиг үйлдвэрлэл хөгжүүлэх замаар байгаль, хүний нөөцийг зохистой ашиглах, шинэ техник технологийг нэвтрүүлэх замаар хөдөөгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих ажлыг хийж байна.</p> <p>Мөн “Ногоон хэрэм”, “Ядуурлыг бууруулах” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн өөрөө удирдах байгууллага, ард иргэдийг татан оролцуулах, дээрхи хөтөлбөрийн үзэл санаа, хүлээж буй эерэг үр дүнгийн талаар ард иргэдэд таниулах ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна.</p> <p>Ийнхүү оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын зарчмыг цөлжилттэй тэмцэх үйл хэрэгт үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг тус улс хязгаарагдмал хүрээнд боловч тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна.</p>
<p>Is gender and the private sector dimension a specific element of any programme in the NAP?</p> <p>ҮҮАХ-ийн аль нэг хөтөлбөрийн тодорхой хэсэг нь жендер болон хувийн сектор мөн үү?</p>	<p>Өнөөдөр цөлжилтийн үйл явцад нэн тэргүүнд өртөж буй нийгмийн давхаргад эмэгтэйчүүд хүүхдүүд багтаж байна. Иймд цөлжилтийн үндэсний хөтөлбөрт цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг нэн ялангуяа цөлжилтөнд өртсөн нутаг дэвсгэрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүд хүүхэд залуучуудын үүрэг их болно хэмээн заасан байдаг. Үүнээс гадна өнөөдөр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүдийн байр суурийг нэмэгдүүлэх, тэдгээрийн эрх ашгийг хөндөхгүй байх талаар бүхий л салбарт яригдаж байгаа дурьдах нь зөв болов уу.</p> <p>Нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд төвлөрлийг сааруулах члэлийг ЗГ-аас баримталж хөдөөгийн хөгжилд чиглэгдсэн хэд хэдэн стратеги бичиг баримтыг боловсруулж ирсэн билээ. Энэ үүднээс Цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрт олон нийт, жижиг дунд бизнес эрхлэгчид болон хувийн сектортой нягт ажиллаж тэдгээрийн оролцоог хөхүүлэн дэмжих талаар тусган ажиллаж байна. Үүнээс гадна МУ-ын Засгийн Газраас 2005 оноос эхлэн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийг зарлан ажиллуулж хөдөө орон нутагт байгалийн нөөцийг ашиглах, байгальд ээлтэй</p>

	<p>газар тариаланг хөгжүүлэх жижиг төслүүдийг хэрэгжүүлж, бичил үйлдвэрлэлийн хөнгөлттэй зээлийг олгох зэрэг үйл ажиллагааг явуулж байна.</p>
<p>Has progress been made in developing, with the assistance of the private sector, appropriate technologies aiming at promoting sustainable land use practices in areas such as cash crop, livestock production, aquaculture, recreation, ecotourism, adherence to mining/extraction industries?</p> <p>Хувийн секторуудын тусламжтайгаар газар тариалан, мал аж ахуй, усны аж ахуй, амралт, аялал жуулчлал, уул уурхайн ба боловсруулах үйлдвэрлэлийг багасгах зэрэг чиглэлд тогтвортой газар ашиглалтын хэлбэрийг хангахуйц тохиромжтой технологи бий болгоход ямар дэвшил гарсан бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Ойн нөөцийг иргэдийн оролцоотойгоор хамгаалах зорилгоор 5 аймгийн хэмжээнд 40 хамтын эзэмшлийн ойн аж ахуйг байгуулав (“Хамтын эзэмшлийн ой” FAO, 2005). - Орон нутагт ашигт мод, сөөгний төрөл зүйлийг ургуулах, эдийн засгийн тогтвортой нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Олон Улсын Ротари байгууллагын шугамаар Өмнөговь аймгийн Даланзадгад, Булган, Өвөрхангай аймгийн Хархорин сумдад мод үржүүлгийн газруудыг байгуулав. Мөн төслийн хүрээнд ашигт мод, сөөгний плантац, ялангуяа чацарганы модыг ургуулан тогтвортой амьжиргааг бүрдүүлэх зорилгоор нийт 40 га талбайд чацарганы плантацийг Өвөрхангай аймгийн Хархорин суманд байгуулав. - Малчид, иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд 19.3 сая төгрөгийн шагналын сантай “Гар худаг” уралдааны болзол зарлаж орон даяр сурталчилсан. Энэ ажлын хүрээнд 2005 онд 350 гаруй гар худаг гаргаж бэлчээр усжуулалт ба малчдыг ундны усаар хангах ажилд нэмэр болов. - Бүх аймаг, нийслэлд эрчимжсэн болон хөдөө аж ахуйн загвар хоршоо бий болгож өргөжүүлэх зорилгоор 2000-2004 онд 66 аж ахуйд нийт 450.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосны үр дүнд нийтдээ 90 гаруй загвар хоршоо, фермерийн аж ахуй байгуулагдан ажиллаж байна.
<p>What are the capacity needs in order to maintain and/or establish a mechanism for active involvement of national and local stakeholders with regard to the planning and implementation of NAP activities?</p> <p>ҮҮАХ-ийг төлөвлөж хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн оролцогч талуудын</p>	<p>ҮҮАХ-ийг төлөвлөж хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн оролцогч талуудын идэвхитэй оролцоог нэмэгдүүлэхэд дараах чадавхийг бэхжүүлэх ажилбарууд хийгдэх шаардлагатай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - иргэдэд түшиглэсэн ямарваа нэгэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ нийгмийн сэтгэлзүйн судалгааг хийх аргачлалыг боловсруулах - орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын нэн ялангуяа орон нутгийн Байгаль орчны байцаагчийн чадавхийг бэхжүүлэх - цөлжилттэй тэмцсэнээр орон нутаг, иргэдийн амьдралд гарах эерэг үр дагаврыг ард иргэдэд зөв таниулах

<p>идэвхитэй оролцоог дэмжих буюу бий болгоход ямар чадавхитай байх шаардлагатай вэ?</p>	<ul style="list-style-type: none"> - иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нийгэм-эдийн засгийн хөшүүргийг бий болгох
<p>Examine the criteria used for selecting various actors in national priority identification processes. Үндэсний түвшинд нэн тэргүүний асуудлыг тодорхойлоход оролцогч талуудыг сонгоход ашигласан шалгууруудыг үнэл?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх төвшний төлөөллийг эрх тэгш оролцуулах боломжийг хангахад дараах шалгуур үзүүлэлтүүдийг илүүц хэмээн тодорхойлсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхэд үүрэг гүйцэтгэж байсан туршлага - Цөлжилтийн асуудал, түүнтэй тэмцэх ажилд оролцож байсан туршлага - Тухайн улс, орон нутгийн экологийн тулгамдсан байдал, тэдгээрийг шийдвэрлэх талаар бодит мэдээлэлтэй, шийдвэр гаргах чадвартай - Байгаль орчны хууль эрхзүйн орчныг судалж мэдсэн, тодорхой туршлагатай - Байгаль орчин ба нийгэм-эдийн засгийн тогтолцооны асуудлуудыг таньж мэдсэн - Засгийн газрын үзэл бодлыг төлөөлөх чадвартай - Иргэний нийгмийн эрэлт хэрэгцээг бүрэн илэрхийлэх чадвартай (иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог).
<p>Do the criteria encourage equal representation at all levels? If not, what is being done to ensure equal representation? Энэ шалгуур нь бүх түвшинд эрх тэгш төлөөллийг гаргаж ирэх үү? Хэрэв үгүй бол эрх тэгш төлөөллийг хангахын тулд юу хийгдэж байна вэ?</p>	<p>Энэхүү шалгуур нь шийдвэр гаргагч болон олон нийтээс гарах эрэлт хэрэгцээг бүрэн гүйцэлдүүлж чадна.</p>
<p>How well is the national scientific community represented and what monitoring mechanisms have been established with its assistance? Үндэсний шинжлэх ухааны төлөөлөл хэр сайн оролцсон</p>	<p>Шинжлэх ухааны холбогдох байгууллагуудын төлөөллийг ҮЗХ-нд хамруулан ажиллаж ирсэн бөгөөд тэргүүлэх судлаачид төдийлөн олонгүй учраас төлөөлөл харьцангуй бага хэмээн дүгнэж байна. Хэдий тийм ч шинжлэх ухааны байгууллагаас үндэсний хөтөлбөр гаргах, түүнд шинжлэх ухааны агуулгыг оруулах, цаашид шинжлэх ухаанд суурилсан онол-практикийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажилд тухай бүр оролцуулахын зэрэгцээ Үндэсний зөвлөлдөх хурал, ҮҮАХ-ийн бодит биелэлтийг үнэлэх, дүгнэх, зөвлөлгөө өгөх ажилд эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулж байна.</p>

<p>болон тэдний тусламжтайгаар хяналтын ямар механизм бүрдсэн бэ?</p>	<p>Тухайлбал, сүүлийн 5 жилийн хугацаанд Цөлжилтийн Судалгааны төвд “Говь хээрийн бүсийн цөлжилтийг сааруулах шинжлэх ухаан, технологийн үндэслэл” (2001-2004) төслийн хүрээнд гандуу бүс нутгийн нийт 3 аймгийн 5 сумын хэмжээнд цөлжилтийн үйл явцад шинжлэх ухааны дүгнэлт өгөх, шинжлэх ухаанд суурилсан цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг анхлан хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн. Хяналтын тогтолцоонд ямарваа нэг өөрчлөлт төдийлөн гараагүй бөгөөд шинжлэх ухааны байгууллага нь шийдвэр гаргагчид ба хэрэгжүүлэгчдэд зөвлөмж өгөх, үйлдвэрлэлийн туршилт тавих хүрээнд ажиллаж байна.</p>
<p>Has a mechanism been put in place to ensure continuous consultations?</p> <p>Тухайн механизм эрдэмтдийн байнгын зөвлөгөөг хүлээн авч байхуйцаар бүрдэж чадсан үү?</p>	<p>Шийдвэр гаргагчдын түвшинд шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын зөвлөмжийг шийдвэр гаргах үндэслэл болгох нь учир дутагдалтай тул гарсан хууль тогтоомж амьдралд хэрэгжихдээ дутмаг байна.</p>
<p>To what extent has the traditional knowledge system been used in exchange, circulation, transfer and dissemination of information?</p> <p>Мэдээллийг солилцох, түгээхэд уламжлалт мэдлэгийн тогтолцоо ямар хэмжээгээр оролцож байна вэ?</p>	<p>Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх ард иргэдийн ухамсарт үйл ажиллагаа, уламжлалт арга алдагдсан учраас түүнийг сэргээх тогтолцоо болгон хэвшүүлэх шаардлагатай боловч цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх мэдээллийг солилцох түгээхэд уламжлалт мэдээлэх суурь тогтолцоо болж байна.</p>
<p>Does traditional knowledge/technology play a role in the framework of the NAP?</p> <p>ҮҮАХ-ын хүрээнд уламжлалт мэдлэг/технологи ямар нэг үүрэг гүйцэтгэх үү?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-ийн хэрэгжилтэнд уламжлалт мэдлэг, арга барил тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Гэдээ өнөөгийн экологи, нийгэм, эдийн засгийн харилцааны түвшинд тэдгээрийн оролцооны хувь, ач холбогдол нь харьцангуй багассан нь дасан зохицох чадвар муу байгаатай холбоотой юм. Тухайлбал, уул ус тахих, газар хөндөхгүй байх, ургамал таслахгүй байх, шинээр зам гаргахгүй байх, усанд улаан, цагаан юм дусаахгүй байх г.м.</p>
<p>Have linkages with educational centres or governmental institutions responsible for education been established in order to promote environmental</p>	<p>Байгаль судлал, экологи-байгаль хамгааллын чиглэлээр бүх шатны сургалтын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, бүх нийтэд экологийн боловсрол олгоход чиглэсэн бие даасан хичээлийг бий болгох хөтөлбөр төлөвлөгөөг холбогдох яамд, ЗГ-ын захиалгаар боловсруулсан ба үүний дүнд дунд сургуулиуд болон их, дээд сургуулиудын мэргэжлийн бус ангиудад экологийг хичээлийн хөтөлбөрт</p>

<p>education relating to the combat against desertification?</p> <p>Цөлжилттэй тэмцэх байгаль орчны боловсролыг сайжруулахад боловсролын төв болон засгийн газрын байгууллагуудтай холбогдох холбоо тухайн олгох мэдлэгийг бий болгох үүрэгтэй юу?</p>	<p>зайлшгүй үзэх болгон хэвшүүлэн ажиллаж ирсэн.</p> <p>Мөн аймаг, сумдын дунд сургуульд түшиглэн экологийн боловсролыг төвүүдийг байгуулан ажиллуулах бэлтгэл ажлыг гүйцэтгээд байна. Нийтийн экологийн сургалтанд зориулан “Монгол орны говь” нэртэй гарын авлагыг “Их говийн судалгаа” олон улсын төслийн санхүүжилтээр захиалан хэвлүүлсэн. НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Монгол дахь Үндэсний Комисстой хамтран дээрхи байгууллага болон НҮБ-ын ЦТК-ийн хамтран хэвлүүлсэн -Цөлжилттэй тэмцэх багш сурагчдад зориулсан гарын авлага”-ыг монгол хэлнээ хөрвүүлэн нийтийн хүртээл болгосон.</p> <p>Ардын болон шашны уламжлалт зан үйлийг байгаль хамгаалах хэрэгсэл болгон ашиглах бодлого баримтлан “Шашин ба байгаль хамгаалал” олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион явуулж байна.</p> <p>Экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Монголын багш нарын холбоо”, “Биологийн багш нарын холбоо”, Монгол орны байгаль орчны консорциум зэрэг ТББ-тай болон Швейцарийн Хөгжил-Хамтын Ажиллагааны Агентлагтай экологийн сурах бичиг боловсруулах ажлууд дээр хамтран ажиллаж байна.</p>	
<p>What are the mechanisms adopted to ensure that various categories of actors are involved in the process to provide information as well as to benefit from information networks?</p> <p>Оролцогч талууд мэдээллээр хангах болон уг мэдээллийн сүлжээг ашиглах үйл явцад хамрагдаж чадахуйц ямар механизмууд ашиглагдсан бэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны мэдээ мэдээллийг бэлтгэх “Байгаль орчин” теле-студийг байгуулан ажиллаж “Эко-дуран” нэвтрүүлгийн хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. • Үндэсний радио долгионоор Малчдын мэдээ булангаар тухай бүр байгаль орчин, холбогдох байгаль орчны асуудлаар цуврал нэвтрүүлгүүдийг бэлтгэн цацаж байна • Үүнээс гадна үндэсний сонин, сэтгүүлээр тухай бүр цөлжилт, түүнтэй тэмцэж буй ажлын үр дүн, хэрэгжиж буй төслүүд, ололт амжилт, учирч буй бэрхшээлүүдийг нийтэд таниулж мэдээлж байв. <p>Мэдээллийг бэлдэх ажил нь нэгдсэн байгууллагагүй байгаа хэдий ч цөлжилтийн асуудлаар холбогдон ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд өөрийн ажил үүргийн тогтолцоонд дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэж байна.</p>	
<p>Have participatory awareness campaigns been conducted dealing with the following themes?</p> <p>Доорхи сэдвүүдээр оролцогсдод хүртээл болгох компани т ажил хийгдсэн үү?:</p>	<p>(i) growing threat to ecosystems and sustainable livelihoods under a scenario of increasingly extreme climatic events</p> <p>(i) Уур амьсгалын гэнэтийн үзэгдлүүд олширч байгаа үед экосистем болон тогтвортой амьжиргаанд нүүрлэж буй аюул нэмэгдэж байна</p>	<p>X</p>
	<p>(ii) advocacy for participatory rural development as a key element in</p>	<p>X</p>

	<p>poverty eradication (ii) Ядуурлыг бууруулхад хөдөөгийн хөгжил түлхүүр элемент болох талаархи хүмүүсийн үзэл бодол</p>	
	<p>(iii) recognition of the widespread downstream geopolitical consequences of phenomena such as forced migrations and conflicts (iii) Хүчээр нүүлгэх, зөрчилдөөн үүсгэх зэрэг үзэгдлийн эцсийн шатны, нийтийг хамарсан геополитик үр дагаварыг ойлгох</p>	<p>Монгол оронд хөдөөгөөс хот руу чиглэсэн “Нүүдэл” үргэлжилнэ. Хот суурин газарт хүн амын механик төвлөрөл ихсэж байгаа нь байгаль хамгаалалд сөрөг үр дагавар болж, төв суурины нутаг дэвсгэрт цөлжилт үүсэх шалтгаан болж байна. Иймээс хүн амын төвлөрлийг сааруулах, байршлыг жинд болгох, нийтийг хамарсан геополитикийн үр дагаврыг сайжруулах бодлого болно. Хөдөөгийн малчдын дунд явуулсан олон удаагийн судалгаагаар хөдөөгийн хөгжлийг дэмжих бодлого нь ядуурлыг бууруулах түлхүүр элемент мөн болох нь батлагдаж байна.</p>
	<p>(iv) the prevention of land degradation is more cost-effective than suffering the severe consequences of desertification (iv) цөлжилтийн үр дагаварт нэрвэгдэн амьдарснаас газрын доройтолтой тэмцэх нь илүү үр ашигтай</p>	<p>Тийм</p>
<p>How are the concerns and results of the national consultations at the local level incorporated into the NAP? Орон нутгийн түвшинд хийсэн үндэсний зөвлөгөөнөөс гарсан асуудал, үр дүн ҮҮАХ-т хэрхэн тусгагдсан бэ?</p>	<p>(v) dissemination of lessons learned and best practices (v) олсон туршлага, ололт амжилтаа бусдад түгээх</p>	<p>Х</p>
<p>Have there been any follow-up activities to ensure continuous feedback from</p>	<p>Үндэсний хэмжээний зөвлөлдөөний үр дүнг орон нутгийн түвшинд 1995, 1997, 1998, 1999, 2000, 2002, 2003 оны эхээр цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах, нарийвчлах, үнэлгээ, дүгнэлт өгөх болон газар, ус, ойн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар цувралт сургалт-семинар зохион байгуулж үндэсний хэмжээний асуудлыг хэлэлцэхэд нийслэл хот, 21 аймгийн төлөөлөгчдийг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулав. Эдгээр зөвлөлдөөний үр дүнд цөлжилттэй тэмцэх орон нутаг, үндэсний чадавхиыг бэхжүүлэх, цаашид цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрт судалга шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлэх, орон нутгийн төвшинд практик арга хэмжээг олон нийтэд түшиглэсэн байгаль хамгааллын зарчимд тулгуурлан авч хэрэгжүүлэх зэрэг бүлэг асуудлууд хөндөгдсөн бөгөөд шинээр батлагдсан ҮҮАХ-т эдгээр асуудлууд тодорхой хэмжээнд тусгалаа олсон (refer to NAP).</p>	<p>ҮҮАХ-ийн хэрэгжих хугацаа дуусаагүй байгаа.</p>

<p>stakeholders even after completion of the NAP?</p> <p>ҮҮАХ дууссан ч гэсэн оролцогч талууд үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар үргэлжлүүлж ирсэн үү?</p>	
<p>What is the modality for designating the representatives of various social and institutional categories, at both national and local levels, (nomination, election etc.)?</p> <p>Орон нутгийн болон үндэсний түвшинд нийгмийн үе давхрага болон эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллийг сонгох ямар арга хэлбэр байдаг вэ? (нэр дэвшүүлэх, сонгууль зэрэг)</p>	<p>Орон нутгийн болон үндэсний түвшинд нийгмийн үе давхрага болон эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллийг ҮЗХ болон БОЯ-наас томилон ажиллуулдаг. Энд нийгмийн давхарга болон судалгаа шинжилгээний байгууллага, судлаач, эрдэмтдийн төлөөллийг аль болохоор өргөн хамруулахыг эрмэлздэг боловч орон нутгийн түвшинд тэр бүр төлөвшөхгүй байна.</p>

vi. ҮҮАХ-ыг боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөлдөөний үйл явц ба хөгжингүй орон-талууд, сонирхлын бүлэг бусад байгууллагатай байгуулсан түншлэлийн гэрээ, ялангуяа орон нутгийн болон олон улсын нөөцийг татах, зохицуулахад

Effective support from international partners for cooperation	
6.1. Хамтран ажиллагч олон улсын байгууллагуудын үр ашигтай дэмжлэг тусалцаа	
<p>What new measures have been taken by the Government to ensure the involvement of international partners in the process and what is the extent of their involvement?</p> <p>Үйл ажиллагаанд олон улсын түншүүдийг татан оролцуулахын тулд засгийн газар ямар арга хэмжээ авсан ба тэдний оролцооны хамрах хүрээ юу вэ?</p>	<p>МУ-ын ЗГ-аас ҮҮАХ-г хэрэгжүүлэх, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд засгийн газар, олон улсын байгууллага хоорондын дараах гэрээг байгуулан ажиллаж ирлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БНСУ-тай 2006-1-17-нд байгуулсан “Цөлжилттөөс урьдчилан сэргийлэх” - 2000-8-28-нд Монгол улсын Байгаль орчныг хамгаалах алба, Япон улсын Хиого мужийн Байгаль орчны холбооны хооронд Ойн салбарт хамтран ажиллах тухай тохиролцоо - 2000-12-21-нд Германы Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс Байгаль хамгаалал ба орчны бүсийн хөгжил төслийн үйл ажиллагааны хүрээнд зээл олгох гэрээ - 1999-12-06-нд Монгол улсын Байгаль орчны яам, Нидерландын Вант улсын Хөгжлийн хамтын ажиллагааны яамд хоорондын Байгаль орчны итгэмжлэгдсэн сан байгуулах тухай санамж бичиг зэрэг нийт 20 гаруй гэрээ, хэлэлцээр, тохиролцоог байгуулжээ. <p>Эдгээр гэрээ нь цөлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх, байгаль хамгааллыг орон нутагт хөгжүүлэх санхүүгийн дэмжлэг авах, байгаль хамгааллын орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зэрэг хүрээг хамарч байна.</p>
<p>What kind of support for a national consultative mechanism has come from relevant international</p>	<p>The conference, on Legal and Administrative Status of Protected Areas in Mongolia - Past, Present and Future, was jointly organized by the United Nations Development Programme (UNDP) and the World</p>

<p>organizations?</p> <p>Бусад холбогдох олон улсын байгууллагуудаас үндэсний зөвлөх механизмыг боловсронгуй болгох ямар дэмжлэг үзүүлсэн бэ?</p>	<p>Wildlife Fund (WWF). The conference noted Mongolia's Protected Area Network is the major means to protect the country's biodiversity thus ensuring that the country's rich natural heritage is available for future generations. Among the recommendations being forwarded to Government, the conference urged the following:</p> <ul style="list-style-type: none"> • The Protected Area Master Plan should be implemented as planned. Proposed extensions of protected areas should be integrated with other local and national development plans. • Environmental impact assessments (EIAs) should be conducted as required, both for specific projects and for general development plans. These EIAs should be open to the public and final decisions should not be made without broad consultations with concerned stakeholders. <p>UNDP and other UN agencies have pledged to support Mongolia's National Programme on Good Governance for Human Security, publicly launched in the State Palace, Ulaanbaatar on 10 January 2001. The four year Programme's objective is the formulation and implementation of national policies based on broad consensus in four component areas: economic transition, equity and social policy, environment and sustainable development, and sound governance. These components principally will work through mission-specific, time-bound, ad hoc working groups that will allow for the participation of major actors and stakeholders, as well as for broad-based consultations. It also seeks a more effective use of national resources and channeling of external cooperation in support of the formulation and implementation of the top national priorities.</p> <p>GEF Awareness workshop organized jointly by UNDP Mongolia and Asia Pacific Regional Unit of UNDP/GEF the starting point of which aims to strengthen country ownership and involvement in GEF co-financed projects as well as to build capacity of GEF national focal points through this multi-stakeholder dialogue process. This is the first GEF National Dialogue Initiative being organized.</p> <p>TNC organized workshop on "Conservation by design" for national conservationists for capacity building on initiating planning and implementing nature conservation activities.</p> <p>Эх үүсвэр: http://www.undp.mn/</p>
---	---

	http://www.nature.org/
<p>Has conclusion of a partnership agreement been achieved?</p> <p>Хамтын ажиллагааны гэрээг дүгнэсэн үү?</p>	<p>ЗГ ОУ байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг жил бүр дүгнэн ирсэн.</p>
<p>How many partners are there, and which of them specifically support the NAP process? Explain, as appropriate, the role of Global Environment Facility (GEF), its implementing/executing agencies and of the Global Mechanism (GM).</p> <p>Хамтын ажиллагааны гэрээтэй хэдэн байгууллага байдаг ба тэдгээрээс аль нь ҮҮАХ-ийн хэрэгжилтийг онцгойлон дэмждэг вэ? Тухайлбал: Даян Дэлхийн Байгаль Орчны САН (ДДБОС)-ын, түүний хэрэгжүүлэгч агентлагийн үүрэг роль, , Глобал механизм (ГМ)-ын талаар тайлбарлах</p>	<p>Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан улс орон, ОУ байгууллагуудын тоонд Казахстан, Киргизстан, БНСУ, Япон Улс, Герман, НҮБ-ын ХХ, ДДБОС, WWF, GTZ, Nyogo Environmental Agency, JICA, FAO, ADB, IFAD зэрэг болно.</p> <p>Эдгээрээс ҮҮАХ-ийг хэрэгжүүлэхэд БНСУ, Японы ЗГ-уудын зүгээс цөлжилттэй тэмцэх практик арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах чиглэлээр олон тооны жижиг төслүүдийг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Японы ЗГ, ТББ-уудын шууд санхүүжилтээр Хього Байгаль Орчны Агентлагаас ойг нөхөн сэргээх; цөлжилт, бэлчээрийн доройтлын судалгаа; Киотогийн Их Сургуулийн Экологийн Судалгааны Төвөөс Туул голын усны бохирдлын мониторинг, мөн байгууллагаас элэгдэж эвдэрсэн газрын чанарын - БНСУ-ын ЗГ, ТББ-уудын шууд санхүүжилтээр: NEAFF “Цөлжилттэй тэмцэх ба ойжуулах” - Олон Улсын Атомын Энергийн Агентлаг “Орхон голын усны бохирдлыг изотопын аргаар судлах” төсөл
<p>How well does this match the national need for international support in order to implement the Convention?</p> <p>Эдгээр нь Конвенцийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын дэмжлэгийг авах үндэсний хэрэгцээнд нийцэж байна уу?</p>	<p>Эдгээр төсөл, гэрээний үйл ажиллагаа нь цөлжилтөнд тэр бүр шууд чиглэгдэн ирээгүй боловч Конвенцийн ерөнхий зорилго цөлжилтөнд өртөмтгийн, өртөж болзошгүй байгалийн бүс бүслүүрийн хэмжээнд цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилтыг биелүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. Хэдий тийм ч Конвенцийн цогц үзэл санааг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй байгааг дурьдахын сацуу эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүх шатны байгууллага, нийгмийн давхаргыг чадавхижуулах, үйл ажиллагааг дасан зохицуулах зэрэг үйл ажиллагаа өнөөг хүртэл хөндөгдөөгүй ирсэн.</p>
<p>To what extent have traditional and alternative sources of finance been successfully generated for the</p>	<p>Монгол улс нь олон улсын байгууллагууд болон өндөр хөгжилтэй орнуудын засгийн газруудаас ган, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах талаар арга хэмжээг авч явуулах санхүү, техникийн</p>

<p>implementation of the NAP, and what are the main obstacles to this?</p> <p>ҮҮАХ-ийг хэрэгжүүлэхэд санхүүгийн уламжлалт болон нэмэлт эх үүсвэрүүдийг хэрхэн бүрдүүлж ирсэн ба үүнд ямар бэрхшээлүүд тулгарсан бэ?</p>	<p>дэмжлэг хүссэн төслийн 20 гаруй саналыг боловсруулж 2002-2004 онуудад илгээсэн бөгөөд Засгийн газрын энэхүү идэвхитэй ажиллагаа болон олон улсын хамтын нийгэмлэгийн тусламж дэмжлэгээр нийт дүнгээрээ 24.6 сая ам долларын 12 төслийг энэ хугацаанд үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна. Үүнээс гадна Засгийн Газар 2000 оны 52-р тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг баталсан. 2003 оноос улс, орон нутгийн төсөвт байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг тусгах арга хэмжээг зохион байгуулж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 467.5 сая төгрөг, ойжуулалт, ойн арга хэмжээнд 521.0 сая төгрөг, орон нутагт хэрэгжүүлж буй байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд анх удаа 549.9 сая төгрөг төсөв батлуулсан байна. 2004 онд энэ төсвийн хэмжээ 18038.5 сая төгрөг болтол өссөнөөр МУ ЗГ цөлжилт, байгаль хамгааллын чиглэлд хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийг тогтвортой эх үүсвэрээр хангах чиглэлд ажил эхлүүлж буйг илтгэнэ.</p> <p>Санхүүгийн төрөл бүрийн эх үүсвэрийг татан оролцуулахад дараах бэрхшээлүүд тулгарч байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдыг хязгаарлагдмал хүрээнд ажиллахад хүргэж байна. - Хөрөнгө оруулалтын эрхзүйн орчин, түүнийг хянах, зохистой удирдан зарцуулах тогтолцоо төдийлөн чадавхижаагүй нь хандивлагчдын хэмжээнд МУ талаархи үнэлэмжийг бууруулаж байна. Тухайлбал, ДДБОС-ын улс орнуудын санхүүжүүлэх ангилалаар МУ 1000 ам.долларын санхүүжилт авах орнуудын тоонд багтсан байна. - Хандивлагч орнууд хөрөнгө оруулалтыг ЗГ-аар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд ЗГ-аас тодорхой хувийн санхүүжилтийг гаргах шаардлагыг тавидгаас зарим хөрөнгө оруулалт нь МУ санхүүгийн боломжид нийцдэггүй шалтгаанаар
---	--

	<p>хөрөнгө оруулалтын хугацаа хойшлох/буцах тохиолдол бий.</p> <p>-</p>
<p>Have steps been undertaken to move from the conclusion of partnership agreements to actual implementation?</p> <p>Хамтын ажиллагааны гэрээг ажил хэрэг болгон хэрэгжүүлэх алхамууд хийгдсэн үү?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх ажлыг бүс нутгийн хэмжээнд эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх Ази номхон далайн бүсийн 6 сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээний (СХС) “Гангийн нөлөөг бууруулах, цөлжилттэй тэмцэх чадавхи бүрдүүлэх” 5 дугаар сэдвийг Монгол улс хариуцах тухай хүсэлт гарган, 2003 оноос хэрэгжүүлж байна.</p> <p>Монгол улсын Засгийн газар, ЦТҮХорооноос ХБНГУ-ын санхүү, техникийн туслалцаагаар урт хугацааны “Цөлжилтөөс сэрэмжлэх менежментийн систем”, “Ойг хамгаалах ойжуулах” төслийг говийн бүсийн хоёр аймаг 2001 оноос эхний хагас жилд эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж бэлтгэл судалгааны ажлыг хийж байна.</p>
<p>Has a country agreed to become <i>chef de file</i> of the consultative process?</p> <p>Зөвлөх үйл явцаас танай орон <i>chef de file</i> болохыг зөвшөөрсөн үү?</p>	
<p>Is there a calendar of activities to ensure continuous process monitoring?</p> <p>Хяналтын үйл явцыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа юу?</p>	<p>Байгаа</p>
<p>Is there a consultative mechanism established among partners at the national or local levels?</p> <p>Орон нутгийн болон үндэсний түвшинд оролцогч талуудын зөвлөлдөх механизм бий юу?</p>	<p>Байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх, тогтвортой хөгжлийн бодлого, төслийн санал боловсруулах, баримт бичиг бэлтгэхэд Засгийн газрын холбогдох байгууллага бүрийн төлөөлөл, олон улс, хандивлагч орнуудын төлөөлөгчид оролцон санал солилцдог, зөвлөгөө өгдөг механизм тогтов.</p> <p>Монгол улсын Засгийн газар Түнш орнуудын үйл ажиллганы уялдаа холбоог сайжруулах чиглэлээр энэ бүлгийн эхэнд дурьдсан хандивлагчдын уулзалт, хоёр талын гэрээ, хэлэлцээрээс гадна манай улсад үзүүлж байгаа зээл тусламжийн зохицуулалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор сэдэвчилсэн уулзалтуудыг түншлэгч орнуудын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн бөгөөд анхны уулзалтыг “Засаглалын асуудал ба зээл тусламж” сэдвээр зохион байгууллаа. Цаашдын төлөвлөгөөнд “Байгаль орчин,</p>

	түүний тулгамдсан асуудлууд” сэдэв тусгагдсан бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь цөлжилттэй тэмцэх ажилд түншлэгч орнуудыг улам идэвхитэй татан оролцуулах, хоорондын үйл ажиллагааг зохицуулах, зөвлөлдөх механизмын нэг хэлбэр болж байна.
What are the frequency of meetings, the level of attendance and the degree of participation? Уулзалт зөвлөлтөөний тоо, ирц, оролцооны ямар байдаг вэ?	Оролцооны төвшин, ирцээс хамааран уулзалтын тоо жилд 2-3 удаа байдаг бөгөөд төлөвлөлөтийн, биелэлтийн үе шатуудыг хэлэлцэх асуудлыг бүх оролцогч талуудыг хамруулан ажиллаж байна.
What is the distribution of roles and tasks among the various partners? Хамтрагсдын үүрэг хариуцлагын хуваарилалт ямар байдаг вэ?	Шинжлэх ухаан, техникийн хүрээний төлөөлөл нь хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн техник, технологийн үнэлгээг өгөх үүргийг хүлээн ажиллах бөгөөд цаашид авах арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулан хөтөлбөрт тусгах үүргийг хүлээн ажилладаг. Засгийн газар, шийдвэр гаргагчдын төвшинд холбогдох яамдын төлөөлөл болон ТББ-ын оролцоог чухалчлан авч үзэж ажиллаж ирлээ.
How do the NFP and NCB participate in the discussions? ҮЗХ болон ҮЗ зөвлөлдөх хуралд хэрхэн оролцдог вэ?	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явцын хэлэлцүүлэг уулзалт, зөвлөлдөөнийг зохион байгуулах, удирдан явуулах үүргийг ҮЗХ, ҮЗ хариуцан ажилладаг бөгөөд тэдгээрийн оролцооны хувь өнөөг хүртэл хангалттай хэмээн тооцогдож ирсэн.
What capacity needs exist in order to maintain the exchange of information with regard to internal consultations? Гадаадын зөвлөлдөх хурлуудын тухайд мэдээлэл солилцох чадавхийн сайжруулах ямар хэрэгцээ байна вэ?	Зөвлөлдөх уулзалтуудын үр дүн, дэвшүүлсэн асуудал, гарсан үрдүн, үндэсний болон орон нутгийн төвшинд гаргах санал зэрэг мэдээллийг солилцох, тэдшээрт дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэхэд дараах эрэгцээ шаардлагууд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Үндэсний үйл ажиллагааг олон улсад таниуцлах, тэдгээрээс гарсан эерэг үр дагавар, олсон сургамж, хуримтлуулсан туршлагыг бүс, дэд бүсийн хэмжээнд таниулах орчин үеийн мэдээлэл технологийн хөгжилд суурилсан мэдээлэл солилцооны аргуудыг хэрэглэх - Мэдээллийг чанаржуулах буюу мэдээллийн нэгдсэн форматтай болох - Мэдээлэл технологийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх
In what manner can the UNCCD secretariat and the Global Mechanism assist in facilitating the	Цөлжилттэй холбогдсон асуудлаар семинар зөвлөлтөөн зохион байгуулах, түүний үр дүнг нийтэд сурталчилахад цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны нарийн бичгийн дарга, НҮБ, UNDP, Даян

<p>convocation of the consultative processes?</p> <p>Зөвлөгөөний үйл явцын чуулганы үйл ажиллагаа явуулахад нь ЦТҮК-ын нарийн бичгийн дарга, Глобал Механизм хэрхэн дэмжлэг үзүүлж чадах вэ?</p>	<p>дэлхийн байгаль орчны сан санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг.</p>
<p>Has the communication and exchange of information been established between the national GEF focal point, the implementing agencies of the GEF, and the NFP?</p> <p>ДДБОС, түүний хэрэгжүүлэгч агентлаг болон ЦТК-ийн үндэсний зохицуулагч ҮЗ нарын хооронд мэдээлэл солилцоо, харилцаа холбоо бүрэлдсэн үү?</p>	<p>Тийм</p>
<p>What difficulties have been identified in accessing funds through the GEF?</p> <p>ДДБОС –аар хөрөнгө оруулалт олоход ямар бэрхшээл тулгарч байна вэ?</p>	<p>Үндэсний чадавхийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Санал болгож буй төслүүдийн даян дэлхийн ач холбогдол (Global impact) төдийлөн сайн тодорхойлогдоогүй - Тогтвортой байдал ба төслийн дараагийн үе шатны саналыг боловсруулах ажил бараг хийгддэггүй - GEF-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн (operational program) мэдээлэл хомс байдгаас төслийн саналууд GEF-ийн стратегийн тэргүүлэх чиглэлд нийцдэггүй (2005 онд зохион байгуулагдсан GEF Awareness workshop-оос уг бэрхшээлийг арилгах талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийгдсэн) - GEF-ийн санхүүжилттэй урьд өмнө хэрэгжиж байсан төслүүдийг өөрийн болгох тал дээр идэвхи санаачлага дутмаг - GEF болон конвенциудын ҮЗ-ын хоорондын харилцаа холбоо сул

vii. Ган цөлжилтийн мониторинг хийх, үнэлгээ өгөх зорилгоор цөлжилттэй тэмцэх ҮҮАХ-ийн хүрээнд түүний дотор эдийн засгийн орчныг сайжруулах, байгалийн баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, цөлжилт, түүнд хяналт тавих мэдлэгийг дээшлүүлэх талаар төлөвлөсөн болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Adequate diagnosis of past experience	
7.1. Өмнөх туршлагад хийсэн дүн шинжилгээ	
<p>Has an exhaustive diagnosis or re-evaluation been made of past experience useful to the NAP process?</p> <p>ҮҮАХ-ийн хэрэгжилтэнд хэрэглэгдэхүйц дүн шинжилгээ, үнэлгээг өмнөх туршлагад тулгуурлан хийсэн үү?</p>	<p>ҮҮАХ-ийн эхний шатыг хэрэгжүүлэх явцад гарсан зохион байгуулалтын, хэрэгжилтийн болон хяналт мониторингийн талаархи туршлагыг үнэлж дүгнэн дараах хэд хэдэн асуудал дээр анхаарлаа хандуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - хөтөлбөрийг иргэдэд ойртуулах зорилгоор “simplicity” зарчмыг баримталсан - эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг практик арга хэмжээнд ойртуулах зорилгоор шинжлэх ухаанд үндэслэсэн цөлжилттэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх - ҮҮАХ-ийг хэрэгжүүлэгч нь гол хэрэгжүүлэгч тал нь ард түмэн гэдэг тогтвортой хөгжлийн үндэсэн зарчимд тулгуурлан иргэдэд түшиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг бодлого, хэрэгжилтийн талаархи зарчмын шинэчлэлийг хийсэн.
<p>What are the constraints/potential for data collection to establish the relevance of the Country Profiles?</p> <p>Улсын тайланг боловсруулахад мэдээлэл цуглуулах ямар саад бэрхшээл байна?</p>	<p>Цөлжилтийн асуудал нь өөрөө элдэв төрөл хүчин зүйлээс хамааралтай байх ба байгаль орчин, нийгэм-эдийн засгийн хөгжлийн бүхий л салбарыг хамардаг тул мэдээлэл цуглуулахад дараах хүндрэлүүд учирдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - салбар бүрийн нэгдсэн мэдээлэл сар, улираас хамааран бүрэн хуримтлагдаж чаддаггүй - мэдээллийн эх үүсвэрүүд хоорондоо уялдаа холбоо бага учраас мэдээллийн зөрүү ихтэй, ө.х. мэдээллийн чанар сул - тухайн салбарын байгууллагын хэмжээнд мэдээллийн стандарт тогтоогүй, нөгөөтэйгүүр хуучин тогтолцооны хэмжих нэгжийн тогтолцоог олон улсын жишигт ойртуулах нэрийдлээр хэмжих нэгж,

	<p>итгэлцүүр зэрэг тоон мэдээллүүдийг орон зай цаг хугацаанд харьцуулан үнэлэлт дүгнэлт өгч байгаа нь ажилд хүндрэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> - орон нутгаас мэдээлэл авах мэдээлэл, харилцаа холбооны тогтвортой тогтолцоо (Монголын цахилгаан холбооны сүлжээг эс тоцвол) байхгүйгээс орон нутгийн мэдээллийг хүлээн авах ажил шуурхай биш
<p>Has the diagnosis resulted in specific recommendations for NAP formulation?</p> <p>Дүн шинжилгээ нь ҮҮАХ-ийн боловсруулах зөвлөмжийг гаргахад нөлөөлсөн үү?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад шинжилгээ судалгааны болон статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг эш үндэс болгосон. Гэхдээ байгалийн нөөцийн менежментийг боловсронгуй болгох зорилгоор БОЯ-нд Байгаль, ой, усны нөөцийн агентлаг 2002-2005, 2005 оны Усны хэрэг эрхлэх газар байгуулан ажиллаж байна. Цөлжилтийн үндэсний хороо (комисс) олон яам тусгай газар, эрдэм шинжилгээний байгууллагуудын ажлын үр дүнг нэгтгэн статистикийн нэгдсэн систем тогтоогүй учир мэдээлэл цуглуулахад бэрхшээл байсаар байна. Монгол оронд цөлжилттэй тэмцэх, түүнийг сааруулах арга хэмжээ 2006 оныг хүртэл онолын шинжтэй дүгнэлт хийх, мэргэжлийн явцуу хүрээнд үнэлгээ өгөхөөс хэтрээгүй байгаа. Урьд өмнө хийсэн зарим ажил төдийлөн үр ашгаа өгөөгүй, эзэмшил, орон нутгийн хүмүүсийн оролцоог төдийлөн бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.</p>
<p>Does the NAP need to be reviewed in the light of the findings and adjusted in the light of the increasing interest received from the international community?</p> <p>Олон улсын нийгэмлэг хүлээн авсан ашиг сонирхлыг ҮҮАХ-ийг хянах, гинэчлэх шаардлага байна уу?</p>	<p>Олон улсын бүлгүүдээс авч явуулж байгаа төслүүд орон нутгийн (local) шинжтэй, сайн дурын маягтай явагддагаас байгаль орчинд эсрэг нөлөө үзүүлж улс орныг хамарсан үлгэр жишээ болсон нь цөөн байна. Үүнийг зохицуулах нэгдсэн удирдлага менежмент үгүйлэгдэж байна.</p>
<p>Established technical programmes and functional integrated projects to combat desertification</p> <p>7.2. Цөлжилттэй тэмцэх чиглэлд боловсруулсан техник хөтөлбөр ба үйл ажиллагааны цогц төслүүд</p>	
<p>What steps are being taken to adapt and integrate ongoing projects into the NAP process?</p>	<p>ЦТҮХ-т тайлбарт бичигдсэн зарчмууд тусгагдсан хэдий ч салбар хариуцсан яамд (сайд)-ын ажлын чиглэлээр тодорхой ажлууд тусгагддаг. Жишээ нь Сэргээгдэх эрчим хүч, ТЭХЯам, Ойн үнэлгээ, олборлолт (БОЯ,</p>

<p>Одоо хэрэгжиж байгаа төслүүдийг ҮҮАХ-т нэгтгэх, уялдуулах талаар ямар арга хэмжээнүүд хийгдсэн бэ?</p>	<p>ҮХЯ)-н үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчмын асуудлууд тусгагдсан. Ус ашиглалтын менежмент ХХААЯ, ҮХЯ, ТЭХЯ, БХБЯ, Газар ашиглалтын менежментийн төслүүд бий.</p>						
<p>To what an extent have the UNCCD principles been integrated into relevant ongoing projects relating to the areas identified in the left column? Otherwise, have concrete projects dealing with these issues been developed and implemented through the NAP?</p> <p>ЦТҮК-ын зарчмууд нь зүүн талын баганад тодорхойлсон төслүүдийн хувьд ямар хэмжээгээр тусгагдсан бэ? Эсвэл ҮҮАХ-ийн хүрээнд эдгээр асуудлыг хамарсан тодорхой төслүүд хэрэгждэг үү?</p>		сайн	дунд	сул			
<p>renewable sources of energy;</p> <p>сэргээгдэх эрчим хүч</p>	√			<p>sustainable land-use management, including water, soil and vegetation in affected areas;</p> <p>газар ашиглалтын тогтвортой менежмент, өртсөн нутгуудын ус, хөрс, ургамлыг хамааруулан</p>			√
<p>mountain ecosystem preservation;</p> <p>уулын экосистемийг хадгалан хамгаалах</p>				<p>forest resources assessment;</p> <p>ойн нөөцийн үнэлгээ</p>		√	
<p>sustainable use and management of rangelands;</p> <p>зохистой ашиглалт ба бэлчээрийн газрын менежмент</p>			√	<p>launch of reforestation/afforestation programmes and intensification of soil conservation programmes;</p> <p>ойжуулалтын хөтөлбөр ба хөрс хамгааллын хөтөлбөр</p>	√		
<p>development of early warning systems for food security and drought forecasting.</p> <p>Хүнсний аюулгй байдал ба гангийн мэдээллийн урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх</p>			√	<p>Монгол орны байгаль цаг уурын онцлог, ахуйн өвөрмөц байдал нь ядуурлын сонгодог тодорхойлолтоос өөр нөхцөл байдлыг үүсгэдэг. Ган, зудаас бэлчээрийн мал аж ахуйд учирсан хохирлоос малгүй болсон, эсвэл цөөн малтай малчид хувиараа алт олборлох, байгалийн баялаг ашиглах, төв суурин газар бараадах зэргээр шилжилт хөдөлгөөнд орсон нь байгаль орчинд сөрөг үйл ажиллагаа үзүүлж байна. Олон улсын төслүүд жишээлбэл IPAD, GTL, ADB- баруун 4 аймгийн хөдөө</p>			
<p>What specific activities have been identified and implemented to improve the economic environment with a view to eradicating poverty?</p> <p>Ядуурлыг бууруулах зорилгоор эдийн</p>							

<p>засгийн орчинг сайжруулах ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?</p>	<p>аж ахуйг дэмжих төслүүд судалгаа хийж эцэст нь худаг уст цэгийг сэргээн засварлах замаар нүүдлийн мал аж ахуйн гол бэрхшээлийн нэг болох усан хангамжийн нөхцлийг сайжруулахад чиглэгдэж байна. Баруун 4 аймагт 4 жилийн хооронд 400 орчим худгийн сэргээн засварлалт, 3 хөв засварлаж, 2 усалгааны системд засвар хийхэд тусалсан байна. IPAD –ын төслөөр Архангай, Хөвсгөл, Хэнтий, Булган аймагт 200 гаруй худаг засч байна. Бэлчээрийн тогтвортой менежмент төслөөр Сэлэнгэ, Өвөрхангайд хийснээр худаг гаргаж 30 гаруй худаг сэргээн засварлаж, 3 хөв шинээр барьж ашиглалтанд оруулжээ. Энэ бүгд нь ядуурлыг бууруулах зорилгоор эдийн засгийн орчныг сайжруулахад чиглэгдэж байгаа юм.</p>
<p>In case activities are implemented in the framework of programmes other than the UNCCD, what management indicators have been put in place to ensure that these activities address the underlying causes of desertification?</p> <p>ЦТҮК-аас гадна цөлжилттэй тэмцэх үндсэн үзүүлэлтийг хэмжих менежментийн талаар ямар үзүүлэлтийг авч үзэж байна вэ?</p>	<p>Монгол улсын их хурлаас 1992 онд баталсан “Монгол улсын үндсэн хууль”-д заасан байгаль орчныг хамгаалах талаар иргэний үүрэгт цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх цөлжилтөөс сэрэмжлэх менежментийн талаар тодорхой заасан.</p> <ul style="list-style-type: none"> • Төрөөс экологийн талаар баримтлах бодлого Улсын Их хурлын 1997 оны 10 дугаар тогтоол • Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоол • Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2000 оны 120 дугаар тогтоол • Байгаль орчны эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр Байгаль орчны сайдын 1999 оны 88 дугаар тухай • Ойн тухай үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол <p>зэрэг баримт бичигт газрыг зохистой ашиглах газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх менежментийн талаар тодорхой тусгасан.</p> <p>Монгол орны нөхцөлд тариалангийн талбай хамгаалах, авто замын сүлжээг сайжруулах болон бэлчээрийн менежментийг гол болгон авч үзэж байна.</p>
<p>Have specific projects been promoted aiming at implementation of the Convention at a local level, addressing local ecological and socio-economic conditions in a more holistic manner?</p> <p>Орон нутгийн экологийн болон</p>	<p>Монгол орны санхүүгийн төвлөрлийн байдлаас орон нутгийн экологийн болон нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг цогцоор авч үзэх, орон нутагт конвенцийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төв суурийн газрын элсжилтийг зогсоох, газар ашиглалт, газрын менежментийг сайжруулах, бэлчээрийг хамгаалах, ойн нөөцийг тоолох, үнэлэх, ойжуулах, ус цэвэршүүлэх зэрэг байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй чиглэгдсэн жижиг төслүүд тайлангийн хугацаанд хэрэгжсэн ба зарим нь одоо ч үргэлжилж байна.</p>

<p>нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг илүү цогцоор авч үзэж, улмаар орон нутгийн түвшинд конвенцийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр гарч ирсэн үү?</p>	
<p>Action programmes implemented in compliance with priority fields set out in the Convention</p> <p>7.3. Конвенцид тусгагдсан тэргүүлэх чиглэлд нийцсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт</p>	
<p>Are there any new methods to combat desertification that have been generated recently? If yes, what are these planned measures?</p> <p>Сүүлийн үед үүсээд байгаа цөлжилттэй тэмцэх шинэ арга гарч ирсэн үү? Хэрэв тийм бол, төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх талаар шинэ аргын тухай. Нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй эрхлэх системд байгаа аж ахуйн үйл ажиллагааны зөрчил бол цэгэн цөлжилт юм. Энэ цэгэн цөлжилтийн шалтгааныг нилээд олон талаас нь тодорхойлж хэдэн зөвлөмж гаргасан. Үүний гол асуудал нь бэлчээрийн доройтлыг сааруулах, бэлчээрийн даацыг хэтрүүлэлгүй ашиглах, мал сүргийн тоо толгой, сүргийн бүтцийн зохистой харьцааг тохируулах асуудал юм. Цөлжилттэй тэмцэх талаар гарсан зөвлөмж дараах чиглэлтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Малын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор усан сан-хөв байгуулах зөвлөмж • Малчдын өвөлжөө, хаваржааны орчимд ногоон шүхэр, ногоон хаалт, ногоон бүс байгуулах зөвлөмж • Хүчтэй салхин шуурганы хүчийг малын хотонд сааруулах дарцаг хийсгэх арга • Бэлчээр ашиглалтанд малын төрөл, тоо толгойн зохистой харьцааг тогтоох
<p>How is technical and scientific capacity being addressed at the local level?</p> <p>Орон нутгийн түвшинд тулгараад байгаа техникийн болон шинжлэх ухааны чадвар ямар байна вэ?</p>	<p>Цөлжилтийг сааруулахтай холбогдсон шинжлэх ухааны байгууллагын дүгнэлт, зөвлөмж нь орон нутагт тэр бүр хэрэгжихгүй байна. Иймд орон нутагт цөлжилттэй тэмцэх, цөлжилтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд техникийн болон шинжлэх ухааны чадавхи сул байна.</p>
<p>How are capacity-building measures aiming at the NAP process itself integrated into the NAP process?</p> <p>ҮҮАХ-ийн өөрийнх нь үйл ажиллагааны</p>	<p>Цөлжилттэй тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь конвенцийг хэрэгжүүлэх үйл явцтай дараах байдлаар уялдсан.</p> <ul style="list-style-type: none"> • Цөлжилттэй тэмцэх сургалт сурталчилгааг өргөжүүлэх • Цөлжилттэй тэмцэхэд төрийн бус байгууллага, хувийн сектор, иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгалийн нөөцийн менежментийг нэвтрүүлэх

<p>нэг зорилго болох чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь ҮҮАХ-ийн үйл явцтай хэрхэн уялдсан бэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Цөлжиж буй нутгийн ард иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх • Цөлжилттэй тэмцэх ажилд олон нийтийг татан оролцуулах эдийн засгийн урамшууллын механизмыг нэвтрүүлэх • Цөлжилттэй тэмцэхэд НҮБ-ын конвенцийн гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх • Цөлжилттэй тэмцэхэд гадаадын хөрөнгө санхүүгийн дэмжлэг, санал санаачилгыг дайчлан оролцуулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх
<p>Effectiveness of measures in local capacity building</p>	
<p>7.4. Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн</p>	
<p>What kinds of capacity-building measures are needed to ensure implementation of the Convention, particularly at the local level?</p> <p>Орон нутгийн түвшинд конвенцийг хэрэгжүүлэхийн тулд чадавхийг нэмэгдүүлэх ямар арга хэмжээ хэрэгтэй байна вэ?</p>	<p>Орон нутгийн түвшинд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүн хүч , санхүүгийн чадавхи сул байгаа нь ажлын үр дүнг дээшлүүлэх гол бэрхшээл болж байна.</p> <p>Орон нутагт дараах арга хэмжээг авах хэрэгтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутагт цөлжилттэй тэмцэх сан байгуулах замаар санхүүгийн асуудлыг шийдвэрлэх • Ус, салхины элэгдэлд орж байгаа хөрсийг хамгаалах, элсний нүүлтийг сааруулах хамгаалалт хийх, ойн бүс байгуулах • Нийгмийн бүх давхаргыг хамарсан цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх сургалтыг тогтмол явуулж байх: үүний дүнд байгаль хамгаалал ба цөлжилттэй тэмцэх нийгмийн сэтгэлгээг шинэ шатанд гаргах • Шийдвэр гаргагчдын түвшинд цөлжилтийн талаархи мэдээллийг бүрэн хүргэж байх • Цөлжилтийн талаархи мэдээллийн санг бүрдүүлэх • Улс орны хэмжээнд цөлжилтийн мониторингийг бий болгох • Цөлжилттэй тэмцэх талаар орон нутаг, ард иргэдийн үүсгэл санаачилгаар хийсэн ажлыг хөхүүлэн дэмжих
<p>Does the NAP reflect such capacity needs and does it outline ways of addressing them?</p> <p>ҮҮАХ нь энэхүү чадавхийг бэхжүүлэх</p>	<p>Энэхүү арга хэмжээний агуулга нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан боловч түүнийг хэрэгжүүлж, ажил болгох нь удаашралтай байна.</p>

түүнийг шийдвэрлэх арга замыг тусгасан уу?	
--	--

viii. Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжин үндэсний төсвөөс хуваарилсан санхүүжилтын хэмжээ, хэрэгцээ шаардлага хийгээд эдийн засаг, техник хамтын ажиллагаа, чиглэл, ач холбогдлын зэрэглэл

Adopted financial mechanisms	
Бүрдүүлсэн санхүүгийн механизм	
<p>What further measures have been taken to ensure access by local actors to funding sources?</p> <p>Орон нутгийн оролцогсод санхүүгийн эх үүсвэрийг олж авах ямар арга хэмжээнүүдийг цаашид авах вэ?</p>	<p>Одоогийн байдлаар цөлжилттэй тэмцэх ажилд зориулан улсын төвлөрсөн төсвөөс жил бүр тодорхой хөрөнгө гарган зарцуулж байна. Энэ хөрөнгийн ихэнх нь хөдөө орон нутагт зарцуулагдаж байна. Цөлжилттэй тэмцэх чиглэлээр хэрэгжиж байгаа гадаад орнууд болон байгууллагуудын санхүүжилттэй төслийн хүрээнд орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай бэлчээр сайжруулах, ойжуулах, нутгийн ард иргэдийг мод сөөг тарих ажилд сургах, мод бутны суулгац үржүүлэх ажил хийж энэ ажилд хамрагдагчид жил бүр өсч байна.</p>
<p>Are these measures provisional or permanent, and how can they be sustained?</p> <p>Эдгээр арга хэмжээнүүд нь урьдаас бэлтгэгдсэн цаашид тогтвортой байж чадах уу?</p>	<p>Дээр дурдсан санхүүжилт нь жил бүр өөр байдаг бөгөөд тогтвортой гэх боломжгүй. Төсвийн тодотголоор жил бүр УИХ-аар хэлэлцүүлэн баталдаг. Жил бүр Монгол улсын эрх барих дээд байгууллага- их хурал улсын төсвийг хэлэлцэж батладаг. Энэ төсөвд байгаль хамгаалах зардал багтдаг бөгөөд тэр нь тогтвортой байдаг.</p>
<p>Have any other specific mechanisms been determined to ensure financing for the NAP?</p> <p>ҮҮАХ-ийг санхүүжүүлэх ямар нэгэн онцгой арга замыг тодорхойлсон уу?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт зааснаар энэ ажилд зориулах хөрөнгийн эх үүсвэр нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэх юм.</p> <p>а/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв</p> <p>б/ байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө</p> <p>в/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө</p> <p>г/ олон нийт, иргэдийн хандивын хөрөнгө</p>

	<p>д/ шинжлэх ухаан технологийн сан, байгалийн нөөцийг хамгаалах зориулалтын сан</p> <p>е/ бусад</p> <p>Цөлжилттэй тэмцэх ажлыг санхүүжүүлэх дараах 2 төрлийн механизм бий болоод байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сан байгуулж цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд ашиглах • Үндэсний хуулийн хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо бүрдүүлэх <p>Цөлжилттэй тэмцэх сан: Байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дараах 2 төрлийн санг байгуулан ашиглаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Байгаль хамгаалах сан”-г Засгийн газрын 1998 оны №118-дугаар тогтоолоор байгуулав. Байгаль хамгаалах сангаас тодорхой жижиг төслүүдийг шалгаруулан жил бүр санхүүжүүлж байна. 1997-1999 онд 43.6 сая төгрөгийн төслийг санхүүжүүлжээ. <p>“Байгаль орчны итгэмжлэгдсэн сан”-г Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), НҮБ-ын Ган, цөлжилттэй тэмцэх алба (UNSO)-ийн дэмжлэгтэй байгуулав. “Байгаль орчны итгэмжлэгдсэн сан”-г бүрдүүлж түүний эх үүсвэрт энэ оны төвлөрсөн төсвөөс 1.6 тэрбум төгрөг¹ төлөвлөсөн байна. Итгэмжлэгдсэн сангийн шугамаар хуримтлагдах хөрөнгө нь үндсэндээ 2 төрлийн үйл ажиллагаанд буюу Монгол улсын биологийн төрөл зүйлийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зарцуулагдана. Энэ хөрөнгийг оролцуулж тооцвол төв, орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө 5.2 тэрбум төгрөг болох юм. Эдгээр сангийн дэмжлэгт газар зохион байгуулалтыг сайжруулах, бохирдлоос сэргийлэх, орчны доройтлыг багасгах, цөлжилттэй тэмцэх зэргээр тодорхой жижиг төслүүдийг дэмжиж санхүүжүүлдэг. Цаашид цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг санхүүжүүлдэг сан байгуулах нь зүйтэй гэж үздэг.</p>
<p>What are the modalities of participation of the various relevant actors in the funding and the management of activities to combat desertification?</p> <p>Цөлжилттэй тэмцэх</p>	<p>Цөлжилттэй тэмцэх ажилд зориулан зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг төрийн байгууллагууд нь улсын болон хувийн компаниуд, иргэдийн хандив, гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын зээл тусламжийг төвлөрүүлэн сан байгуулах ажлыг зохион байгуулахаар хөтөлбөрт заасан.</p> <p>ЦТҮХороо нь өөрийн мэдлийн санхүүгийн эх үүсвэргүй боловч Байгаль орчны яамны хүрээнд хийгдэх арга хэмжээний зардал, тухайлбал: газар зохион</p>

<p>үйл ажиллагааны менежмент болон санхүүжилт олоход янз бүрийн бүлгийн хүмүүсийн оролцооны хэлбэрүүд ямар байх вэ?</p>	<p>байгуулалт, ойжуулалт, худаг ус гаргах, тусгай хамгаалалттай нутгийн менежмент хийх, газрыг нөхөн сэргээх, ус цаг уур орчны мониторинг хийх, байгалийн нөөц баялгийг ашигласны орлогын тодорхой хэсгийг байгаль хамгаалах болон цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зориулах зэрэг бүхий л үйл ажиллагаанд санал өгөх, зөвлөх, зарим төслүүдийг захиалан авч хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг өргөн ашигладаг.</p> <p>Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд УИХ-аас батлан гаргасан “Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоох” тухай хууль (УИХ-ын хууль, 2000он №18) чухал үүрэг гүйцэтгэж байна. Үндэсний зохицуулах байгууллага нь гишүүдээрээ дамжуулан тэдгээрийг төлөөлж байгаа төрийн ба төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн байгууллага, нэгжтэй харьцаж үйл ажиллагаа явуулж байна.</p>
<p>Are international partners supporting these specific financial mechanisms?</p> <p>Энэ санхүүгийн механизмийг олон улсын хамтрагч нар дэмжиж байна уу?</p>	<p>Гадаад орнууд /Япон,Өмнөд Солонгос, Голланд зэрэг/ болон олон улсын байгууллагууд /Дэлхийн Банк, Азийн хөгжлийн банк, Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF// зэрэг байгууллагууд тодорхой төсөл хэрэгжүүлэх замаар туслаж байна.</p> <p>Эдгээр орнууд болон байгууллагууд цаашид хамтран ажиллах сонирхлоо илэрхийлээд байна.</p> <p>Хэрэглэж байгаа санхүүгийн механизм</p> <p>Монгол улс зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаанд шилжиж байгаатай холбогдон нийгэм эдийн засгийн бүхий л хүрээнд эрх зүйн тогтолцоог шинэчлэн хуульчилж, 1994-2000 онд байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 22 хууль, 200 орчим эрх зүйн актыг батлан мөрдөж байна. Байгаль хамгаалах тухай хуулийн 33-р зүйлд “Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан билээ. Энэ заалт нь байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуульчилж өгсөн хэрэг. Цөлжилттэй тэмцэх хүрээнд хамаарах салбарууд, тухайлбал хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, дэд бүтэц, нийгмийн хамгааллын салбарын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын зарим хэсгийг тооцох нь зүйтэй.</p> <p>Цөлжилттэй тэмцэх ажлын санхүүжилт болон менежментийн үйл ажиллагаанд янз бүрийн оролцогч талуудын оролцооны журмыг хуулиар зохицуулсан</p>

	<p>болно.</p> <p>Үндэсний хөтөлбөрийг байгаль орчны болон бусад стратеги төлөвлөлтийн тогтолцоотой уялдуулах нь. Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (ЦТҮХ)-ийг 1996 онд Засгийн газраас баталж, түүнийг бусад хөтөлбөрүүдийг уялдуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> * Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал (1996) * Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998) * Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997) * Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр (1996) * Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998) * Бүх нийтэд экологийн боловсрол олгох тухай үндэсний хөтөлбөр (1997) * Ойн тухай үндэсний хөтөлбөр (1998) * Байгалийн гамшигийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр (1998) * Монгол орны биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (1996) * Усны үндэсний хөтөлбөр (1999) * Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр (1999) * Ногоон хэрэм хөтөлбөр (2005) * <p>зэргүүдтэй уялдуулан зохицуулалт хийсэн болно. 1998 онд бүх хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх талаар үндэсний хэмжээнд семинар зохион байгуулж зохих зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.</p>
<p>Has a type of activity that generates sufficient economic return in an environmentally sound way been properly identified and promoted for investment projects?</p> <p>Эдийн засгийн үр өгөөжийг авчрах байгаль орчны хөрөнгө оруулалтын төсөл үйл ажиллагаанууд боловсруулагдсан уу?</p>	<p>Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн үр өгөөжтэй ургамал, мод, бут тарих ажлууд зохион байгуулагдаж байгаа бөгөөд эндээс орох орлого нь цөлжилттэй тэмцэх ажилд зарцуулагдана.</p> <p>Мөн байгалийн нөөц ашигласны төлбөрүүд нь байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх, нөхөн сэргээх ажилд зарцуулагдаж байна. Хөдөөгийн малчдын усан хангамжийг сайжруулах төсөл бол эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх байгаль орчны хөрөнгө оруулалт юм. (Энэ талаар 11-р бүлгээс үзнэ үү?)</p> <p>2004 оноос хойш малын бэлчээрийн усан хангамжийг дээшлүүлэх талаар төсөл боловсрогдон үйл ажиллагаа нь эхэлсэн боловч ажлын хамрах хүрээ бага, удаашралтай байгаагаас бодит үр дүн төдийлөн гарахгүй байна.</p>

<p>Has the return on investment been properly reinvested to ensure financial sustainability?</p> <p>Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд хөрөнгө оруулалтын өгөөжийг дахин хөрөнгө оруулалтанд зориулж байна уу?</p>	<p>Хөрөнгө оруулалтын өгөөж нь/return on investment/ одоогийн байдлаар санхүүгийн тогтвортой байдлыг хангахуйцаар далайцтай биш байна. Эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх байгаль орчны хөрөнгө оруулалт нь дөнгөж 3-4 жилийн өмнөөс бага хэмжээгээр эхлэж байгаа учраас цаг хугацааны хувьд дахин хөрөнгө оруулалтанд зориулах хугацаа, боломж гараагүй байгаа.</p>
<p>Has investment in drylands been generating environmental and socio-economic benefits for multiple stakeholders?</p> <p>Хуурайшсан газарт оруулсан хөрөнгө оруулалт нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үр ашгийг сонирхлын бүлгүүдэд авчирч байна уу?</p>	<p>Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн хуурай бүс нутаг нь газар орны байршил хийгээд уур амьсгалын удаан хугацааны өөрчлөлтийн үр дүн бөгөөд биологийн системүүдийн тогтворгүй, бүтээмж багатай орчинд хамаарагдана. Энэ хуурай гандуу нутгийн бэлчээрийг олон мянган жилийн турш нутгийн уугуул нүүдэлч-малчид ашиглаж, мал аж ахуйгаа хөгжүүлж ирсэн уламжлалтай.</p> <p>Бэлчээрийн ургац нь үндсэндээ тухайн жилийн нийлбэр тунадасны хэмжээ, хуваарилалтаас шууд шалтгаалдаг юм. Монголын хуурай бүс нутагт жилдээ 50-200мм тунадас унаж байгаа нь ууршицаас 20-4 дахин бага байх бөгөөд үүнээс шалтгаалж байнгын чийгийн хомсдлыг нөхцөлдүүлж ургацын хэмжээг хязгаарладаг. Бэлчээрийн ургамлын даацыг хэтрүүлэн ашиглаж байгаа нүүдлийн мал аж ахуйн өнөөгийн байдал нь газрыг доройтолд оруулж, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий цөөн хэдэн горхи, худгийн ойролцоо хэсэг хэсэг толбо маягийн цөлжилтийн голомт үүсэж байгаа нь тогтоогдсон юм.</p> <p>Ийм учраас Засгийн газраас ашиглагдаагүй байгаа бэлчээр нутагт мал бэлчээрлүүлхийн тулд худаг, уст цэгийг олшруулах бодлого боловсруулж “Монгол Улсын усны үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хуурай гандуу нутгийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, авто зам тавих, цахилгааны шугам татах, усан цахилгаан станц барих зэрэг хөрөнгө оруулалт нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх сонирхлын бүлгүүдийн эрх ашигт нийцэж байна. Харин газрын ашигт малтмал, зарим алт олборлолтын технологи нь байгаль орчныг хамгаалах бүлгүүдийн сонирхолд нийцдэггүй.</p>
<p style="text-align: center;">NAP financing</p> <p style="text-align: center;">ҮҮАХ-ийн санхүүжилт</p>	

<p>In what way is the national Government allocating money towards effective implementation of the Convention?</p> <p>Конвенцийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар мөнгөө ямар аргаар хуваарилаж байна вэ?</p>	<p>Санхүүжилт нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна:</p> <p>а/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв</p> <p>б/ байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө</p> <p>в/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө</p> <p>г/ олон нийт,иргэдийн хандивын хөрөнгө</p> <p>д/ шинжлэх ухаан технологийн сан, байгалийн нөөцийг хамгаалах зориулалтын сан</p> <p>е/ бусад</p>
<p>What kind of difficulties exists with regard to increasing the existing level of financing?</p> <p>Одоо байгаа санхүүгийн түвшинг сайжруулахад ямар бэрхшээлүүд тулгарч байна вэ?</p>	<p>Одоо байгаа санхүүжилтыг сайжруулахад дараах бэрхшээлүүд оршиж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Монгол улсын хэмжээний төвлөрсөн төсвийн хөрөнгөөс зарцуулагдах багахан хэсэг цөлжилттэй тэмцэхэд хангалттай эх үүсвэр болж чадахгүй байна. • Цөлжилттэй тэмцэх үндэсний конвенцийг хэрэгжүүлэхэд зориулсан тусгай санхүүгийн эх үүсвэр байхгүй байна. • Цөлжилттэй тэмцэх ажлыг шийдвэр гаргагчдаас эхлээд бүх түвшинд ойлгох ойлголт дутмаг. • Бүх нийтийн үйл ажиллагааг цөлжилттэй тэмцэхэд чиглүүлэх нийгмийн ухамсар бүрдээгүй • Байгаль орчинд халтай технологи хэрэглэгддэг • Байгаль, байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаанд цөлжилтөөс урьдчилан сэргийлэх технологи нэвтрээгүй
<p>Has a National Desertification Fund or any other budget line within the Government been established which provides funding exclusively for activities of the NAP?</p> <p>Засгийн газраас ҮҮАХ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ямар нэгэн төсөв буюу</p>	<ul style="list-style-type: none"> • Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд хөрөнгийн эх үүсвэр нь дараах байдалтай байна. <p>а/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв</p> <p>б/ байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө</p> <p>в/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө</p> <p>г/ олон нийт,иргэдийн хандивын хөрөнгө</p>

<p>Үндэсний Цөлжилтийн Санг байгуулсан уу?</p>	<p>д/ шинжлэх ухаан технологийн сан, байгалийн нөөцийг хамгаалах зориулалтын сан</p> <p>е/ бусад</p> <ul style="list-style-type: none"> • Цөлжилттэй тэмцэх үндэсний сан байгуулагдаагүй
<p>Has a plan been formulated for requesting technical cooperation, including envisaged multilateral and bilateral cooperation?</p> <p>Хоёр талын болон олон талын техникийн хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдсан уу?</p>	<p>Одоогийн байдлаар зарим гадаад орны Байгаль орчны яам /Япон,Өмнөд Солонгос зэрэг оронтой цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд хамтран ажиллахаар тохиролцсон боловч тодорхой төлөвлөгөө гаргаагүй байна. Монгол улсын ЦТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын цөлжилттэй тэмцэх нэгжийн үйл ажиллагаа, бүс нутгийн хөтөлбөр болон дэд бүтцийн хамтын ажиллагааны хүрээний төсөл, үйл ажиллагаатай нягт уялдаж байна. Тухайлбал Азийн бүсийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээний “Гангийн нөлөөг бууруулах, цөлжилттэй тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх” Монгол улс хариуцан гүйцэтгэв. Мөн Зүүн Хойт Азийн байгаль орчны хамтын ажиллагааны хүрээнд цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах арга хэмжээнд хамтран оролцож байна.</p> <p>Монгол улс цөлжилтийн судалгаа, түүнд хяналт шинжилгээ хийх, цөлжилтийг сааруулах арга хэмжээний хүрээнд Төв Азийн бүсийн хөрш зэргэлдээ улс орнууд Ази, Зүүн Азийн бүсийн олон талын үйл ажиллагаанд оролцож байна.</p> <p>Олон улсын Геобиосфер хөтөлбөрт хамтран оролцож нийхүү 2 талын ба олон талын хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p>
<p>Technical cooperation developed</p> <p>Техник хамтын ажиллагааны хөгжил</p>	
<p>What technical cooperation support has been received other than financial resources?</p> <p>Санхүүгийн эх үүсвэрээс гадна техникийн хамтын ажиллагааны ямар дэмжлэг хүлээн аваад байгаа вэ</p>	<p>Санхүүгийн эх үүсвэрээс гадна Олон улсын байгууллага, гадаад орнуудын холбогдох байгууллагын шугамаар зээлээр болон буцалтгүй тусламжаар зарим төсөл хэрэгжсэн болон хэрэгжиж байна. Тухайлбал ЦТК-ийн нарийн бичгийн дарга нарын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ЮНЕСКО, НҮБ-ын БОХ, Данида, Жайка, Койка, GTL, НҮБ-ын АНДЭЗИК, АХБ, Дэлхийн банк зэрэг техник хамтын ажиллагааны шугамаар монгол орны байгаль уур амьсгалын нөхцөлд бэлчээр газрын менежментийг сайжруулах, ойжуулах, усжуулах,</p>

	байгалийн нөөцийг нөхөн сэргээх чиглэлээр дэмжлэг хүлээн авч байна.
What are the needs for capacity building/technical cooperation, notably from the GEF? Ялангуяа ГОФ/ GEF /-аас чадавхийг бэхжүүлэх хамтын ажиллагааны ямар хэрэгцээ байна вэ?	Эхний ээлжинд цөлжилттэй тэмцэх үндэсний сүлжээ бий болгож чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллах цаашид улсын хэмжээний нэгдсэн судалгаа хийх болон практик ажлуудын хүрээнд хамтран GEF-тэй ажиллах шаардлагатай байна.
What is the order of priority of the needs identified? Дээрх хэрэглээнүүдийн зэрэглэлийг тодорхойлно уу?	<ul style="list-style-type: none"> i. Цөлжилттэй тэмцэх үндэсний сүлжээ бий болгож чадавхийг бэхжүүлэх ii. Улсын хэмжээний нэгдсэн судалгаа хийх iii. Цөлжилттэй тэмцэх практик ажлуудын хүрээнд хамтран ажиллах

ix. Хэрэгжилтийн явцыг тодорхойлох, үнэлэхэд хэрэглэгдэх шалгуур үзүүлэлтүүдийн талаарх тойм

Operational mechanisms for monitoring and evaluation	
9.1. Үнэлгээ өгөх болон хянах үйл ажиллагааны механизм	
Are the processes and dynamics of land degradation being monitored in your country? Танай оронд газрын газрын элэгдлийн хяналт хийгддэг үү, үнэлэх, дүгнэх бодит ажлыг хийсэн үү?	<p>Монгол улсад газрын доройтлын бүх аспектыг хамруулж чадаагүй боловч газар бүрхэвчийн мониторингийг тодорхой хэмжээгээр хийж байна. Газрын элэгдэл эвдрэл, цөлжилтийн төлөв байдлын мониторингийн сүлжээ бий болсон. УЦУОШГ-ын харъяа цаг уурын 64 станц, харуулууд дээр буюу 300 гаруй суманд 1961 оноос эхлүүлэн бэлчээрийн мониторинг хийж байна. Үүнээс гадна агаар сансрын зургийн тусламжтайгаар ургамлан бүрхэвчийн өөрчлөлтийг тандан судлах МТТ-ийг байгуулан 2000 оноос хойш NOAA ANVRR мэдээллийг 32 сувгаар хүлээн авч түүнд үндэсний мэргэжилтнүүдийн хүчээр боловсруулалт хийж байна.</p> <p>Шинжлэх ухааны чиглэлийн хүрээлэнгүүд, их дээд сургуулиуд ургамлан нөмрөгийн мониторингийн талбайтай. Мөн олон улсын зарим төслүүд ч энэ талын мониторингийн талбай байгуулан ажиллаж байна. Гэхдээ мониторинг хийгээд удаагүй. Мөн ажиглалт хэмжилтийн нэгдсэн систем бүрдэж чадахгүй, чадавхи</p>

	султай зэрэг бэрхшээл байна.
<p>What measures do you have on the ground to assess the rate of resource degradation?</p> <p>Ган болон цаг уурын байдлаас шалтгаалан газрын элэгдлийн түвшин ямар байх вэ?</p>	<p>Сүүлийн жилийн судалгаагаар Монгол орны цөлжилтийн үйл явц нь уур амьсгалын өөрчлөлт, гангийн давтагдал нэмэгдсэнтэй шууд хамааралтай гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Монгол шиг эмзэг экологитой нутагт илүү хүчтэй илэрч байна.</p>
<p>What is the rate of resource degradation that can be attributed to drought or climate change?</p> <p>Ган гийн нөлөөг бууруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх механизм байдаг уу?</p>	<p>БОМС-д түшиглэн орон нутаг үндэсний хэмжээнд гангийн давтагдал, тохиолдлыг тухай бүр орон нутаг, шаардлагатай бүс нутгуудад нарийвчлан мэдээлэх боломжоор хангагдсан. Цөлжилттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуурай гандуу нутагт дасан зохицсон мод, сөөгний төрөл зүйлийг сонгон ургуулах мод үржүүлгийн газруудыг байгуулах арга хэмжээг авч улсын хэмжээнд 1995 оноос хойш мод үржүүлгийн талбай байгуулаад байна. Тэнд жилд 32 сая ш суулгац бэлтгэж, ойжуулалтанд ашиглаж байна. Мөн талхлагдсан бэлчээр, уурхайлагдсан газар, тариалангийн элэгдэж эвдрээд хаягдсан газрын хөрс, ургамлан нөмрөгийг сэргээх ажил хийгдэж байна.</p>
<p>Are there any early warning mechanisms set up in an effort to mitigate the effects of drought and desertification?</p> <p>Таны бодлоор бодлогыг сайн хэрэгжүүлэхийн тулд эдгээр арга механизмуудын аль нь илүү их үр дүнтэй байх вэ?</p>	<p>Дээрхи арга механизмыг сайжруулах, мэдээлэл түгээх, хүлээн авах, урьдчилан мэдээлэх тогтолцоог бүрдүүлэхэд анхдагч мэдээг нарийвчилсан, бодит хугацаанд хүлээн авах, хамрагдаж буй мэргэжилтнүүдийн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэх шаардлагатай байна. Үүнээс гадна цөлжилтөөс урьдчилан мэдээлэх тогтолцоог бүрдүүлэхэд мэргэжлийн бэлтгэл үндэсний хэмжээнд хангагдаагүй байна гэж дүгнэж байна. Доройтсон газрын зэрэглэлийг тогтоох, тэр хэмжээгээр технологийг ялгавартайгаар боловсруулж, түүнийг бие даан нэвтрүүлэх байгууламж, аж ахуйн нэгж бас хэрэгтэй байна. Манай орны хувьд ойжуулах, ургамалжуулах, усжуулах (ялангуяа гадаргын усыг хуримтлуулах) зэрэг арга хэмжээ онцгой анхаарал татаж байна.</p>
<p>In your opinion, to what extent have the results from these measures been used to facilitate better policy formulations or responses?</p> <p>Одоо байгаа механизм болон системийг зохион</p>	<p>Гангийн нөлөөг бууруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэх зорилгоор 2004 оноос УЦУОШГ, түүний харъяа цаг уурын үндэсний сүлжээнд түшиглэн цаг уурын тоон загварчлалын аргаар гаргасан прогноз мэдээллийг орон нутагт түргэн шуурхай хүргэх сансрын холбооны VSAT сүлжээг JICA байгууллагын тусламжтайгаар суурилуулан, туршиж байна. Байгаль Орчны Мэдээллийн Санд түшиглэн цөлжилтөнд өртөж болзошгүй нутгуудад нэн тэргүүнд</p>

<p>байгуулах ямар арга хэмжээнүүд авагдаад байгаа вэ?</p>	<p>авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр баримтлах бодлогыг боловсруулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p>
<p>What are the measures taken for harmonization of existing mechanisms and systems? ҮҮАХ-ийн үр дүн, нөлөөллийг үнэлэх ямар хяналтын систем байна вэ? Энэ нь батлагдсан уу?</p>	<p>ҮҮАХ-ийн үр дүн, нөлөөллийг үнэлэх хяналтын систем өнөөдөр хараахан бүрэлдээгүй байна. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд гүйцэтгэгдсэн байдаг. Гэтэл үр дүнг түүнтэй харьцуулахад бага байгаа нь ажлыг үнэлэх нэгдсэн хяналтын систем бараг байхгүйтэй холбоотой болов уу? Гэвч хөтөлбөрийн хэрэгжилтийг үе шат бүрээр Засгийн газарт тайлагнаж, холбогдох арга хэмжээг авдаг.</p>
<p>What monitoring system has been formulated to assess and evaluate the impact of the NAP? Has it been adopted? ҮҮАХ-т цөлжилтийг хянах болон гангаас урьдчилан сэргийлэх шинжлэх ухааны болон техникийн ямар үйл ажиллагаа байна вэ?</p>	<p>Засгийн газар “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 1996 онд баталсан. Мөн 2003 онд шинэчилсэн. Энд цөлжилтийг хянах, түүний нөлөөллийг бууруулах үндсэн асуудлууд тусгагдсан. Мониторингийн сүлжээ байгуулах, мэдээллийн систем сайжруулах, тэмцэх ажлын ШУ-ны үндэслэлийг боловсруулах, чадавхийг дээшлүүлэх гэх мэт. Цөлжилттэй тэмцэх арга хэмжээ: бүсийн ба орон нутгийн түвшинд ялгавартай авах технологийн шинжлэх ухааны үндсийг боловсруулж хөрс, ургамлан нөмрөгийг хамгаалах, сэргээн сайжруулахад уламжлалт орчинг орчин үеийн дэвшилт технологитой холбох, цөлжилтөнд нөлөөлж буй хүчин зүйлүүд, тэдгээрийн оролцоог тодорхойлсоны үндсэн дээр авах арга хэмжээг боловсронгуй болгоно.</p>
<p>Цөлжилтийг хянах шинжлэх ухааны болон техникийн үйл ажиллагаа нь Конвенцийн зарчмыг хангаж чадаж байна уу? Хэрэв тийм бол хэн яаж хийсэн бэ?</p>	<p>Цөлжилттэй тэмцэх шинэчилсэн хөтөлбөр, түүнийг биелүүлэх ажлыг төлөвлөгөө Конвенцийн 10, 16, 17 дугаар зүйлийн заалтуудад нийцэж байгаа. Гэвч хөтөлбөрийн мэргэжлийн ба үзэл баримтлалын доголдлоос хэрэгжүүлэх явцад эргэлзээтэй зүйл гарсан. Зорилгод хүрэхэд бэрхшээл учирч байна. Хөтөлбөрт элсний нүүлтэд голлон анхаараад газрын доройтлыг багцаар авч үзээгүй сул тал бий.</p>
<p>ҮҮАХ-т шинжлэх ухааны болон техникийн бүлгийг нэгтгэх ямар зорилго тавигдсан бэ?</p>	<p>Эрдэм шинжилгээний ажлыг орон нутгийн нөхцөлтэй уялдуулж захиалгаар гүйцэтгэхэд анхаарч байна. Ажлын үр дүн, технологийг нийтэд таниулах, зааж сургах, нөгөө талаас эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх малчдын сонирхлыг татах талаар арга хэмжээ авч байна. “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” /2003/-т - бэлчээрийн эдэлбэр газар, газар тариалангийн нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой менежментийг буй болгох - цөлжилттэй тэмцэх төв, орон нутгийн байгууллагуудын</p>

	<p>чадавхийг бэхжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - цөлжилттэй тэмцэхэд төрийн бус байгууллага, хувийн сектор, иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг нэвтрүүлэх - цөлжиттэй тэмцэх ажилд олон нийтийг татан оролцуулах, эдийн засгийн урамшууллын оновчтой механизмийн судалж нэвтрүүлэх гэж заасан байна. <p>Харин “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн эхний үе шатны /2003-2007 он/ зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд:</p> <ul style="list-style-type: none"> - бэлчээрийн даац, чадавхид нь тохирсон менежментээр мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх - говь тал хээрийн бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг нэвтрүүлэх - байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийн доройтлыг бууруулахад нутгийн иргэдийн оролцоог өргөтгөх, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ойн зурвас байгуулах, газрын нөхөн сэргээх зэрэг арга хэмжээнд өргөн оролцуулах, идэвх санаачлагыг өрнүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн санаачлагыг дэмжих ажил зохион байгуулах - цөлжилттэй тэмцэх санаачлага, идэвхи чармайлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, алдаршуулах арга хэмжээ авах гэх зэрэг заалтууд орсон байна.
<p>ҮҮАХ-ийн үйл явцад шинжлэх ухааны ба техникийн үйл явцыг тохируулах ямар бэлтгэл ажил хийгдсэн бэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын Засгийн газрын 2000 оны 199 дүгээр тогтоолын дагуу Ус цаг уурын ажиглалтын улсын сүлжээний өртөө харуулуудыг түшиглэн сум, аймгийн төвшинд малын өвөл-хаврын бэлчээрийн даац багтаамжийг тодорхойлон мал өвөлжилтийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах ажлыг 2001 оноос эхлэн Засгийн газрын төвшинд зохион байгуулдаг болсноор малын зүй бус хорогдол тодорхой хэмжээгээр багассан. - Мөн тогтоолын дагуу улсын хэмжээгээр цөлжилтийн байдлын үнэлгээг багийн төвшинд 2002 оноос эхлэн хийж анхны зарим үр дүнгүүд гарган авч байна. - Монгол улсын Засгийн газраас бэлчээрийн антропоген доройтлын гол нэг шалтгаан болж байгаа бэлчээрийн усан хангамж 1990-ээд оноос эрс доройтсон явдлыг засч залруулах чиглэлээр улсын дотоодын төсөв болон хандивлагчдын хөрөнгийн нэлээд хэсгийг энэ чиглэлд зарцуулах бодлого явуулж тодорхой амжилтанд хүрч байна. Тухайлбал бэлчээрт

	<p>худаг гаргахад зориулан улсын төсвөөс 2004 оноос хойш жил бүр 200 орчим сая төгрөг зарцуулж байх юм.</p> <p>- Ган, цөлжилтийн нөлөөг бууруулах зорилгоор Монгол улсын Засгийн газраас хөдөө аж ахуйг эрчимжүүлэх бодлого барьж байна. Засгийн газар, олон улсын байгууллага, гадаад орнуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд малчид хөдөлмөрөө хорших байдлаар ажиллаж бэлчээрийн менежментээ боловсронгуй болгох, бэлчээр сайжруулах чиглэлээр ажиллаж буй малчдын 1400 гаруй бүлэг буй болж, 2003-2006 онд 80 гаруй мянган га бэлчээрийг хашиж хамгаалан олон наст өвс тарьж байгаа мэдээ байна. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй бүс нутагт тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 350 гаруй тоног төхөөрөмжийг улсаас хөнгөлттэй үнээр малчдад нийлүүлсэн байна.</p> <p>Гэвч бэлчээр хамгаалах ажилд огт хөрөнгө заралгүй эргэлтийн чанартай өөрчлөлт хийж болох бэлчээр эзэмшилт, өмчлөлтийн эрхзүйн харилцааг зохицуулсан хуулийг одоо болтол гаргаагүй байна. Үүнээс болоод малчид газарт хөрөнгө оруулалт хийх сонирхол багатай байгаа юм.</p> <p>Бас нэг анхаарал татаж байгаа зүйл бол эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ гэж төр засаг зорилт тавьж хөтөлбөр хүртэл гаргасан боловч Монголд энэ ажлыг яаж хийх загвар гарч ирээгүй, энэ талын эрхзүйн акт ч гараагүй, үндсэндээ төрийн бодлого болоод шинжлэх ухааны судалгааны ажил нь амьдралаас хоцорч явна.</p>
<p>ҮҮАХ-т хэрэгжихэд цөлжилтийн хянах шинжлэх ухааны ба техникийн үйл явцыг онцгойлон хэрэгжүүлэх хэрэгтэй хэмээн зөвлөмж орсон уу? Ямар дэвшил гарч байна вэ? Түүний үр дүн, нөлөөлөл юу байна вэ?</p>	<p>Хөтөлбөрөөс эш татсан байдлыг харахад ийм санаа үндсэндээ орсон байна гэдэг нь ойлгогдоно. Гэхдээ энэ асуудал дээр онцгойлон ач холбогдол өгч, хөрөнө зараад байгаа ажил бараг байхгүй. Харин улсын захиалгат шинжлэх ухааны төслийн ажлын үр дүнгээр Монгол орны цөлжилтийн өнөөгийн төлөв байдлыг харуулсан зураглал энэ 2006 онд ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төвөөс гарна. Одоо хүртэл хүн болгон цөлжилт болоод байна л гэж яриад байгаагаас биш улсын хэмжээгээр цөлжилтийн төвшин ийм байна гээд шинжлэх ухааны үндсэн дээр гаргачихсан үнэлгээ байхгүй байгаагаар барахгүй, цөлжилт гэж юу юм бэ гэдэг талаар нэгдсэн ойлголт ч тогтоогүй шахам, цөлжилтөнд хүргэж байгаа хүчин зүйлүүдийг ялган тогтоогоогүй байна. Цөлжилтийн цар хүрээ, аюулын зэрэглэл зэргийг нарийвчлан тогтооход ба эдгээрийг тогтоох үзүүлэлтүүдийг стандартчилах. Мөн цөлжилтийн</p>

	урьдчилсан модель-ийг зохиоход их анхаарч байна.
Шинжлэх ухааны болон техникийн бүлгүүдтэй зөвлөлдөх ямар журам байна вэ?	Энд тодорхой хэвшсэн арга механизм алга байна. Гэхдээ тэдгээрийн уулзалт, семинар, зөвлөлгөө зохион байгуулдаг.
Зөвлөгөөг хэрэгжүүлэх ямар арга зам байна вэ?	Тодорхой механизм тогтоогүй. Гэхдээ зөвлөлдсөний үндсэн дээр, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг орон нутагт төлөвлөж, төслөөр санхүүжүүлдэг.

х. ТБХ.5/10-ын шийдвэрийн дагуу шинээр танилцуулах үзүүлэлтүүд

Scientific and technical desertification control activities	
10.1. Цөлжилтийг хянах шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа	
<p>Which scientific and technical activities relating to desertification control and drought mitigation have been identified under the NAP?</p> <p>ҮҮАХ-ийн хүрээнд цөлжилтийн хяналт, гангийн нөлөөг бууруулахтай холбоотой шинжлэх ухаан, технологийн ямар үйл ажиллагаа авч хэрэгжүүлсэн бэ?</p>	<p>Олон улс, түнш орнуудын хамтын ажиллагааны хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “A Pilot Study in North-East Asia for Developing Desertification Assessment and Constructing an Early Warning System” funded by the Ministry of the Environment of Japan төслийн хүрээнд Graduate School of Agricultural and Life Sciences of the University of Tokyo, Japan Монгол улсын ХААИС-тай хамтран Монгол орны цөлжилтийн үйл явцыг хянах, урьдчилан мэдээлэх, нөлөөлж буй механизмыг тооцох арга, аргачлал боловсруулах зорилгоор хээр, говь, цөлийн бүсийг төлөөлсөн 3 цэгийг Хэнтий аймгийн Хэрлэнбаян улаан, Дундговийн Сайнцагаан, Өмнөговийн Булган суманд сонгон судалгаа явуулж байна. Уг судалгааг Зайнаас тандсан материалыг хээрийн судалгаагаар тодруулах замаар гүйцэтгэж байна. Энэ судалгааны нийгэм эдийн засгийн салбарт Global Environmental Forum of Japan, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн хамтран гүйцэтгэгчээр ажиллаж байна. • “Preventing desertification in North East Asia” Mongolia-Korea joint project implemented by Korean Forest Research Institute and Institute of Geoecology Mongolia. Энэхүү төслийн хүрээнд элсний нүүлт хөдөлгөөнийг сааруулах дэвшилтэт аргуудыг Монголын нөхцөлд турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэж ирлээ.

	<p>Үүнээс гадна БОЯ, БСШУЯ-ны тусгай захиалгаар цөлжилттийн үйл явцыг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх дэвшилтэд аргуудыг боловсруулах, гангаас урьдчилан сэргийлэх чиглэлд дараах төслүүдийг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн төвшнүүдэд ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Говь, хээрийн бүсийн цөлжилтийг сааруулах шинжлэх ухаан технологийн үндэслэл” (2001-2004) • “Монгол орны цөлжилтийн динамик, түүний хандлага”(2004-2007)
<p>Have the scientific and technical desertification control activities been considered with a view to determining their conformity with the principles of the Convention? If so, how and by whom was this done?</p> <p>Цөлжилтийг хяналтын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа нь конвенцийн зарчмуудтай хэрхэн уялдуулсан бэ? Хэрэв тийм бол хэрхэн, ямар байгууллага үүнийг хийж гүйцэтгэдэг вэ?</p>	<p>Дээрхи шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа нь цөлжилтийг хянах, үнэлгээ өгөх арга, аргачлал боловсруулахад чиглэгдсэн судалгаа болж байгаа учраас Конвенцид заагдсан зарчим, үзэл санаанд нийцэж байгаа.</p> <p>Дээрхи үйл ажиллагааг хийж гүйцэтгэх гол үүргийг ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн дэргэдэх Цөлжилтийн судалгааны төв гүйцэтгэж байгаагаас гадна МУИС, ХААИС-иудын дэргэдэх судалгааны төв, нэгж салбаруудаар дамжуулан хэрэгжүүлж ирсэн.</p>
<p>What proposals have been made to integrate the scientific and technical community into the NAP process?</p> <p>ҮҮАХ-ийн үйл ажиллагааны хүрээнд шинжлэх ухаан, техникийн байгууллагуудыг оролцуулах талаар ямар санал боловсруулан ажилласан бэ?</p>	<p>ҮҮАХ-т шинжлэх ухаан, технологийн бүлгийг нэгтгэх, тэдгээрийг ҮҮАХ-ийн хэрэгжилтэнд татан оролцуулах талаар тодорхой зорилго тавигдаагүй.</p>
<p>What arrangements have been made to adapt the scientific and technical activities under way to the NAP process?</p> <p>ҮҮАХ-ийн хэрэгжүүлэх явцад шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дасан зохицуулах ямар ажилбарууд хийгдсэн бэ?</p>	<p>ҮҮАХ-ийн хэрэгжүүлэх явцад шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дасан зохицуулах ямар нэгэн ажилбарууд хийгдээгүй болно</p>
<p>Have the scientific and</p>	<p>ҮҮАХ-т онцгойлон дурьдагдсан шинжлэх ухаан,</p>


<p>technical desertification control activities specifically recommended in the NAP been implemented, what progress have they made and what are their results and impact?</p> <p>ҮҮАХ-т онцгойлон дурьдагдсан шинжлэх ухаан, технологийн судалгаа явагдсан эсэх, ямар ололт амжилтанд хүрсэн бэ?</p>	<p>технологийн судалгаа нь цөлжилтийн хүчин зүйлс, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулах ажилд онцгой анхаарал хандуулж ирсэн бөгөөд энэхүү ажлын хүрээнд зайнаас тандан судлах арга буюу цаг хугацаа, санхүү болон ажлын хүчийг зохистой ашиглахад илүүц нийцсэн шинэлэг аргазүйг хэрэглэх тал дээр анхааран ажиллаж байна. Ийнхүү NOAA хиймэл дагуулын мэдээ, Landsat хиймэл дагуулын түүхэн хугацааны мэдээний цуваад тулгуурлан газрын бүрхэвчийн өөрчлөлт, гангийн мониторинг зэрэг шалгууруудаар үнэлж дүгнэх чадавхийг үндэсний хэмжээнд бэхжүүлж ирсэн. Үүнээс гадна 2005 оноос Нидерландын Вант Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр Монгол орны байгалийн нөөцийн менежментийн Геомэдээллийн сан байгуулах зайнаас тандан судлах эх үүсвэрийг бэхжүүлэх төслийн хүрээнд ялгах чадвар сайтай MODIS хиймэл дагуулын мэдээг авах суурин станцыг байгуулах болсноор үндэсний мэргэжилтнүүд тодорхой хэмжээний шинэ арга, мэдээллийн эх үүсвэрийг ашиглах боломж бүрдэж байна. Дээрхи үйл ажиллагаанаас олсон гол ололт амжилтуудыг дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - судалгаа шинжилгээний уламжлалт болон орчин үеийн аргуудыг хослуулах, тэдгээрийг жишин үнэлэх замаар цөлжилтийн үнэлгээний нэгдсэн аргыг боловсруулсан - Цөлжилтийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулахад урьд өмнө гарч байсан алдааг бууруулах зорилгоор хиймэл дагуулын мэдээг ашиглан цөлжилтийн үйл явцын талбайлаг шинж чанарыг үнэлэх аргачлалын суурь бүрэлдэн тогтсон - Цөлжилтийн мониторингийн суурин судалгааны сүлжээг бий болгох үндэслэлийг боловсруулан үндэсний хэмжээнд экологийн урт хугацааны мониторинг хийх шаардлага хэрэгцээг тодорхойлон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.
<p>What consultation procedures have been implemented with the scientific and technical community?</p> <p>Шинжлэх ухаан, технологийн хүрээнд зөвлөлгөө зөвлөмж хийсэн эсэх?</p>	<p>Үгүй</p>

<p>What mechanism has been set in place to facilitate consultation?</p> <p>Дээрхи хүрээнд зөвлөлгөөг хэрэгжүүлэхийн тулд ямар механизм боловсруулсан бэ?</p>	-	
<p>Implementation of the recommendations of the Committee on Science and Technology</p> <p>10.2. Шинжлэх ухаан, технологийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p>		
<p>What lessons have been drawn from implementing the recommendations of the CST, in particular in respect of the following:</p> <ul style="list-style-type: none"> • Benchmarks and indicators; • Traditional knowledge; • Early warning systems; • Training and field studies to identify pilot sites? <p>Шинжлэх ухаан болон техникийн хорооноос гаргасан зөвлөмжийг гүйцэлдүүлэхэд дараах чиглэлүүдийн хүрээнд ямар сургамжууд олсон бэ?</p> <ul style="list-style-type: none"> • Шалгуур үзүүлэлтүүд • Уламжлалт мэдлэг • Урьдчилан мэдээлэх тогтолцоо • Судалгааны цэгүүдийг тодорхойлох сургалт, хээрийн судлагаа 	<p>Benchmarks and indicators</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>Сургамж/цаашид анхаарах асуудал</p> <ul style="list-style-type: none"> • Зайнаас тандан судлах аргыг уламжалт судалгаатай хавсран хийх нь зүйтэй • Цөлжилтийн үйл явцын зураглалд тусгаар хэлбэрүүдийг (салхи, усны элэгдэл, эвдрэл, бэлчээрийн талхагдал, ойн хомсдол) оруулах шаардлагатай • Цөлжилттэй тэмцэх чиглэлээр явуулсан судалгааны үр дүнг тухай бүр үнэлж дүгнэх
	<p>Traditional knowledge</p> <p>Уламжлалт мэдлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Байгальд түшиглэсэн аж ахуйн уламжлалт хэлбэрүүдийг сэргээх • Уламжлалт байгаль хамгааллын хөшүүргүүдийг орчин үеийн байгаль хамгаалах зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх • Хүүхэд залуучуудад байгаль хамгааллын уламжлалт аргуудыг таниулах
	<p>Early warning systems</p> <p>Урьдчилан мэдээлэх тогтолцоо</p>	<ul style="list-style-type: none"> • Цөлжилт бүхий хөрш зэргэлдээ орнуудтай мэдээлэл солилцох мэдээллийн технологийн шинэлэг аргыг нэвтрүүлэх • Бүс дундын урьдчилан мэдээлэх системд өөрийн орны мэдээллийг тухай бүр толилуулах
	<p>Training and field studies to identify pilot sites</p> <p>Судалгааны цэгүүдийг тодорхойлох сургалт, хээрийн судлагаа</p>	<ul style="list-style-type: none"> • Цөлжилтийн мониторингийн урт хугацааны сүлжээ байгуулах • Суурин судалгааны цэгүүд нь байгалийн бүс, мужуудыг төлөөлж чадахуйц байрлалтай байх • Орон нутгийн байгаль хамгааллын байгууллага/мэргэжилтнүүдэд суурин судалгаанд хэрэглэгдэх гол зарчим, аргуудыг таниулах
<p>What use has been made of experts from the roster of independent experts drawn up by the secretariat?</p> <p>ЦТҮХ-оос жагсаасан бие даасан шинжээчдээс ямар мэргэжилтнүүд/шинжээчдийг ямар байдлаар ашигласан</p>	-	

(XI) Цөлжилт болон гантай холбоотой биофизикийн үзүүлэлтүүд


1. Уур амьсгал

Хур тунадас: Монгол оронд хур тунадас ерөнхийдөө бага. Ойт хээр, уул нуруудад жилдээ 250-400 мм, хээрийн бүсэнд 150-250 мм, цөлөрхөг хээр ба цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унадаг (1 дүгээр зураг).




1 дүгээр зураг. Жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн тархац
Хур тунадасны дунджийн квадрат хазайц буюу стандарт хазайц цөлийн бүсэнд ± 30 мм тунадасны хэмжээний өөрчлөлт хуурай бүс нутагтаа илүүтэй мэдрэгддэг. Цөлөрхөг хээрийн бүсэнд $\pm 30-50$ мм, хээрийн бүсэнд $\pm 50-70$ мм, ойт хээрийн бүсэнд 70-90 мм байдаг. Манай орны жилийн хур тунадасны вариацийн коэффициент ойт хээрт 0.24, хээрт 0.27, уулархаг мужид 0.33, цөлөрхөг хээр болон цөлд 0.38 юм.

1.2 Хуурайшлын индекс: Манай орны хуурайшлын индексийн газар зүйн тархацыг авч үзвэл /2, 3 дугаар зураг/ цөлийн бүсэд 0.05-0.07 орчим, цөлөрхөг хээрийн бүсэд 0.10-0.30 орчим, хээрийн бүсэд 0.30-0.50, ойт хээрийн бүс ба өндөр уулын бүслүүрт 0.50-0.75 орчим байна.



2 дугаар зураг. Хуурайшлын индекс(P/E_0)-ийн газар зүйн тархац

Цаг уурын 47 өртөөний 1940-2003 оны өгөгдлөөр тооцоолсон хуурайшлын индексийн олон жилийн явцын шугаман трендийн тэгшитгэлийн а коэффициентийг зураг 3-т үзүүлэв. Зураг 3 -аас харвал Дорнод, Дорноговийн зүүн хэсэг болоод Алтайн уулархаг нутаг, Алтайн өвөр говиор хуурайшлын индексийн утга нэмэгдэж байгаа буюу гандуу байдал буурч байгаа / $a > 0$ /, бусад бүх нутгаар хуурайшлын индексийн утга буурч байгаа буюу гандуу байдал нэмэгдэж байхад / $a < 0$ /, төвийн бүсэнд хамгийн эрчимтэй байна.



3 дугаар зураг. Хуурайшлын индексийн олон жилийн явцын шугаман трендийн тэгшитгэлийн а - коэффициентийн утга

1.3 Агаар мандлын ган: Манай орны өндөр уул, ойт хээр, хээрийн бүсийн ихэнх нутагт 10 жилийн 1-2 жилд нь ган болох эрэмбэтэй байдаг бол цөлөрхөг хээрийн бүсэнд 2 жилийн нэг нь гантай байдаг, харин хээрийн бүс, цөлөрхөг хээрийн бүсийн зааг нутгаар 3 жилд нэг удаа ган болдог аж. Гангийн давтагдал хойноос урагшлах, зүүнээс баруун тийшлэх тутам нэмэгдэж байгаа нь манай орны чийгшлийн ерөнхий горимтой зохицож байна.




4 дүгээр зураг. Гангийн давтагдлын газар зүйн тархац

2. Ургамалшил болон газар ашиглалт

2.1 Ургамлын нормчилсон индекс- (NDVI) :

NDVI нь орон зай, цаг хугацааны өөрчлөлт ихтэй. Байгалийн бүс бүслүүр бүрд харилцан адилгүй тайга, өндөр уулын, ойт хээрийн бүсэд 7-р сарын 10-нээс 8-р сарын 10-нд, хээрийн бүсэнд 7-р сарын 20-ноос 8-р сарын 20-нд, цөлөрхөг хээр ба цөлийн бүсэнд 8-р сарын 10-наас 9-р сарын 10-нд байдаг байна.




5 дугаар зураг. NDVI-ийн жилийн явц, байгалийн бүсээр

2.2 Ургамлан бүрхэц: Монгол орны хэмжээнд ургамлан бүрхэц дунджаар 26 % байх бөгөөд харин зуншлага хамгийн сайн байсан 1994 онд 32%-д хүрчээ. Гэхдээ ургамлан бүрхэц гантай жилүүдэд дахин, 2002 онд 16 % болтол буурсан байна. Ургамлан бүрхэц дээр 1994 он хүртэл өссөн, 1994 оноос хойш буурсан нь гангийн ерөнхий хандлагыг харуулж байна. Монгол орны ургамал бүрхэцийн дундаж утгын олон жилийн динамикийг зурагт үзүүлэв. Ялангуяа сүүлийн 5 жилд ургамал бүрхэцийн хувь их буурлаа.



6 дугаар зураг. Ургамлан бүрхэц (хувь)

Ургамлан бүрхэцийг 1982-1994, 1995-2003 оны NDVI-ийн дундаж утгаар бодож дараах зурагт үзүүлэв. Сүүлийн 10 жилийн байдлаар манай нийт нутгийн 27.3%-ийг 10% -иас бага ургамлан бүрхэцтэй газар эзлэх болж хувь нь өмнөх 10 жилээсээ 4.3% - иар нэмэгджээ.



2.3 Газар ашиглалт (Нийт газрын хэдэн хувь)

Монгол орны газрын сан, түүний ашиглалтын өнөөгийн байдал:

Монгол орны газрын нэгдмэл сан нь ХАА-н газар, Хот тосгон ба бусад суурин газар, Зам шугам сүлжээний газар, Ойн сан бүхий газар, Усан сан бүхий газар, Нөөц газар гэж ангилагдана.

2004 оны эцсээр нийт нутаг дэвсгэрээс ХАА-н газарт 115580.5 мян.га (73.9 хувь), хот тосгон ба бусад суурин газар 432.9 мян.га (0.27 хувь), зам шугам сүлжээний газарт 353.1 мян.га (0.22 хувь), ойн сан бүхий газар 14673.8 мян.га (9.4 хувь), усан сан бүхий газарт 943.4 мян.га (0.60 хувь), улсын тусгай хэрэгцээний газарт 24427.9 мянган га (15.6 хувь) тус тус эзэлж байна.

1 дүгээр хүснэгт. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын эзлэх хувь.


д/д	Газрын сангийн үндэсний ангилал	1998		2004	
		мян.га	%	мян.га	%
1	Хөдөө аж ахуйн газар	129131.9	82.5	115580.5	73.9
2	Хот, тосгон бусад суурины газар	376.3	0.24	432.9	0.27
3	Тусгай хэрэгцээний газар	-	-	24427.9	15.6
4	Ойн сан бүхий газар	17852.0	11.42	14673.8	9.4
5	Усан сан бүхий газар	1665.0	1.06	943.4	0.60
6	Нөөц газар	7056.2	4.51	-	-
7	Зам, шугам сүлжээний газар	330.2	0.21	353.1	0.22
	Нийт нутаг	156411.6	100.0	156411.6	100.0

Эндээс үзэхэд сүүлийн 5-6 жилд хөдөө аж ахуйн газар 8.7 ба ойн сан бүхий газар 2.0 хувиар тус тус буурсан байна.

2 дугаар хүснэгт. Газар ашиглалт

Газар ашиглалт	1990-1999	2000-2005
Хагалсан газар	900.0 мян.га	500 мян.га
- Усалгаатай (Surface irrigation)	16.0 мян.га	20.0 мян.га
- Бороожуулсан (Sprinkler irrigation)	10.1 мян.га	12.6 мян.га
Бэлчээр	125.0 сая.га	110.9 сая.га
Ой болон модтой газар	12.9 сая.га	12.2 сая.га
Бусад газар	17.6 сая.га	17.9 сая.га

Changes of pasture land size and head of livestock



Total livestock number was 9.6 million in 1918 which was increased until 30 million in 2000 (increased three times), while the pasture land size is reduced from 130.0 million ha down to 115.0 ha for the same time period (21.5 % decrease). The increase of the livestock is mainly connected with rapid increase of goat and sheep, while number of the larger livestock such as cattle, horse and camel is decreased.

3 дугаар хүснэгт. Монгол оронд газар өмчлөл ба эзэмшилтийн байдал

№	2003 он		2005 он	
	Тоо /мян.өрх/	Га	Тоо /мян.өрх/	Га
1. Өмчлөгч (Гэр бүл иргэд)	21.8	1.9 мян.га	35.3	15.5 мян/га
2. Эзэмшигч	353.3	12.4 сая/га	415.7	17.1 сая/га

3. Усны нөөц:

3.1 Усны нөөц: Монгол орны гадаргын нийт усны нөөц 599 шоо км байна. Монгол улсын цэвэр усны хангамж (34.6 сая м³). Усны нөөцийн 83.7 хувийг нуур, 10.5 хувийг мөсөн гол, 5.8 хувийг голд тус тус байдаг боловч байгалийн нөхөн сэргээлт бага явагддаг. Жилийн дундаж хур тунадас 244 мм (үүний 90.1 хувь нь ууршдаг) байдаг бөгөөд хур тунадасны хэмжээ жилээс жилд хэлбэлзэж нийт газар нутгийн хэмжээнд ихээхэн ялгаатай байдаг. Гадаргын усны нөөцийн 85 хувийг цэнгэг ус, түүний 93.6 хувийг Хөвсгөл нуурын ус эзэлнэ. Газрын доорх усны нөөц ойролцоогоор 12.6 шоо км байна.

Монгол орны усны нөөц, шоо км

Улсын хэмжээгээр	Гадаргын ус		Газрын доорх ус	
	Нийт	Үүнээс:ашиглаж болох	Ул хөрсний	Үүнээс:ашиглаж болох
48.6	34.6	4.96	12.0	5.60

Бэлчээрийг усжуулах зорилгоор 1960-1990 онуудад олон худаг барьж байгуулан нийт хээр талын 60 хувийг усаар хангасан боловч тэр 48000 худгийн дөнгөж 40 хувь нь л одоогоор ажиллагаатай байна. 1998-1999 оны хооронд худаг усны хангамж 20 хувиар буурсан, харин энэ хугацаанд малын тоо толгой 30 хувиар нэмэгдсэн байна. 2005 оны байдлаар шинээр гаргасан худгийн тоо 1492, үүнээс инженерийн хийцтэй 183, энгийн уурхайн 1309 байна. Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1279.6 сая.төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр 299.2 сая.төг, Гадаад орон, Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 584.1 сая.төг, малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр 403.3 сая.төг зарцуулагдсан байна. Мөн 2005 онд засварлсан худгийн тоо 2341, үүнээс инженерийн хийцтэй 772, энгийн уурхайн 1569, худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1713.3 сая.төг, улсын төсвийн хөрөнгөөр 387.0 сая.төг, Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 1131.7 сая.төг, малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр 194.6 сая.төг зарцуулагдсан байна.

The territory of Mongolia is divided into three large watersheds of the World namely Northern Arctic Ocean Basin, Pacific Ocean Basin, and Central Asian Internal Drainage Basin,

The total water resources in the country is 38.8 km³ and potential water resources is 34.6 km³. Surface water resources are 22.0 km³ and ground water resources are 6.6 km³. There are about 4113 rivers approximately 3500 lakes, 6898 springs including over 120 mineral water springs with medical properties and 240 glaciers with a total area of more than 500 km³. Due to the high mountain conditions of the country, almost all rivers, which are fed by abundant rainfall, run to the Arctic and Pacific Ocean basin and disappear in a short time. Most of the surface runoff flows (70%) out of the country, while a small portion flows into the Central Asian Internal Drainage Basin.

In the territory of Mongolia the distribution of the water resources is uneven. Table-1

	Name of the Ocean basin	Percentage of the territory, %	Potential Water resources, cube Km
1	Arctic ocean	20	16.9
2	Pacific ocean	12	13.9
3	Central Asian Internal Drainage Basin	68	3.8
		100	34.6

The Gobi desert and Steppe zones, cover 68 percent of the total territory of Mongolia. In these areas, rivers and streams with permanent flow are very rare. The water resources in the Gobi and steppe region are characterized by scarcity and they are also unsuitable for drinking purposes, due to high material content or hardness. It is estimated that about one third of populations live in these areas. However depending on the geographic range and water availability, rivers (which are the source of all surface water) freeze out in winter and spring time (8 months) and populations must use ground water. Ground water occurs over the entire territory of Mongolia. Groundwater is the main source for household and drinking use, watering points for animal husbandry and industrial consumption in Mongolia, while surface water is the source in summer time. Ground water is of great economic significance. Twenty

percent of Mongolian consumption is originated from surface water sources and while 80% from ground water sources.

Resource availability. On average the water available per capita on an annual basis is 14000m³. in the Gobi area it is 4500m³, and the Northern and Central areas, where the majority of lakes and river systems are concentrated, it equals to 46000m³ per capita.

Water consumption:

Water resource is widely used for water supply, industrial and agricultural purposes. Total water withdrawal for the year 2004 was approximately 0.6km³.

The following is water use by sectors: 0.24 km³ for agricultural use

0.25 km³ for industrial use

0.11 km³ for drinking and house hold use

3.2 Усны хэрэглээ:

Нэг хүнд ноогдох цэвэр усны нөөц (0.11 км³) :

Хөдөө аж ахуйн усны хэрэглээ (0.24 км³)

Үйлдвэрлэлийн усны нөөц (0.25 км³)

Монгол улсад усны үр ашиггүй хэрэглээ дэндүү их байна. Улаанбаатар хотын орон сууцны нэг оршин суугч өдөрт дунджаар 0.4 куб м гаруй ус хэрэглэдэг. Говийн бүсэд нэг хүнд ногдох усны нөөц дэлхийн дунджаас 10 дахин бага байхад ойт, хээрт 45.0-55.2 мян.шоо м байгаа нь дэлхийн дунджаас 4-5 дахин их юм.

3.3 Усны баланс. 1994 оны байдлаар манай улсын хэмжээнд усны нөөц нь хэрэглээнээс даруй 23731 сая шоо м-ээр илүү байна.

Монгол орны ус хэрэглээ

Усны нөөц R, сая м ³	Ус хэрэглээ /сая шоо м/						
	Хүн ам	Үйлдвэрлэл	Хөдөө аж ахуй	Экологийн нөөц	Усны нийт хэрэгцээ	Усны нөөц ашиглалт, хувь	Балансын зөрүү
34600	64.5	227.7	526.7	8328.8	9098.4	2.23	25477

4. Эрчим хүч

Хэрэглээ. Нар, салхины эрчим хүчний багахан хэмжээний эх үүсвэрийг эс тооцвол Монголчуудын эрчим хүчний хэрэглээний эх үүсвэр нь ойролцоогоор 5-7 сая тонн нүүрс, 1.1 сая тонн аргал, 0.7 сая тонн мод ашигласнаас бий болдог.

Эрчим хүчний бүтэц (Гвтц)

	Нүүрс	Шатахуун	Цахилгаан	Дулаан	Нийт, #	Эрчим хүч, %
Нийт	3606	4362	1907	5222	15.095	100

4.1 Нэг хүний эрчим хүчний жилийн хэрэглээ - 1311.6 кВт/цаг

Electricity generation, in coal equivalent, thous.tons

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Electricity	411.8	323.2	362.3	371.1	382.7	385.9	406.3
Heat	1279.1	976.9	984.6	943.4	982.1	1020.1	1107.8
Coal	3363.0	2394	2437.2	2416.3	2605.9	2663.1	3226.6
Total Gross Generation	5053.9	3694.1	3784.1	3730.8	3970.7	4069.1	4740.6
Percent	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Electricity	8.1	8.7	9.6	9.9	9.6	9.5	8.6
Heat	25.3	26.4	26.0	25.3	24.7	25.1	23.4
Coal	66.5	64.8	64.4	64.8	65.6	65.4	68.1

Coal equivalent coefficient for electricity 0.123, heat-0.143, brown coal-0.47

Source: Statistical year book, 2004

4.2 Нэг га-д ногдох хөдөө аж ахуйн эрчим хүчний хэрэглээ - 0.2 кВт

Үйлдвэрлэл

4.3 Шатдаг болон хог хаягдлыг оролцуулахгүйгээр сэргээгдэх эрчим хүч (0.5 хувь)

Balance of electricity, mln.kW.h

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Total	3576.0	3009.0	3127.0	3213.0	3279.0	3309.0	3474.3
Gross Generation	3348.0	2628.0	2946.0	3017.0	3111.7	3137.7	3303.4
Import	228.0	381.0	181.0	196.0	167.3	171.3	170.8
Distribution	3576.0	3009.0	3127.0	3213.0	3279.0	3309.0	3474.3
2719.0 1909.0 1910.0 1948.0							
1. Consumption, total				2031.7 2194.6 2357.0			
<i>Of wich:</i>							
Industry & construction	1803.0	1105.0	1182.0	1204.0	1260.1	1361.1	1458.8
Transport Communication	175.0	69.0	79.0	87.0	84.7	91.5	98.5
Agriculture	116.0	59.0	21.0	17.0	22.0	23.8	25.6
Communal housing	349.0	518.0	463.0	476.0	487.0	526.1	567.6
Other	276.0	158.0	165.0	164.0	177.8	192.1	206.5
Losses in transmission and distribution	323.0	502.0	576.0	603.0	582.8	489.2	480.4
Station internal use	534.0	598.0	616.0	644.0	649.0	618.4	628.8
Export	-	-	25.0	18.0	15.5	6.7	8.2

Source: Statistical year book, 2004

Сэргээгдэх- Хэрэглээ сектор тус бүрээр

4.4 Үйлдвэрлэл (Нийт сэргээгдэх хэрэглээнд эзлэх хувь)

Balance of heat /thous. G.kal/

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Gross Generation	8945.0	6831.7	6885.4	6597.2	6867.6	7133.3	7746.6
Station internal use	49.9	41.3	138.0	59.6	144.9	335.5	479.7
Consumption - Total	8895.1	6790.4	6747.4	6537.6	6722.7	6797.8	7266.9
<i>Of wich:</i>							
Industry & construction	2971.5	2708.9	2620.1	2343.7	2428.5	2288.5	2149.9
Transport	271.5	446.3	410.6	485.6	419.6	443.5	391.0

Communication							
Agriculture	344.2	146.5	33.3	36.5	36.2	40.5	77.2
Housing	1638.3	2360.6	2655.1	2990.5	2843.1	2777.2	3000.9
Others	3381.7	1110.0	794.9	562.8	841.8	1033.7	1468.3
Losses in transmission and distribution	287.9	18.1	233.4	118.5	153.5	214.4	179.6

Source: Statistical year book, 2004

4.5 Суурин газарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь, 0.3 %

Эрчим хүч

	Sources of energy	Lovered areas	Connection to int.power network	Population access to power
Central energy system	Power station 2-21.5 MW PS# 3-126 MW PS# 4-540 MW PS in Darkhan -46 MW PS-28.8 MW	UB- Arvaikheer, Bulgan, Govisumber, Darkhan, Dornogovi, Dundgovi, Orkhon, Uvurkhangai, Selenge, Tov, Khentii, Hovsgul, and their 133 Soum centers	Connected to a sub power station in Selendum, Russia with a 154 km long line of 220 kV	1650000
Western energy system	No	Uvs, Bayan-Ulgii, Khovd, and their 18 Soum centers	Connected to a subpower station in Chadan, Russia with a 101 km long line of 220 kV	250000
Eastern energy system	Power station in Dornod-36 MW	Dornod and Sukhbaatar and their 8 soums	No	110000
Others	PS in Dalanzadgad 6 MW Diesel generator in Aimag centers 26.7 MW DG in Soum centers 29.5 MW Six hydro-power stations-3.5 MW Renewable sources of energy (solar and wind panel 400 km) Electricity generators used by household including herder household in rural area	Umnugovi, Bayankhongor, Govi-Altai and Zavkhan -151 soum centers 50000 herder	No	250000 families

4.6 Хөдөө аж ахуйд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 0.2%

Dynamics of Energy Supplies for Herder Communities

(Numbers of households in thousand)

Households have	2001	2002	2003	2004
Generators	24.8	24.7	28.9	53.7
Of wich: Solar panels		18.8		
Wind faus		3.5		
Motors (operates with benzin)		2.4		

Some relevant data from the program on the improvement of energy Supply in soums and other Settled areas

	2000	2005
Numbers of Soums and settled areas that have access to central energy system	136	188
Numbers of Soums and settled areas that have no access to central energy system	186	134
Of them: the soums and settled areas with renewable energy sources	0	4*

*-Solar – wind –water- diosel combined.

5. Газрын элэгдэл

Газрын элэгдэл

Газрын элэгдлийн хэлбэр	1990-1999		2000-2005	
	Сая га	Нийт газрын эзлэх хувь	Сая га	Нийт газрын эзлэх хувь
Усаар угаагдсан	21.8	14.0	21.8	14.0
Салхиар хийссэн	7.8	5.0	12.5	8.0
Ус ба салхиар	91.6	58.6	93.8	60.0
Техникээр	2.0	1.2	3.0	1.9

Монгол орны газрын элэгдэл эвдрэлийн зэрэг өндөр байна. Сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байна. Ялангуяа хөрс салхиар хийсэх хувь хэмжээ өсч, зэрэглэл гүнзгийрсэн. Хөрсний элэгдэл эвдрэлийн үндсэн шалтгаанаар газар тариалангийн үйлдвэрлэл уналтанд орлоо. Мөн техникийн буюу уул уурхайн газрын элэгдэл эвдрэл их нэмэгдлээ. Засгийн газар 2006 оныг хаягдсан тариалангийн талбай ба уурхайлсан газрыг нөхөн сэргээх жил болгоод ажиллаж байна.

6. Нөхөн сэргээлт

Ойг нөхөн сэргээх арга хэмжээнд улсын төсвөөс жил бүр 219.5 сая төгрөг зарцуулж байна. Жилдээ 32 сая ш суулгац бэлтгэж байна. 2005 онд 4491.2 га талбайд ойн нөхөн сэргээх ажил гүйцэтгэснээс 1751 га талбайд улсын төсвийн хөрөнгөөр, 756.7 га талбайд орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 823 га талбайд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр, 1155.5 га талбайд Солонгос улсын Ойн чуулга, Монголын ойн чуулгын тусламжийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр хийлээ. Жилд мод, сөөгний 1.4 тн үр, 31.2 сая ширхэг тарьц суулгацын нөөц бүртгэгддэг байна. Засгийн газар 2004 оноос “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Ж илд 353.5 га талбайд хашаа хамгаалалттай, усалгаатай ойн зурвас байгуулж, үүнд 25400 ш хайлас, 18000 ш чацаргана, 35000 ш шар хуайс, 37000 ш улиас, бургас, 4500 ш үхрийн нүдний суулгац зэрэг нийт дүнгээр 187.0 мянган га орчим суулгац тарьж, 40 орчим гар худаг гарган аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хариуцуулж, усалгаа, тордолт хийсэн ба амьдралт нь 75.0 хувьтай

байна. Өмнөговь, Сэлэнгэ аймагт 600 га ойжуулалт, БНСУ-ын Ротари клубын ойн чуулган төрийн бус байууллагын тусламжаар 130 га-д ногоон зурвас байгуулж хамгаалалтын хашаа барьж гүний худаг гарган 200 га-д ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхэд 400.0 мянга орчим ам.долларын санхүүжилт авав.

Ойг нөхөн сэргээсэн талбай, га

Он	1999	2000	2001	2002	2003	2004
Ойн нөхөн сэргээлт, га	5005	9030	8000	8275	9036	9755

Ойг нөхөн сэргээх ажлын арга хэмжээг 1999 оныг 2003 онтой харьцуулан үзэхэд 1.8 дахин өссөн байна

Нөхөн сэргээлт ба хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилт

Нөхөн сэргээгдэж буй газар	1990-1999	2000-2005
Тариалангийн газрын нөхөн сэргээлт (км ²)	2000	3000
Талхлагдсан бэлчээрийн нөхөн сэргээлт (км ²)	50000	97000

Тариалангийн ба тариажуулж хаягдсан мөн талхлагдсан бэлчээрийн газрыг нөхөн сэргээх ажлын хэмжээ сүүлийн 5 жилд хаьцангуй их байгаа. Ялангуяа олон наст өвс тариалах, бэлчээрийг хашиж хамгаалах ба өнжөөх ажилд анхаарал тавьж байна.

(XII) Цөлжилт болон гантай холбоотой нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд

1. Хүн ам, эдийн засгийн байдал

Хүн ам: Монгол улсын хүн ам тооны хувьд өсч байгаа хэдий ч жилийн дундаж өсөлтийн хурд жилээс жилд саарч байна. Нийт хүн амын тоо 2004 оны жилийн эцсийн байдлаар 2533.1 мянга болж, 2003 оноос 1.2 хувиар буюу 29.1 мянган хүнээр өслөө. Нийт хүн амын 49.6 хувийг эрэгтэйчүүд, 50.4 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. 100 эмэгтэй дутамд 98.5 эрэгтэй ногдож байна. 2004 онд нийт хүн амын 59.1 хувь буюу 1498.2 мянга нь хотод амьдарч байна. 2004 оны байдлаар 596.4 мянган өрхийн 57.2 хувь нь хотынх, 42.8 хувь нь хөдөөгийнх байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 4.2 хүн ногдож байна. 1000 хүн амд ногдох төрөлт 2001 онд 20.5 байсан бол 2004 онд 18.1 болж, 2001 оны түвшингээс 11.7 хувиар буурлаа. 2004 онд нийт төрсөн хүүхдийн тоо 2001 оныхоос 8.4 хувиар, 2003 оныхоос 0.5 хувиар тус тус буурчээ. Зөвхөн сүүлийн 4 жилд хүн амын тоо 4.0 хувиар өссөн байна.

Үзүүлэлтүүд	Хүн ам (мян.хүн)			
	2001 он	2002 он	2003 он	2004 он
Бүгд	2442.5	2475.4	2504.0	2533.1
Хотын	1397.1	1421.0	1464.2	1498.2
Хөдөөгийн	1045.4	1054.4	1039.8	1034.9

1.2 Хүн амын өсөлт (жилийн өсөлтийн хувь) -1.5 %. Хүн амын цэвэр өсөлт буурч байгаа нь хүн амын өсөлтийн хурдац буурахад гол нөлөө үзүүлсээр байна.

1.3 Төрөлт (жилээр)**Төрөлт, нас баралт**

Он	Төрөлт	Төрөлт, нас баралт	
		Нас баралт	
2001	20.5	6.6	
2002	19.1	6.4	
2003	18.4	6.4	
2004	18.1	6.5	

1.4 Хүүхдийн эндэгдэл: (1000 төрөлт тутам)

Он	Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл
2001	29.5
2002	29.6
2003	23.0
2004	22.3

1.5 ҮНБ (ам доллараар): Дотоодын нийт бүтээгдэхүүн:

2004 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай орны дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) оны үнээр 1808.0 тэрбум төгрөг (1495.4 сая ам.доллар), 2000 оны зэрэгцүүлэх үнээр 1250.0 тэрбум төгрөг (1033.9 сая ам.доллар) болж, 2003 онтой харьцуулахад 10.6 хувь буюу 119.7 тэрбум төгрөгөөр (99.0 сая ам.доллар) өссөн. Энэ өсөлтөнд малын тоо 2003 оныхоос 2.5 сая толгойгоор нэмэгдсэн, Канадын хөрөнгө оруулалттай "Бороо Гоулд" алтны үйлдвэр 2004 онд ашиглалтанд орж үйл ажиллагаа явуулан ихээхэн хэмжээний алт олборлосон зэрэг нь голлон нөлөөллөө. 10.6 хувийн өсөлтийн 4.5 нэгжийг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар, 4.2 нэгжийг үйлдвэрлэлийн салбар, 1.9 нэгжийг үйлчилгээний салбар тус тус хангасан байна. Нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 717.3 мянган (593.3 ам.доллар) төгрөгт хүрч, 2003 оныхоос 130.6 мянган төгрөгөөр нэмэгдлээ.

1.6 Нэг хүнд ногдох ҮНО (сая төгрөг)**Үндэсний нийт орлого**

Он	2001	2002	2003	2004
Оны үнээр				
ҮНО, сая төг	1147363.2	1307297.4	1533170.1	1968223.6
1 хүнд ногдох, төг	473136.3	531637.8	615681.5	780917.1
1 хүнд ногдох ҮНО, Дэлхийн 1 хүнд ногдох ҮНО, ам.доллар	398	446	510	554

Гадаад валютын зах зээлийн ханш

/төг/

Гадаад валютын ханш, жилийн эцэст	2001	2002	2003	2004
АНУ-ын доллар	1102.00	1125.00	1168.00	1209.00
АНУ-ын долларын жилийн дундаж	1097.64	1110.35	1146.51	1185.19
Евро	973.60	1169.40	1460.20	1647.40
Рубль	36.20	35.40	39.90	43.40
Юань	133.10	135.90	141.10	146.10
Вон	0.83	0.94	0.98	1.16
Иен	8.39	9.39	10.92	11.65
Фунт	1598.60	1804.00	2073.40	2320.90

1.7 Үр тарианы үйлдвэрлэл (тонн) - 1 жилд дунджаар 138 мянган тонн**1.8 Мал аж ахуйн үйлдвэрлэл (тонн)**

ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, / мян.тн/


№	Бүтээгдэхүүн	2001	2002	2003	2004
1	Мал нядалгааны жингээр	226.4	204.4	153.4	199.3
2	Арьс, шир, мян.ш	10841.9	8409.6	6134.4	6635.8
3	Хонины ноос	19.8	17.0	15.2	15.3
4	Ноолуур	3.1	2.9	2.7	3.2
5	Сүү	290.3	276.6	292.4	382.6
6	Өндөг, сая ш	7.7	4.2	7.1	16.0

2. Хүний хөгжил:**Хүний хөгжил: Хүний хөгжлийн хэмжигдэхүүнүүд**

1990 оноос хойш Монгол улсад хүн ам зүйд ихээхэн өөрчлөлт гарч байна. Тус улсын эдийн засгийн салбарын идэвхитэй хүн ам насны хувьд харьцангуй залуу юм. 2002 оны эцэст бүртгэгдсэн 2.5 сая орчим хүн амын 38.0 хувь нь 16-аас доош насныхан, 55.0 хувь нь хөдөлмөрийн насныхан байлаа. Төрөлтийн нийлбэр коэффициент 1989 онд 1000 хүн ам тутамд ногдох төрөлт 36.5 хүрч байсан бол 2004 онд 20.6 хүртэл буурчээ.

Монгол улсын хүний хөгжлийн индекс

Он	Дундаж наслалт (жилээр)	Насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдал (15-аас дээш насныхан, %)	Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин	Нэг хүнд ногдох ДНБ (PPP-ам.доллар)	Дундаж наслалтын индекс	Боловсролын индекс	ДНБ-ний индекс	Хүний хөгжлийн индекс
1990	63.7	96.5	60.4	1640	0.645	0.845	0.467	0.652
1992	62.8	97.7	54.3	1266	0.638	0.824	0.424	0.626
1995	63.8	98.9	57.0	1267	0.647	0.849	0.424	0.635
1998	65.1	96.5	62.0	1356	0.669	0.850	0.435	0.651
1999	63.2	97.8	66.0	1707	0.636	0.872	0.472	0.661
2000	63.2	97.8	69.6	1838	0.636	0.884	0.486	0.669
2001	63.4	97.8	69.6	1968	0.639	0.884	0.497	0.674
2002	63.5	97.8	69.7	2125	0.642	0.884	0.510	0.679



3. Шинжлэх ухаан, технологи

3.1 Цөлжилттэй холбоотой шинжлэх ухааны байгууллагуудын тоо
(Нийт тоо - 12)

4. Мэдээллийн эх үүсвэрийг оруулах
<ol style="list-style-type: none">1. УЦУурын Үндэсний сүлжээ2. NOAA- хиймэл дагуулын мэдээ3. Суурин болон явуут судалгааны материал4. Үндэсний статистикийн газрын мэдээ5. Эрдэм шинжилгээний бүтээлүүд (тайлан, илтгэл)6. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт7. Монголын хүний хөгжлийн илтгэл